



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх , эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(22 дахь жилдээ)

2023/01

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрд”

(22 дахь жилдээ)

2023/01

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл

2023/01(61)

Улсын бүртгэлийн дугаар 244

22 дахь жилдээ

Дугаарыг эрхлэн гаргасан:

- | | |
|-----------|---|
| Б.Энхболд | Ерөнхий редактор (Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн,
Хууль зүйн ухааны доктор, дэд профессор) |
| Х.Цэцгээ | Нарийн бичгийн дарга (Хүний эрхийн Үндэсний Комиссын
Хүний эрхийн сургалт, сурталчилгааны хэлтсийн ахлах референт) |

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ISSN:2617-927X

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ*А.Доржсүрэн*

Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт,
тулгамдаж буй зарим асуудал 5

Д.Мягмарсүрэн, Г.Цэцэгмаа

“Сурч боловсрох эрх:
Чанар, хүртээмжийг сайжруулах нь” 14

Г.Гантөмөр

Бүх насаар хорих ялын олон улсын
эрх зүйн зохицуулалт..... 29

Б.Янжмаа

Цахим орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал 36

Н.Одонтуул

Гадаадын зарим улсын эрүүгийн хуульд эмнэлгийн
чанартай албадлагын арга хэмжээг хуульчилсан байдал,
харьцуулсан судалгаа 49

С.Ганцэцэг

Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд
тулгарч буй зарим асуудал..... 84

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА*Фернанда Пирие*

Эрх зүйн антропологи.
Дэг журам, маргаан ба эрх зүйн олон ургалч 91

ЗОЧНЫ ЯРИЛЦЛАГА*Г.Уранцоож*

Иргэдийн оролцооны идэвх нэмэгдэхийн хэрээр
шударга ёсны үнэлэмж нэмэгдэж, дагаад өөрсдөө
шударга ёсыг сахих, хэрэгжүүлэх чадамжтай болдог..... 107

CONTENT

ARTICLES

- Dorjsuren.A*
Legal regulation of inheritance and some
pressing issues in inheritance 5
- Myagmarsuren.D., Tsetsegmaa.G*
“The right to education: Taking seriously the
improvement of the access to quality education” 14
- Gantumur.G*
The penalty of life imprisonment under international law 29
- Yanjmaa.B*
Rights of the Child and Child Protection in the
Digital Environment..... 36
- Odontuul.N*
Application and criminalization of medical coercive
measures and the limits of criminal codes of some countries:
Comparative study..... 49
- Gantsetseg.S*
Some challenges facing the implementation of the
Labour Law of Mongolia 84

ONLY IN MONGOLIAN

- Fernanda Pirie*
Order, Disputes, and Legal Pluralism,
The Anthropology of Law, 2013..... 91

GUEST INTERVIEW

- Urantsooj.G*
Potential of civic participation advances the value of
justice, and as a result, citizens become capable of
upholding and realizing the justice..... 107



А.ДОРЖСҮРЭН

Эрх зүйч, судлаач

ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

LEGAL REGULATION OF INHERITANCE AND SOME PRESSING ISSUES IN INHERITANCE

Хураангуй: Энэхүү судалгааны ажлын хүрээнд өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт, түүнд тулгамдаж буй зарим асуудлыг хөндөнө. Учир нь Монгол Улсын Иргэний хуулиар заавал өвлөгч субъектийн эрх зүйн байдлыг тодорхойлохдоо хууль ёсны болон хууль ёсны бус өвлөгчийг ялгаатай байдлаар тогтоож, улмаар уг харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл байдал хүрч байна. Иймд судлаачийн зүгээс онолын болон практик судалгааг хийж, тодорхой саналыг дэвшүүлсэн болно.

Abstract: In the framework of this research work, the legal regulation of inheritance and some of its problems will be discussed. This is because the Civil Law of Mongolia determines the legal status of the subject of obligatory inheritance by differentiating legitimate heirs and illegal heirs, and thus the rights and legal interests of the participants in the relationship are violated. Therefore, the researcher conducted theoretical and practical research and put forward specific proposals.

Түлхүүр үг: Өв залгамжлал, өвлөгч, гэрээслэл, өв шилжих, өв хүлээн авах, өвлүүлэгч.

Keywords: Inheritance, heres, testamentum, succession transmission, acceptance of inheritense, testator;

I. УДИРТГАЛ

Өв залгамжлалын эрх зүйн асуудал бол эрх зүйн зохицуулалтын хүрээнд төдийгүй эдийн засгийн хүрээний маш өргөн агуулга бүхий харилцаа юм. Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд өв залгамжлалын маргаан ихээр гарах болсон нь цаашид энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Хүний мөн чанартай шууд холбоотой хүнтэй хамт байдаг хууль тогтоомжоор зайлшгүй хамгаалагдсан байх ёстой үндсэн эрх бол өмчлөх эрх гэдгийг нэрт сэтгэгчид болох Ж.Локк, Гегель нар хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүнтэй нягт холбогддог өв залгамжлуулах эрх Монгол Улсын Үндсэн хуулиар энэхүү эрхийг хамгаалсан байна. Уг эрхийг хэрэгжилтийг хангах гол баталгаа бол Иргэний хууль бөгөөд уг хуулиар заавал өвлөгчийн талаар тусгасан байдаг.

Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.3-д “Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр (эхнэр), төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ. Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох хэсгийг оролцуулан тооцно” гэж заасан байна. Эндээс үзвэл гэрээслэгч буюу өвлүүлэгч нь зөвхөн хууль ёсны бус өвлөгчид өөрийн бүх хөрөнгөө өвлөсөн тохиолдолд заавал өвлөгчид тухайн хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлэхээр байна. Гэтэл гэрээслэгч буюу өвлүүлэгч нь хууль ёсны бус өвлөгчид биш харин Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.2-д заасан “нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ” гэх мэт хууль ёсны өвлөгчид өөрийн бүх хөрөнгийг гэрээсэлсэн тохиолдолд заавал өвлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байх тул уг асуудлыг судалж, шийдвэрлэх арга замыг илэрхийлэхийг зорьсон болно.

II. ҮНДСЭН ХЭСЭГ, ОНОЛЫН СУДАЛГАА

Өв залгамжлалын эрх зүйн асуудал нь өмчлөх эрхтэй шууд холбогдох бөгөөд өмчлөх эрх нь хууль ёсоор эзэмшиж байгаа эд хөрөнгийн хувь заяаг хэнээс ч асуухгүйгээр шийдвэрлэх эрх ба үүнийг бусад хүн хүндэтгэн зөвшөөрөх, түүнийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх туйлын эрх¹ билээ.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй,

Өнөөдрийн бий болсон чөлөөт нийгмийн дэвшилтэт үзэл санааны үндсийг² тогтоосон агуу сэтгэгч Ж.Локк³ хүнээс өөрөөс нь салгаж болохгүй үндсэн эрхэд “амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх⁴” гэсэн эрхийг хамааруулж байсан бол Гегель “хувийн өмч⁵ бол нийгэм эдийн засгийн шударга ёсны илэрхийлэл бөгөөд гол хэмжүүр” гэж үзсэн байдаг нь хүний эрхийн үндсийн үндэс⁶ болсон өмчлөх эрхийн ач холбогдлыг харуулж байна. Өөрөөр хэлбэл Аристотелийн үзсэнчлэн өмч бол хүний өөртөө хайртай байх мөн чанараас урган гардаг гэдэг утгаараа хүний салшгүй эрх⁷ юм. Хүний хувийн өмчийг хамгаалах эрхийн үзэл санаа Английн 1215 оны Магна хартын 39 дүгээр зүйл⁸ болон Францын 1789 оны Хүний ба иргэний эрхийн тунхгийн 17 дугаар зүйлээр⁹ тус тус баталгаажин хөгжсөн байдаг. Эрх зүйн онолч Л.Харт ашиг сонирхлын болон сонголтын онолын хүрээнд тайлбарлахдаа “Өмчлөх эрх нь хүний чөлөөтэй сонголт хийх эрх, ашиг сонирхлын хамгаалдаг амин чухал эрх болох нь тодорхой бөгөөд амьд явах үндсэн эрх нь бүх эрхийн үндэс болдгийн адил өмчлөх эрх нь эргээд амьд явах эрхийн цорын ганц хэрэгжилт болдог” үүнийг бусад сэтгэгчид ч “өмчлөх эрх хангагдахгүйгээр бусад эрх хангагдахгүй, хүн өөрийн амьдралыг өөрийн хүчээр авч явах ёстой болохоор тэрхүү хүчин зүтгэлийг гаргах эрхгүй болох аваас амьдралаа тэжээн тэтгэх боломжгүй болно¹⁰” гэж оновчтой тайлбарласан байдаг.

Энэхүү эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулснаар хүн хувийн өмчтэй¹¹ байж, түүгээрээ ашгийн төлөө болон ашгийн бус үйл ажиллагаа явуулж, олсон орлогоороо бизнесээ өргөжүүлэх, хэрэгцээгээ хангахад зарцуулах бололцоотой болж бидний байгуулахаар зорьж буй иргэний нийгмийн бие даасан субъект нь нийгмээ өөрсдөө авч явах бололцоо бүрдэх юм. Монгол Улсын хувьд Үндсэн хуулиар хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураан авахын хориглоно¹² гэж заасан байдаг. Үүнээс бид ***өв залгамжлуулах эрх бол өмчлөх эрхийн нэг салшгүй хэсэг төдийгүй***

хэрэгжилт, УБ., 2017., 239 дэх тал.

² Платон Төр зохиолдоо “Ухаант иргэдийн тогтоох ёстой тэрхүү шударга ёсны үнэлэмжийн илрэн гарах нэг хэлбэр нь өмч” хэмээн бичсэн байдаг бол

³ Ж.Локк Өмчлөх эрхийг хамгаалах хамгийн чухал арга бол түүнийг хуульчлах гэсэн байдаг.

⁴ Ж.Локк., Избранные Философские Произведения., Т.2.М., 1960., С.8.

⁵ John G. Sparkling, Understanding Property Law, Lexus Nexis, 2012, P 13 “Өмч гэдэг нь нийгэмд материаллаг баялгийг олж авах хэлбэр, нөгөө талаас өмч нь эдийн засгийн категорин хувьд оршин тогтнодоггүй харин зөвхөн эрх зүйн категорин хувьд яригдаж болно”.

⁶ Т.Саруул., Эрх зүй хэрэглэх арга зүй., УБ., 2014., 21 дэх тал.

⁷ Аристотель “Өмчлөх эрх нь хүний өөртөө хайртай байх мөн чанартай шууд холбоотой” гэж үзсэн.

⁸ Чөлөөт иргэнийг хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульгүйгээр өмч хөрөнгийг нь булааж болохгүй гэж Магна хартад заасан.

⁹ Иргэний ба улс төрийн эрхийн тунхагт “Өмчлөх эрх нь хүний салшгүй эрх бөгөөд нийтийн хэрэгцээнд хуульд заасан үндэслэлгүйгээр, урьдчилсан шударга нөхөн олговоргүйгээр хураан авч болохгүй” гэж заасан байдаг.

¹⁰ Эйн Рэнд., Капитализмыг өмөөрөх нь: Эдмон хэвлэлийн газар., 2005

¹¹ Доктор, профессор О.Жамбалдорж, О.Амарсайхан, Ж.Ариунзаяа., Монгол Улсын Иргэний эрх зүй., УБ., 2006., 17 дахь тал.

¹² Н.Лүндэндорж., Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар., УБ., 2022

хамгийн чухал эрх гэдгийг харж болно. Нэрт сэтгэгч Ж.Локк “өмчлөх эрхийг хамгаалах хамгийн чухал арга бол хуульчлах” хэмээн өөрийн бүтээлдээ дурдсан байдаг. Тэгвэл Үндсэн хуульд тусгагдсан уг эрхийг материаллаг хууль тогтоомжоор хэрхэн хамгаалсныг судлан үзэж, алдарт Философич Ш.Л.Монтескье “хууль нийгмийн хэрэгцээ шаардлага, бодит амьдралд үндэслээгүй бол хүн ардад үйлчлэхгүйгээс гадна хор хохирол авч ирнэ” гэж өөрийн бүтээлдээ дурдсан байдагчлан хүний салшгүй эрхийн нэг хэсэг болсон өв залгамжлалын эрх зүйн зохицуулалтын хийдлийг судлан асуудалд дүн шинжилгээ хийх замаар боловсронгуй болгох санал дэвшүүлэх нь чухал юм.

III. ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын Иргэний хуулиар өв залгамжлалын эрх зүйн асуудлыг зохицуулдаг бөгөөд өв залгамжлал эрх зүй нь өөрийн гэсэн өвөрмөц зохицуулалт бүхий иргэний эрх зүйн харилцаа бөгөөд энэ нь иргэний өмчлөх эрх, түүнээс улбаалан гарах бусад эрхийн асуудалтай нягт холбогдсон харилцаа бөгөөд өв залгамжлал нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч бүхий л этгээдэд хамаарах ойлголт биш харин иргэн хүний хувьд хамаарах хууль зүйн дагуу хийх үйлдэл юм¹³. Уг ойлголтыг нэр томъёоны хувьд авч үзвэл Манай улсын нэрт эрдэмтэн хууль зүйн ухааны доктор, профессор С.Нарангэрэл “Өв залгамжлалыг нас барагчийн (өвлүүлэгчийн) эрх ба үүрэг түүний өвлөгчид шилжих үйлдэл¹⁴” гэж тодорхойлсон байдаг бөгөөд Эрх зүйн харилцаанд оролцогч өмчлөгч иргэний хувьд өөрийн өмчлөх эрхээ бусдад өв залгамжлуулахдаа хууль ёсоор, эсхүл гэрээслэлээр шилжүүлж болдог¹⁵. Профессор Лаврансе Фридман (Lawrence M.Friedman) хууль ёсны өвлөгчид болон нас барагчийн гэр бүлийн гишүүдтэй нарийн холбогддог утгаараа хууль ёсны өв залгамжлалын үндсэн зарчим¹⁶ тодорхойлогддог бол өв залгамжлалын эрх зүй дэх бэлэглэлийн зарчим сайн дурын хүсэл зориг давамгайлдаг учраас чөлөөт зах зээлийн эдийн засагтай нийцдэг гэсэн утгаараа гэрээслэлийн чөлөөт байдлын зарчим тодорхойлогддог гэсэн байдаг.

Орчин үед хууль ёсны өв залгамжлалын үзэл санааг эсэргүүцэх болсон бөгөөд “нэг талаас үр хүүхдүүд нь өөрсдийн амьдралын гараагаа эхлүүлэхдээ эцэг эхээсээ эд хөрөнгө авах нь зүй ёсны зүйл гэж үздэг хууль ёсны өв залгамжлал нь нийгмийн хуучинсаг үзэл санаанд тулгуурласан нөгөө талаас хүмүүсийн дундаж наслалт эрс нэмэгдэж, хүүхдүүд аль хэдийнээ өөрийн баялгийг

¹³ Legaldata.mn В.Оюумаа., Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд нотариатчийн гүйцэтгэх үүрэг, УБ., 2007., Нийтлэл.

¹⁴ С.Нарангэрэл., Монголын эрх зүйн эх толь бичиг, УБ., 2015., 331 дэх тал.

¹⁵ Legaldata.mn В.Оюумаа., Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд нотариатчийн гүйцэтгэх үүрэг, УБ., 2007., Нийтлэл.

¹⁶ Alexandra Braun and Anne Rochell, Passing Wealth on Death, Oregon Hart Publishing, 2016, P.9

бүтээчихсэн үедээ эцэг эхийнхээ хөрөнгийг өвлөж авдаг” энэ үүднээс яагаад нас барсан хүн өөрийн бүх хөрөнгийг чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй байх хэрэгтэй гэж гэсэн асуулт нь гэрээслэлийн чөлөөт байдлын зарчмын суурь¹⁷ болж байна. Ийм ч учраас нийтлэг эрх зүйн хэм хэмжээнд эд хөрөнгө өвлүүлэх эсэхийг өөрийн үзэмжээр шийдвэрлэх буюу шууд өвлөх хүрээг багасгах хандлагатай¹⁸ байна. Үүнээс үүдэн Зарим улс оронд гэрээслэлийг бүрэн, хэсэгчилсэн, нэрлэсэн гэсэн гурван төрөлтэй байхаар нэг бүрчлэн хуульчилсан¹⁹ байдаг. Монгол Улсын хувьд гэрээслэлийн чөлөөт байдлын зарчмын үндсийг тогтоосон²⁰ хэдий ч “өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх” зэрэг хүмүүс нь заавал өвлөгч²¹ байхаар хуульчлагдсан байдаг. Өөрөөр хэлбэл өвлүүлэгч нь өөрийн бүх хөрөнгийг хууль ёсны бус өвлөгчид гэрээслэлээр өвлөсөн тохиолдолд дээр дурдсан этгээдүүд тухайн хөрөнгөөс заавал авах эрхтэй гэсэн агуулгаар хууль ёсны өвлөгчдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор гэрээслэлийн чөлөөт байдлын зарчимд хязгаарлалт тогтоосон²² байдаг. Профессор Жон Лангбены үзсэнчлэн гэрээслэл нь эдийн засгийн чухал баримт бичиг болохын гэрээслэлийн түүний чөлөөт байдлын зарчимд тавьж буй хязгаарлалт²³ зайлшгүй судлах чухал асуудал болоод байна.

Асуудал дэвшүүлэх нь: Монгол Улсын Их хурлаас 2002 онд баталсан Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1-д “Дор дурдсан этгээдийг хууль ёсны өвлөгч гэх бөгөөд тэдгээр нь адил хэмжээгээр өвлөх эрхтэй”

1. Нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх;
2. Дээр дурдсан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ хэмээн хууль ёсны өвлөгчдийг нэрлэн зааж, өвлөх эрхийн дарааллыг тогтоож өгсөн²⁴.

Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.3-д “Гэрээслэгч бүх эд хөрөнгөө **хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх** тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр (эхнэр), төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, **хууль ёсны бусад**

¹⁷ С.Должин., Харьцуулсан хувийн эрх зүй судлал., УБ., 2018., 186 дахь тал.

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ French, Civil Law, 1804

²⁰ Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.1 дэх заалт.

²¹ Т.Мөнхжаргал., Өв залгамжлалын эрх зүй., УБ., 2009., 56 дахь тал.

²² С.Должин., Харьцуулсан хувийн эрх зүй судлал., УБ., 2018., 187-188 дахь тал.

²³ С.Должин., Харьцуулсан хувийн эрх зүй судлал., УБ., 2018., 187-188 дахь тал.

²⁴ Ё.Каюот, Э.Шпанглер, Р.Хелмхаген, Д.Наранчимэг нар., Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар), УБ., 2022., 934 дэх тал.

өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ. Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох хэсгийг оролцуулан тооцно²⁵ гэж заасан байна. Эндээс үзвэл гэрээслэгч буюу өвлүүлэгч нь зөвхөн **хууль ёсны бус өвлөгчид** өөрийн бүх хөрөнгөө өвлөсөн тохиолдолд заавал өвлөгчид тухайн хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлэхээр байна

Гэтэл гэрээслэгч буюу өвлүүлэгч нь хууль ёсны бус өвлөгчид биш харин Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.2-д заасан “нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ” гэх мэт хууль ёсны өвлөгчид өөрийн бүх хөрөнгийг гэрээсэлсэн тохиолдолд заавал өвлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байна. Өөрөөр хэлбэл гэрээслэгч нь хууль ёсны өвлөгч (нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ)-д өөрийн бүх хөрөнгийг өвлөсөн тохиолдолд заавал өвлөгч хохирч үлдэх, улмаас заавал өвлөгчийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол ноцтойгоор зөрчигдөх, бүрэн хамгаалагдахгүй байх эрсдэл бий болж байна.

Энэ талаар **түүхэн талаас нь судлан үзвэл:** 1963 оны Иргэний хуульд 1993 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөд энэ зохицуулалт агуулгаараа тусгагдсан²⁶ байдаг бөгөөд гэрээслэлд хэн гэж зааснаас үл хамааран тухайн эд хөрөнгийн 2/3-ийг шилжүүлэн авахаар тусгагдсан²⁷ байна.

Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаа: Сүүлийн жилүүдэд өв залгамжлалын эрх зүйн маргаан улам бүр нэмэгдэх хандлагатай болж байгаа бөгөөд Shuukh.mn сайтаас 2022-2023 оны өвлөх маргаантай холбоотой шүүхийн шийдвэр гэсэн агуулгаар хайлт хийхэд нийтдээ 9 шийдвэр байна. Монгол Улсын Шүүхээр 2015 оны 03 дугаар сараас 2019 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд шийдвэрлэгдсэн нийт маргааны 10,000 хэрэг тутмын 5 нь өвлөх харилцаатай холбоотой байна. Тус маргааныг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг үзвэл 12 нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 5 маргаанд хууль ёсны өвлөгч болохыг тогтоож, 1 маргаанд өв хүлээн авах хугацааг сэргээж шийдвэрлэсэн²⁸ байна. Мөн Shuukh.mn сайтаас Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн өвлөх маргааныг шийдвэрлэсэн байдлыг судалж, гэрээслэл гэсэн түлхүүр үгээр хайхад нийтдээ 25 илэрц гарч байна. Уг 25 шийдвэртэй танилцахад уг асуудалтай ойролцоо төрлийн 2 маргаан байна.

²⁵ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн., Иргэний хэргийн Шүүхийн Шүүгчдийн сургалтын гарын авлагын эмхэтгэл., УБ., 2022 он., 736-737 дахь тал.

²⁶ 1963 оны Иргэний хуулийн 368 дугаар зүйлийн 368.4 дэх заалт “Өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй түүнчлэн амьд байхад нь олоод нас барахад нь төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, хүүхэд, төрүүлсэн ба үрчилсэн эцэг эх, бусад этгээд энэ зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг үл харгалзан хуульд зааснаас өөрт ногдох хэсгийн гуравны хоёроос багагүй хэсгийг өвлөнө. Ийнхүү заавал өвлөх хөрөнгийн хэмжээг тодорхойлохдоо гэрийн ердийн эд хогшлын үнэ, өвлүүлэгчийн банканд хадгалуулсан хадгаламжийг оруулан тооцно.

²⁷ З.Сүхбаатар. А.Доржготов нар., Монгол Улсын Иргэний хууль холбогдох баримт бичиг (1993-1995)., 2018., 243-244 дэх тал.

²⁸ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн., УБ., 2018

№	Маргаан 1 ²⁹ .	Маргаан 2 ³⁰ .
Шийдвэрийн дугаар	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 184/ШШ2023/00769 дугаар шийдвэр	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 181/ШШ2017/01949 дугаар шийдвэр
Маргааны агуулга	“Өвлүүлэгч нь өөрийн хөрөнгийг хууль ёсны бус этгээдэд гэрээсэлсэн бөгөөд улмаар хууль ёсны өвлөгч нь өвлүүлэгчийн эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгохоор шүүхэд хандаж, шүүхээс Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг өвлүүлэх боловч нэхэмжлэгч Д нь насан хүрсэн, хөдөлмөрийн чадвартай этгээд тул нэхэмжлэх эрхгүй, мөн өвлүүлэгчийн бусад хөрөнгө болох хадгаламж нь хууль ёсны өвлөгч болох Д-д өвлөгдөх учир уг нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй байна”. Улмаар өвлүүлэгчийн үлдсэн эд хөрөнгө болох хадгаламжийн дэвтрийг гаргаж өгөхийг даалгаж шийдвэрлэсэн.	“Өвлүүлэгч Ү.Д нь өөрийн хөрөнгийг зээ хүүхдүүд болох Б.Э, Ц.Э нарт өвлүүлэхээр гэрээслэл бичсэн боловч, Иргэний хуулийн 525 дугаар зүйлд заасны дагуу гэрээслэлээ цуцалсан байдаг. Ингээд өөрийн отгон дүүгийн хүүхэд болох Б.С-д өөрийн бүх хөрөнгийг өвлүүлэхээр гэрээслэл үлдээсэн байдаг. Учир нь Ү.Д-ийн эхнэр нас барсны дараа түүний дагавар хүүхдүүд асран хамгаалахаас татгалзаж, улмаас Б.С асран хамгаалах болж, тэрээр Б.С-д бүх хөрөнгөө гэрээсэлсэн. Гэвч хууль ёсны өв залгамжлагч болох дагавар охин Д.А нь Б.С-д олгосон өв залгамжлалын гэрчилгээ болон гэрээслэлийг хүчингүйд тооцуулахаар шүүхэд хандсан байдаг. Өвийн зүйл болох уг эд хөрөнгө нь Ү.Д болон түүний зээ охин Т.Ц-ийн нэр дээр байдаг бөгөөд өвийн тодорхой хэсгийг гэрээслэлээр Б.С-д өгсөн” шүүхээс гэрээслэлийг хүчин төгөлдөр гэж үзэж, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Дээр дурдсан маргааны хувьд өвлүүлэгч нь гэрээслэлийн чөлөөт байдлын зарчмын хүрээнд өөрийн хөрөнгийг хууль ёсны бус этгээдэд өвлүүлсэн байх бөгөөд улмаар заавал өвлөгчийн эрх зүйн асуудал хөндөгдөж, нэхэмжлэгчид нь Иргэний хуульд заасан заавал өвлөгчид хамаарахгүй байгаа тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Мөн өөрийн бүх хөрөнгийг бус зарим хөрөнгийг өвлөсөн тул үлдсэн хөрөнгийг хууль ёсны өвлөгчид олгож шийдвэрлэжээ.

Монгол Улсын Иргэний хуульд заасан гэрээслэлийн чөлөөт байдлын зарчимд тавьж буй хязгаарлалт нь үндэслэлтэй хэдий боловч өвлүүлэгч нь хууль ёсны өвлөгчид хөрөнгөө өвлүүлэх тохиолдолд заавал өвлөгчийн эрх,

²⁹ https://shuukh.mn/single_case/125863?daterange=2002-01-01%20-%202023-04-01&id=1&court_cat=1&bb=1

³⁰ https://shuukh.mn/single_case/71137?daterange=2002-01-01%20-%202023-04-01&id=1&court_cat=1&bb=1

хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байгаа тул уг зохицуулалтыг өөрчилж, гэрээслэлд хэн гэж тусгаснаас үл хамааран заавал өвлөгчид өвлүүлэгчийн хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлэх зохицуулалтыг Иргэний хуульд тусгах шаардлагатай байна.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Өв залгамжлалын эрх зүйн асуудал нь хүний мөн чанарын илэрхийллээс урган гарч буй өмчлөх эрхтэй шууд холбоотой бөгөөд уг эрхийг Үндсэн хуулиар хамгаалах нь хамгийн чухал гарц болох талаар нэр сэтгэгчид хэлсэн байдаг. Тэр ч утгаараа Монгол Улсын Үндсэн хуулиар уг эрхийг хамгаалсан байна. Мөн өв залгамжлалын эрх зүй нь хүн төрөлхтний түүхэн хөгжил хувьслын явцад өөрчлөгдөн, гэрээслэлийн чөлөөт байдлын зарчмыг илүүтэйгээр хүлээн зөвшөөрч, хууль ёсны өв залгамжлалын хүрээг багасгах хандлага дийлж байна. Үүнээс үүдэн Профессор Жон Лангбены үзсэнчлэн гэрээслэл нь эдийн засгийн чухал баримт бичиг болохын гэрээслэлийн түүний чөлөөт байдлын зарчимд тавьж буй хязгаарлалт зайлшгүй судлах асуудал чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын хувьд гэрээслэлийн чөлөөт байдлын зарчмыг Иргэний хуулиар тодорхойлсон байдаг боловч түүнд тавьж буй хязгаарлалтын хувьд гэрээслэгч зөвхөн хууль ёсны бус этгээдэд өөрийн бүх хөрөнгийг гэрээсэлсэн тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ хэмээн хуульчилсан байдаг бөгөөд гэрээслэгч зөвхөн хууль ёсны бус өмчлөгч этгээдэд өвлөсөн тохиолдолд уг заавал өвлөгчид хөрөнгө өвлөгдөхөөр заасан байна. Гэвч өвлүүлэгч нь өөрийн бүх хөрөнгийг хоёрдугаар зэргийн хууль ёсны өвлөгч болох өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээд гэрээсэлсэн тохиолдолд заавал өвлөгчийн эрх зөрчигдөх нөхцөл үүсэж байна. Уг зохицуулалтыг эрх зүйд эдийн засгийн анализ хийх аргачлалын дагуу авч үзвэл маш чухал зохицуулал байх боловч хууль ёсны өвлөгчид бүх хөрөнгийг өвлөсөн бол заавал өвлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байгаа тул уг зохицуулалтыг өөрчлөн найруулах зайлшгүй шаардлагатай байна. Иймд судлаачийн зүгээс Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.3-д “Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ. Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох

хэсгийг оролцуулан тооцно” гэснийг Гэрээслэгч бүх эд хөрөнгөө гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр (эхнэр), төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг гэрээслэлд хэн гэж тусгаснаас үл хамааран заавал өвлүүлнэ” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэвшүүлж байна. Сүүлийн жилүүдэд мөн энэ төрлийн маргаан нэмэгдэх хандлагатай байх тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь өвлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чухал ач холбогдолтой юм.

V. НОМ ЗҮЙ:

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992
2. Монгол Улсын Иргэний хууль 2002
3. Магна харт 1215
4. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966

Монгол эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц., Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт., УБ., 2017
2. Т.Саруул., Эрх зүй хэрэглэх арга зүй., УБ., 2014
3. Эйн Рэнд., Капитализмыг өмөөрөх нь: Эдмон хэвлэлийн газар., 2005
4. Аристотель., Улс төр.
5. Доктор, профессор О.Жамбалдорж, О.Амарсайхан, Ж.Ариунзаяа., Монгол Улсын Иргэний эрх зүй., УБ., 2006
6. Legaldata.mn В.Оюумаа., Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд нотариатчийн гүйцэтгэх үүрэг., УБ, 2007., Нийтлэл.
7. С.Нарангэрэл., Монголын эрх зүйн эх толь бичиг., УБ., 2015
8. С.Должин., Харьцуулсан хувийн эрх зүй судлал., УБ., 2018
9. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар).,УБ., 2022
10. Т.Мөнхжаргал., Өв залгамжлалын эрх зүй., УБ., 2009

Гадаад эх сурвалж:

1. Ж.Локк., Избранные Философские Призведения., Т.2.М., 1960.
2. John G. Sparkling, Understanding Property Law, Lexus Nexis, 2012, P 13 “Өмч гэдэг нь нийгэмд материаллаг баялгийг олж авах хэлбэр, нөгөө талаас өмч нь эдийн засгийн категорийн хувьд оршин тогтнодоггүй харин зөвхөн эрх зүйн категорийн хувьд яригдаж болно”.
3. Alexandra Braun and Anne Rochell, Passing Wealth on Death, Oregon Hart Publishing, 2016, P.9
4. French, Civil Law, 1804



Д.МЯГМАРСҮРЭН

Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн Ахлах багш



Г.ЦЭЦЭГМАА

Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн багш

“СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ: ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ НЬ”

“THE RIGHT TO EDUCATION: TAKING SERIOUSLY THE IMPROVEMENT OF THE ACCESS TO QUALITY EDUCATION”

Хураангуй: Тогтвортой хөгжлийн зорилгуудын нэг болох сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх талаар дэлхий нийтээр багагүй ахиц дэвшил гараад байна. Монгол Улс нь олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, чанартай боловсрол эзэмшүүлэх, боловсролын мэргэжлийн байгууллагын тогтолцоог бэхжүүлэх, боловсролын чанарын баталгааг хангах зэрэг чиглэлээр бодлогын болон бүтэц, зохион байгуулалтын олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Сурч боловсрох эрхийг хангахад дан ганц үндэсний бодлого, зохион байгуулалт хангалтгүй тул эдгээрийг дэлхий нийтийн хөгжлийн бодлого, зорилтуудтай харьцуулах, хууль тогтоомжийн шинэчлэлд нийцүүлэн уялдуулах нь чухал болохыг энэхүү өгүүлэлд хөндөв. Монгол Улсын боловсролын талаарх хуулиудыг шинэчлэн боловсруулж буй энэ цаг үед “чанартай боловсрол эзэмших”, “сурч боловсрох тэгш боломж”, “суралцахуйн орчинд хүний эрхийг хүндэтгэх” зэргээр сурч боловсрох эрхийн хүрээнд авч үзэхийг зорьсон болно. Энэ өгүүллийн хүрээнд боловсролын хүртээмж, чанар, тэгш

боломжид холбогдох бодлого, түүний хэрэгжилтэд тулгарч буй сорилтуудыг авч үзлээ.

Abstract: *Realisation of the right to education, one of the Sustainable Development Goals, has made significant progress in global and national levels. Mongolia has been implementing numerous policy, structural, and organisational measures in the areas of inclusive and high-quality education, thereby ensuring the right to education and strengthening the educational system and its capacity. National education policy and systematic changes are insufficient to guarantee right to education in Mongolian context. In this article, the author examines the significance of comparing the upcoming policy reform of Mongolian education laws with global education policies and benchmarks. Currently, education laws in Mongolia are being revised. This article discusses the right to education in Mongolia in terms of “quality education”, “equal opportunities”, and “respect for human rights in the educational settings”. In this article, the author examines the current policy on access, quality, and equal opportunity in Mongolian education system, as well as the key challenges associated with its implementation.*

Keywords: *education, right to education, core curriculum, education quality and accessibility*

Түлхүүр үг: *боловсрол, сурч боловсрох эрх, сургалтын цөм хөтөлбөр, чанар, хүртээмж*

I. ОРШИЛ

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас боловсролын салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Боловсролын ерөнхий хуулийн төсөл, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төсөл, Дээд боловсролын тухай хуулийн төсөл, Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төсөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг (шинэчилсэн найруулга) боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж эхэлсэн билээ. Эдгээр хууль батлагдсанаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын нэгэн зорилго болох “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх” боломж бүрдэнэ хэмээн Засгийн газар үзжээ. Боловсролын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх үүднээс эдгээр хуулийн төслийг боловсруулж, салбарын мэргэжилтнүүд, иргэд, олон нийтээр хэлэлцүүлж, олон тооны санал, зөвлөмжүүд авч байна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх явцад Монгол Улсын боловсролын чанар, хүртээмжийн талаар оролцогч талууд ихээхэн шүүмжлэлтэй хандаж, ялангуяа боловсролын салбарт тэгш бус байдал ихээхэн гүнзгийрч, салбарын хамгийн тулгамдсан асуудал болж буй тухай олонтоо хөндөгдсөн болно. Өөрөөр хэлбэл, ерөнхий боловсролын бодлогын залгамж чанар, уялдаа холбоо хангалтгүй, боловсролын чанар, хүртээмжид олон сорилтууд тулгарч байгаа нь сурч боловсрох эрхийн хэрэгжилт хангалтгүй байна гэсэн үг юм. Иймд Боловсролын тухай багц хуулийг шинэчлэн боловсруулж буй энэ цаг үед “чанартай боловсрол эзэмших”, “сурч боловсрох тэгш боломж”, “суралцахуйн орчинд хүний эрхийг хүндэтгэх” зэргээр сурч боловсрох эрхийн агуулгыг хүний эрхийн үүднээс авч үзэх нь чухал юм. Энэ өгүүллийн хүрээнд боловсролын хүртээмж, чанар, тэгш боломжид холбогдох бодлого, түүний хэрэгжилтэд тулгарч буй сорилтуудыг авч үзлээ.

II. БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ДЭЛХИЙ НИЙТИЙН ЧИГ ХАНДЛАГА

Боловсролын хяналт шинжилгээний 2018 оны дэлхийн тайланг “Боловсролд хариуцлагатай хандах нь” хэмээн нэрлэсэн байдаг. Уг тайланд Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилт (ТХЗ 4) *“Тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих”* зорилтыг биелүүлэхэд дэлхий нийтийн боловсролын тогтолцооны үүрэг хариуцлага, өнөөгийн байдалд үнэлэлт өгөх, цаашдын хариуцлагын тогтолцоо бүрдүүлэхэд анхаарчээ.

2030 он хүртэлх Боловсролын алсын хараа нь “боловсрол нь хөгжлийн үйл явцыг хурдасгагч бөгөөд боловсролоор дамжуулан хүмүүсийн амьдралыг өөрчилнө. Иймд хөгжлийн гадна хэнийг ч үлдээхгүй, тэгш хамруулах зорилго бүхий боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ алсын хараа нь дэлхий дахинаа, үндэсний түвшинд боловсролд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэнэ” хэмээн тодорхойлжээ.

ТХЗ4: *“Тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих”*

Зорилт 4.7: *2030 он гэхэд бүх суралцагч тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар тухайлбал, тогтвортой хөгжил, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жеңдэрийн тэгш байдал, энх тайван, хүчирхийллийг үл тэвчих соёлыг дэмжих, дэлхийн иргэн байх, тогтвортой хөгжилд соёлын оруулах хувь нэмэр, соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрөхөд суралцсан байна.*

Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилгын хүрээнд сурч боловсрох эрхийг хангахад улс орнууд ихэд анхаарч, хүүхэд бүрийг сургуульд хамруулах, бага боловсрол эзэмшүүлэх зэрэгт ихээхэн ахиц дэвшил гарсан. Гэвч боловсрол дахь тэгш боломж буюу сургуулийн байршил, хот, хөдөөгийн ялгаа, хөгжлийн

бэрхшээл, гадаад хэлний түвшин зэрэгтэй холбоотой боловсролын үр дүн ихээхэн ялгаатай байна. Дэлхий нийтийн хувьд ирэх арван жилд нэг тэрбум орчим залуучууд ажиллах хүчний эгнээнд шилжин орох хүлээлттэй байна. Гэвч бага боловсролын насны 387 сая, суурь боловсролын насны 230 сая хүүхэд унших, математикийн хичээлээр эзэмшвэл зохих хамгийн наад захын түвшнийг хангаж чадаагүй нь суралцахуйн үр дүн, чанарын хувьд ихээхэн ялгаа байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, боловсролын бүх түвшинд эрх тэгш суралцах, суралцахуйн чадварын асуудал даруй шийдвэрлэвэл зохих сорилтуудын нэг болжээ.¹ Тиймээс хүүхэд, өсвөр үеийнхний суурь чадвар (наад зах нь бичиг үсэгт тайлагдах, тоо бодох), зөөлөн ур чадвар (тухайлбал, нийгэм-сэтгэлзүйн байдал, бүтээлч байдал, асуудал шийдвэрлэх чадвар) болон дижитал чадварыг хөгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэжээ.

Монгол Улс нь Ази, Номхон далайн бүс нутгийн залуу хүн амтай улсын нэг бөгөөд нийт хүн амын гуравны нэг нь хүүхэд билээ. Тиймээс боловсролд зарцуулах Монгол Улсын үндэсний төсвийн зардлын хэмжээ тогтмол нэмэгдсээр байна. Тухайлбал, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд зааснаар төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгийн төлбөр, бусад зардлыг улсын төсвөөс хариуцаж, боловсролын салбарын төсвийн 23 хувийг сургуулийн өмнөх боловсролд зарцуулах болсноор нэг хүүхэдэд ноогдох боловсролын зардал бүс нутагтаа хамгийн өндөр орнуудын нэг болжээ. Мөн бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин 2022-2023 оны хичээлийн жилд 96.5 хувьд хүрсэн. Дунд ангийн (6-9-р ангийн) хамран сургалтын цэвэр жин 94.0 хувь болж², бүх нийтийг хамарсан нь (БСШУСЯ, 2018) Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хуульд “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно” хэмээн баталгаажуулсны бодит үр дүн юм.

Монгол Улс хүн бүр сурч боловсрох эрхтэйг хүлээн зөвшөөрч, уг эрхийг багтаасан Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц болон бусад хүний эрхийн гэрээ конвенцод нэгдэн орсон нь олон улсын гэрээ, санаачилгуудыг өөрийн улс оронд хэрэгжүүлэх үүрэг хүлээсний илэрхийлэл юм. Сурч боловсрох эрхийг Монгол Улсын боловсролын эрх зүйн олон бичиг баримтад тусгаж өгчээ. Үүнд 2002 оны Боловсролын тухай багц хууль, 2008 оны Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон Засгийн газрын хөтөлбөрүүд, 2006-2015 оны Боловсролын мастер төлөвлөгөө (ЗГ, 2006) болон бусад бодлогын баримт бичгүүдийг нэрлэж болно. 2002 оны Боловсролын тухай хуулиар алслагдсан хөдөө орон нутагт амьдардаг хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулах Сургуулийн өмнөх боловсролын “хувилбарт” сургалтыг буй болгожээ. 2006-2015 онд хэрэгжүүлсэн Боловсролын Мастер

¹ НҮБ-ын Хүүхдийн сангийн Боловсролын стратеги (2019-2030), Хэлэлцүүлгийн тайлан, 2019

² Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээлэл 2022-2023 он 74 дүгээр тал

төлөвлөгөөнд хүртээмж, чанарыг сайжруулахыг онцлон холбогдох зүйл заалтыг дэлгэрүүлэн тусгажээ. БСШУЯ, ЭМЯ болон НХХЯ-ын хамтарсан тушаалаар “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого”-ыг (2005) үндэсний хэмжээнд баталж, хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнс, нийгмийн халамж хамгаалал болон боловсролын талаар төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулсан байна. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод (2014-2024) суурилан 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ. 2017 онд батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр” “хүүхдийн амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрүүл, аюулгүй орчинг буй болгох” болон хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн байна.

Боловсролын мастер төлөвлөгөөнд (МУЗГ,2006) сурч боловсрох эрхийг хангах талаар хэд хэдэн зүйлд дурдсан боловч энэхүү мастер төлөвлөгөө, үндэсний хууль, хөтөлбөрүүд нь хүний эрхэд суурилсан арга хандлагыг бүрэн тусгаж, хэрэгжүүлээгүй юм.³ Иймд Монгол Улсын хувьд хүний эрхэд суурилсан хандлагыг хэрхэн оновчтой тусгах талаар олон улсын туршлагаас судлах нь чухал юм. Жишээлбэл, хүний эрхэд суурилсан хандлагаар авч үзвэл хэнийг ч алагчилж хандахгүй, тодорхой бүлэг, хүнийг ялгаварлан гадуурхахгүй, сурч боловсрох эрхийг нь хязгаарлахгүй байх нь хүний эрхэд суурилсан бодлогын чиглэл болж чадна. Хүний эрхэд суурилсан зарчмыг хангах гэдэг нь суралцах явцад үл алагчлах, хүн бүрд тэгш боломж олгохын зэрэгцээ зарим зорилтот бүлэгт дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хэлнэ. 2019 оны 4 дүгээр сард Боловсролын суурь мэдээллийн тайлангийн хэлэлцүүлгийн үеэр боловсролын үл алагчилсан, инклюзив бодлогыг хангахын тулд хүний эрхэд суурилсан арга хандлагаар авч үзэхийг дэмжсэн байр суурь, үзэл бодол хүчтэй илэрхийлэгдэж байв.

2016 онд Боловсролын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “сургалтын цөм хөтөлбөр”-ийг тухайн шатанд суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвшлийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичиг хэмээн тодорхойлж өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллага дагаж мөрдөхөөр хуульчилсан. Энэ хүрээнд 2012-2018 онд сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулж, үе шаттайгаар үндэсний түвшинд бүх нийтээрээ мөрдөн хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- 2014-2015 оны хичээлийн жилээс бага боловсролын сургалтын хөтөлбөр
- 2015-2016 оны хичээлийн жилээс суурь боловсролын сургалтын хөтөлбөр
- 2016-2017 оны хичээлийн жилээс бүрэн дундын X ангийн сургалтын

³ БСШУСЯ, НҮБШУСБ Монгол Улсын Боловсролын Суурь Мэдээллийн Тайлан. УБ., 2019., 103 дугаар тал,

хөтөлбөр

- 2017-2018 оны хичээлийн жилээс бүрэн дундын XI ангийн сургалтын хөтөлбөр
- 2018-2019 оны хичээлийн жилээс бүрэн дундын XII ангийн сургалтын хөтөлбөр хэрэгжиж байна.

2014 оноос эхлэн мөрдөж буй бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт шинжлэх ухааны мэдлэг, чадвараас гадна өөрийн хүч нөөцийг мэдрэх, бусадтай хамтрах, мэдлэгийг эрж хайх олж судлах арга барилтай болох, байнга тасралтгүй хөгжих, хүрээлэн буй орчныг зөв ухаарч тэнд өөрийгөө зөв авч явах, зорилго чиглэлтэй амьдарч хөдөлмөрлөх зэрэг хувь хүний хөгжилд хандсан ТХБ-ын үзэл санаа, агуулгыг тодорхой тусгасан байна. Сургалтын цөм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баримтлах тодорхой зарчмуудыг чухалчилж, хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй нь сурагчдын аливаа юмс, үзэгдлийг өөрөө сонирхон шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, бусадтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах үр дүнгээ танилцуулах зэрэг бүтээлч үйл ажиллагаанд сууриллахаар тодорхойлжээ.

Харин бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг ахлах ангийн сурагчдад өөрсдийн авьяас, сонирхол, ирээдүйн мэргэжлийн чиг баримжаандаа тулгуурлан хичээлээ сонгож судлах өргөн боломж олгох, ахлах сургуулийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталсан байна. Энэ бодлогын хүрээнд бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ахлах сургуульд дараах нэмэлт үйл ажиллагаанууд хэрэгжиж, тэдгээрт харгалзах шинэ менежмент шаардагдаж, сургуулийн захирал, сургалтын менежер, ангийн болон хичээл заадаг багш нар, нийгмийн ажилтан, сурагчид, эцэг эхчүүд шинэ үүрэг хариуцлага хүлээхээр төлөвлөжээ.

Гэвч дээрх шийдвэр гаргахдаа Монгол Улс дахь ЕБС-ийн бүтэц, байршил, хэмжээ, хэв шинжийн онцлогийг гүйцэд тооцоогүй, зохих бэлтгэлийг бүрэн хангаагүйн улмаас хөдөөгийн цөөн сурагчидтай сургуульд сонгон суралцах боломжууд хязгаарлагдаж, тус бодлогын хэрэгжилтэд бэрхшээлүүд гарч, батлагдсан сургалтын төлөвлөгөөнүүд өөрчлөгдөхөд хүргэжээ. Улмаар дараагийн шатны сургуульд үргэлжлүүлэн суралцах залгамж холбоог хангах, бүрэн дунд боловсролын агуулгыг кредитийн тогтолцоонд шилжүүлэх, суралцагчдад сонгох боломжийг өргөжүүлэх, ахлах сургуулийг хөгжүүлэх бодлого бүрэн утгаараа хэрэгжиж чадахгүй байна.

Сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг боловсролын түвшнээр авч үзвэл бага боловсрол (ББ)-ын 142 (25.0%), суурь боловсрол (СБ)-ын 217 (38.3%), бүрэн дунд боловсрол (БДБ)-ын 208 (36.7%) суралцахуйн зорилт тус бүр ТХЗ-д хамаарч байна. Судалгааны дүнгээс харахад Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ зорилго, агуулгын хувьд харьцангуй сайн

интеграцिलाгдсан байна. Гэхдээ боловсролын түвшин бүрийн сургалтын цөм хөтөлбөрийн бүтэц, дизайны ялгаатай байдал, судлагдахууны агуулгын чиглэлүүдийн онцлогууд, хөтөлбөрүүдийн боловсруулалтын түвшний жигд бус байдал зэргээс хамаарч цөм хөтөлбөрт ТХБ-ийн интеграцिलाгдсан байдлыг илрүүлэх ажиллагаа нь судалгаанд сонгогдсон эх материал бүрийн хувьд ялгаатай аргачлалаар явагдахад хүргэсэн талаар уг судалгаанд тэмдэглэжээ.

“Цөм хөтөлбөр”-өөс бүртгэгдсэн нийт өгөгдлийн 22,3 хувь хөтөлбөрийн зорилго, зорилтод, 7,4 хувь үнэлгээнд, 12,8 хувь агуулгад, 33,1 хувь аргад, 24,4 хувь орчин ба хэрэглэгдэхүүнд тус тус ногдож байна. “Цөм хөтөлбөр”-т үнэлгээний зорилт нь суралцахуйн зорилтоосоо 3 дахин цөөн байна. Зүй ёсоороо бол үнэлгээний зорилт (шалгуур, индикаторууд) нь хөтөлбөрийн зорилтоосоо дутуугүй, харин ч илүү нарийвчлагдсан байвал зохилтой гэж үзжээ. Цаашид сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулах үйлийг төлөвлөлт, туршилт, хэрэгжилт, үнэлгээг оновчтой, үр өгөөжтэйгөөр тасралтгүй үргэлжилж байх “Сургалтын хөтөлбөрийн менежментийн цикл”-ийг нарийвчлан боловсруулж мөрдөх хэрэгцээ үүссэн байна. 2019 оны байдлаар 2008-2018 оны хооронд үндэсний түвшний нийт 252 сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдсөн боловч сүүлийн жилүүдэд боловсрогдсон нийт хөтөлбөрийн 70 гаруй хувь нь хүчингүй болсон байна.

Монгол Улсад боловсрол дахь ялгаатай байдлыг (disparity) хот суурин, хөдөө орон нутгийн ялгарал, хүйс, хөгжлийн бэрхшээлийн зарим хэлбэр, орлогоос үүдэлтэй ядуурал, малчин болон малчин бус болон үндэсний цөөнхийн бүлэгт хамаарах эсэх талаас шинжлэн судлах нь нийтлэг байна. Ялгаатай байдлын талаар хийгдсэн судалгаа шинжилгээ нь боловсролд хамрагдсаны дараа янз бүрийн чадвар, чадамжаар ялгаатай суралцагчдын суралцах, тэдэнд хичээл заах үйл явцыг авч үзэхээс илүүтэйгээр боломж, хүртээмжийн асуудалд илүү төвлөрсөн байдалтай байна.

2021 оны байдлаар дэлхийн 64 улсыг өрсөлдөх чадвараар нь харьцуулан судлахад Монгол Улс 60 дугаарт⁴, авьяас, ур чадварын үнэлгээгээр 61 дүгээрт⁵, дижитал өрсөлдөх чадвараар 62 дугаар байрт⁶ эрэмбэлэгдсэн нь боловсролын хамран сургалтын өндөр түвшин, боловсролд зарцуулах төсвийн зардалтай харьцуулахад чамлалттай үзүүлэлт юм. Монгол Улсын боловсролын чанар анхан шатнаас эхлэн нийт салбарын хэмжээнд хэдэн арван жилийн турш хамгийн тулгамдсан асуудлын нэг болж байна. 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар 2, 3-р ангид суралцаж буй охид, хөвгүүдийн дөнгөж 33 хувь нь тоо бодох суурь мэдлэгтэй, 44 хувь нь унших

⁴ Дэлхийн дижитал чадварын тайлан. 2021.

⁵ Дэлхийн дижитал чадварын тайлан. 2021.

⁶ Дэлхийн дижитал чадварын тайлан. 2021.

суурь чадвартай гэсэн үр дүн гарсан нь харамсалтай.⁷

Үүний хамт КОВИД-19 цар тахлын үед чанартай боловсрол олгох зорилгын хэрэгжилтэд саад бэрхшээлүүд тулгарч, ихээхэн ялгаатай байдал үүссэн талаар олон тооны судалгааны дүгнэлтүүд гарчээ.⁸ КОВИД-19 цар тахлын хөл хорионы үед зохион байгуулсан зайн сургалтын явцад алслагдсан нутгийн малчин өрхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон эцэг эхийн хараа хяналт сул хүүхдүүд хоцрох эрсдэл хамгийн өндөр байв.⁹ Ялангуяа үндэстний цөөнх бүлэгт хамаарах хүүхдүүдийн нөхцөл байдал бүр дор бөгөөд эдгээр хүүхэд анхаарлын гадна орхигдож буйг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны явцад тодорхойлжээ.¹⁰ Энэ нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үүдэлтэй боловсролын тэгш бус байдал ихээхэн гүнзгийрч байгаагийн нэг жишээ юм.

Түүнчлэн КОВИД-19 цар тахлын эсрэг Нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө болон 2019 оны Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийн Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ/VNR)¹¹-д тодорхойлсон орхигдох эрсдэлтэй хүн амын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн тайлан, олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн дүн шинжилгээ, холбогдох зөвлөмжүүд зэрэг эх сурвалжаас үзэхэд хүүхэд, өсвөр насныхан хөгжлөөс орхигдох эрсдэлтэй байна.¹² Газарзүйн байршил, боловсролын чанар, хүртээмж, амьжиргааны эх үүсвэрийн ялгаатай байдлаас шалтгаалж, хүүхэд, залуучуудын бүлэгт олон тооны бэрхшээл тулгарч байгаа тул хөгжлийн гадна хэнийг ч орхихгүй гэсэн амлалтаа биелүүлэхэд Монгол Улсын хувьд хүндрэл учирч байна. Ялангуяа бага орлоготой бүлэгт хамрагддаг, хөдөө орон нутагт амьдардаг, боловсролын чанар, хүртээмжээс хоцорсон хүмүүс хөгжлийн үр шимээс орхигдох магадлалтай байна хэмээн НҮБ-ын Ази, номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комисс (НҮБ-АНДЭЗНК)-ын судалгаанд¹³ дүгнэжээ.

Дэлхий нийтийн чиг хандлагын нэгэн адил Монгол Улсын хүн амын ядуурал нь хүн амын боловсролын түвшинтэй ихээхэн хамааралтай. Ядуу өрхийн хүүхдүүдийн дөнгөж 10 орчим хувь нь дээд боловсрол эзэмшиж байна. Харин чинээлэг өрхийн хүүхдүүд урт хугацаагаар үргэлжлүүлэн суралцаж,

⁷ Үндэсний статистикийн хороо, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018, 378 дахь тал

⁸ НҮБХС-ийн судалгаа. “Теле хичээлийн үр дүнгийн үнэлгээ”, 2020, ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл 2021 зэргийг дурдаж болно.

⁹ Монгол Улс дахь НҮБХС, Теле хичээлийн үр нөлөөний үнэлгээ, 2020

¹⁰ Монгол Улс дахь НҮБХС, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018 – Инфографик

¹¹ Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ/VNR), 2019, <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

¹² Монгол Улс дахь НҮБ, Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ 2021, 19 дэх тал ССА page 31;

¹³ НҮБ-АНДЭЗНК/ESCAP (2021), Монгол Улс: Орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд, Нийгмийн хөгжлийн бодлогын товчоон #2021/02, available at: <https://www.unescap.org/resources/leaving-no-one-behind-inob-country>

мэдээлэл технологийн дэвшилтэй сайтар танилцаж, хэрэглээ өндөр байгаа нь нийгмийн бүлгүүд хоорондын мэдлэг боловсролын, ур чадварын ялгааг нэмэгдүүлж байна. Сурч боловсрох явцад гарч буй эдгээр ялгаа нь хүүхэд, өсвөр үеийнхэн, залуус сургуулийн орчноос ажил, хөдөлмөрийн талбарт шилжихэд сөрөг нөлөө үзүүлж байна.

КОВИД-19 цар тахлын өмнөх үетэй харьцуулахад өнөөгийн хүүхэд, залуучууд маш эмзэг болсон хөдөлмөрийн зах зээлтэй учирч байна.¹⁴ Бичиг үсэг, тоо бодлого зэрэг суурь мэдлэг, чадварыг боловсролын анхан шатнаас дутуу эзэмшүүлснээр ажиллах хүчний чанар, бэлэн байдалд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болжээ. Хүүхэд, өсвөр үеийнхэн боловсролын чанарыг нь сайтар магадлан шалгахгүйгээр их, дээд сургуульд элссэний улмаас дээд боловсрол эзэмшсэн ч мэргэжлээрээ ажиллах боломжгүй, ажлын байранд тэнцэхгүй байх тохиолдол олон гарч байна. Залуучуудыг шинэ төгсөгч, мэргэжлийн ур чадвар дутмаг, туршлагагүй гэх шалтгааны улмаас ажил олгогчид бага цалин, хөлсөөр ажиллуулж байна. Төгсөгчид, ялангуяа их, дээд сургууль төгсөгчдийн ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байгаа, техник, мэргэжлийн боловсролын тогтолцооны хөгжил сул байгаа зэрэг нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангаж чадахгүй байх, албан бус хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, хөдөлмөрийн бүтээмж буурах, цалин хөлсний тэгш бус байдал үүсэх зэрэг асуудлын үндсэн шалтгаан болж байна. Өнөөгийн хөдөлмөрийн зах зээл нь ажиллагчдаас мэргэжлийн ур чадварын хамт “зөөлөн” ур чадварууд шаардаж байна. Харамсалтай нь суурь боловсролоос эхлэн олгох “зөөлөн” ур чадваруудыг суралцагчдад эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг бүрэн хангахуйц нийлүүлэлт өнөөгийн боловсролын тогтолцоонд дутагдаж байна. Зөөлөн ур чадварууд эзэмшээгүй өсвөр насны охид, хөвгүүд цаашид өөрийгөө хөгжүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэх эрхээ эдэлж чадахгүйд хүрч байна.

Техник, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (ТМСҮТ)-ийн төгсөгчдийн дунд явуулсан хамгийн сүүлийн үеийн судалгаагаар төгсөгчдийн дөнгөж гуравны нэг хүрэхгүй хувь нь ТМСҮТ-д суралцсан мэргэжилдээ тохирох ажилд орсон байна. ТМСҮТ-өөс олж авсан мэргэжлээрээ ажиллаагүй дараах гол шалтгаануудыг дурджээ. Үүнд: I) ТМСҮТ-ийн төгсөгчдийн орсон ажлын байр нь ихэвчлэн цалин бага, хөдөлмөрийн нөхцөл муу байсан; II) төгсөгчид ажлын хангалттай туршлагагүй, мөн ТМСҮТ-ийн багшлах чадварлаг нөөц дутмаг байснаас эзэмшсэн ур чадвар нь зах зээлийн шаардлагад нийцээгүй; III) ажилгүйчүүд, бага орлоготой айл өрхөд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээ харьцангуй нэмэгдсэнээр залуучууд хөдөлмөр эрхлэх сонирхол бага болсон; IV) ажил олгогчид ТМСҮТ төгсөгчдийг бус дээд боловсрол

¹⁴ НҮБ. Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ 2021, 7 дахь тал. https://mongolia.un.org/sites/default/files/2022-03/CCA%202021%20Mongolia%20MN_20220316.pdf

эзэмшсэн залуусыг ажилд авахыг илүүд үздэг зэрэг нөхцөлийг тодорхойлжээ.¹⁵

Дээд боловсролд хамрагдах боломж нэмэгдсэнээр өндөр боловсролтой дундаж давхарга бүрэлдэн тогтож буй бөгөөд Монголын нийгэм анги давхаргад (class) хуваагдах хандлага тогтох магадлалтай. Монгол улсын боловсрол хувьсан өөрчлөгдөж буй энэ үед урган гарч буй тэгш бус байдлыг анги давхаргын үүднээс харж, тодорхойлж болох юм. Дээд боловсролын салбарт мөн олон сорилт тулгарч байгаа бөгөөд төгсөгчдийнх нь боловсролын чанар сул, эзэмшсэн ур чадвар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байна. Үүнд чанаргүй олон хувийн их, дээд сургуулиуд ихээхэн нөлөөлжээ.¹⁶ Амьдрах ухааны боловсрол нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд “нийцэхгүй” байгаа өсвөр үеийнхний ур чадвар (эрсдэл, эмзэг байдлыг удирдах)-ыг дээшлүүлэх, Монгол Улсын шинэ тутам эдийн засагт тулгарч буй сорилт, гарч буй боломжийг шийдвэрлэх нийтлэг стратеги болж байна.¹⁷

Монгол Улс боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагддаг боллоо. Олон улсын чанарын энэхүү үнэлгээнд дэлхийн 90 гаруй улс хамрагддаг бөгөөд суралцагчид мэдлэг, чадвараа амьдралд хэрэглэж буй байдал, тухайн улсын боловсролын тогтолцоо нь ур чадварууд эзэмшүүлж буй түвшнийг тогтоож, боловсролын чанарын харьцуулалт хийх, чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлдог. Монгол Улсын 195 сургуулийн 7,325 суралцагч анх удаа сурлагын амжилтын PISA 2022 олон улсын чанарын үнэлгээнд хамрагджээ. Хэдийгээр бүх түвшний боловсролд хамрагдалтын түвшин өндөр ч энэ үзүүлэлт нь боловсролын чанарыг бүрэн илэрхийлэхгүй байна. Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжилтийг хангах, тэдгээрийн сайжруулахад чиглэсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий үндэсний хэмжээний иж бүрэн судалгаанууд хийгдэж эхэлсэн ч тэдгээрийг тогтвортой явуулах тогтолцоог бий болгож чадаагүй байна.

Сургуулийн өмнөх боловсрол, бага болон дунд боловсролын цөм хөтөлбөрт (бага, дунд ангийн хөтөлбөрт “сургалтыг дэмжих” хөтөлбөр, ахлах ангийн хөтөлбөрт “сургуулийн мэдлийн цаг”, БХ, 2019) тухайн сургууль өөрийн онцлогт тохируулсан, уян хатан боловсруулсан агуулга, чадвар эзэмшүүлж болох талаар тодорхой хэмжээгээр, гэвч тун бага боломжийг тусгаж өгсөн байдаг.

¹⁵ 2019 НҮББШУСБ/UNESCO Монгол Улсын Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын тойм шинжилгээ (Англи хувилбар): <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374199?posInSet=2&queryId=44cedc2c-c698-42bb-b5fd-cba0f2aa9dad>

¹⁶ 2020 НҮББШУСБ/UNESCO Боловсролын салбар. Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ (Англи хувилбар): <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687>

¹⁷ ОУХБ, 2008, Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_105100.pdf

Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, тэгш бус байдлыг бууруулах зорилгоор боловсролын бодлого, эрх зүйн орчныг шинэчлэхдээ нотолгоонд суурилсан төлөвлөлт, нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай байна. Тухайлбал, малчин өрхийн, алслагдсан орон нутгийн, үндэстний цөөнхийн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зэрэг эмзэг нөхцөлд буй хүүхдэд чиглэсэн хөтөлбөр боловсруулах, тэгш хамруулах, шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээний асуудлаар бодлогын нөлөөлөл хийх нь чухал байна. Үүнд сурч боловсрох эрхийг илүү хангахуйц уян хатан, оновчтой төрөл, хэлбэрийг санал болгох, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг онцлог, тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн байдлаар шинэчлэх зэрэг асуудлууд багтана. Мөн малчдын, хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл сурлагаар хоцрогдсон зэрэг хүүхдүүдийн онцлог нөхцөл байдалд мэдрэмжтэй хандсан, хэл, соёл болон хөгжлийн зохих түвшинд нийцсэн арга зүй, сургалтын материалаар хангах талаарх өнөөгийн боловсролын бодлого, түүний хэрэгжилтийг нарийвчлан үнэлэх шаардлага тулгарч байна.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Боловсролын чанар, хүртээмж нь улс орны хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлэхүйц хүчин зүйл болохыг өнөөгийн Монгол Улсын эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийн байдал, амьжиргааны түвшин, нийгмийн бус бус байдал зэргийг илэрхийлэх олон үзүүлэлтээс харж болох юм.

Сурч боловсрох эрхийг хангаж, ахиц дэвшил гаргахад хүн бүр, байгууллага бүр үүрэг хүлээнэ. Сурч боловсрох эрх нь боловсролын салбарын бүхий л оролцогчдыг хариуцлагатай байхыг шаардаж байна. Ялангуяа үүрэг хүлээгчид болон эрх эдлэгчдийн үүрэг хариуцлага, хүчин чармайлтыг тодорхой болгох, үүрэг хариуцлага хэзээ, хаана, яагаад биелэхгүй байна, ямар хариу арга хэмжээ авах зэргийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Цаашид боловсролын тогтолцоон дахь тэгш бус байдлыг бууруулах, сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй буюу орхигдох эрсдэлд буй хүүхдүүдэд чанартай үйлчилгээ хүргэх талаар үндэсний болон орон нутгийн түвшинд оновчтой бодлого хэрэгжүүлэх, боловсролын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, ахиц, үйл явцыг хянах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Боловсролын чанарыг сайжруулах, боловсролд орчин үеийн технологи нэвтрүүлэх, хот, хөдөөгийн, хувийн ба төрийн өмчийн зэрэг сургууль хоорондын ялгаатай байдлыг нэмэгдүүлэхээс сэргийлэх нь сурч боловсрох эрхийг хангах үндсэн нөхцөл болно.

IV. НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

1. Боловсролын тухай хууль. 2002
2. НҮБ, “Боловсрол 2030 Инчоны тунхаглал” 2015
3. Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний тавдугаар тайлан илтгэл, УБ., 2014
4. ҮСХ, НҮБХС, Монгол Улсын Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны тайлан, 2018
6. Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистик мэдээлэл 2022-2023, УБ., 2023
7. Боловсролын Үнэлгээний төв, Сурлагын амжилтын судалгааны тайлан, УБ., 2018
8. Боловсролын Үнэлгээний Төв, Боловсролын чанарын үнэлгээний судалгааны тайлан. УБ., 2018
9. Боловсролын хүрээлэн, 2019., Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. УБ. БОНХАЖЯ, 2016, УБ., Суурь судалгааны тайлан
10. БОНХАЖЯ, ШХА, 2015, Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа, УБ., pp. 128, 130,
11. БСШУСЯ, БХ, Цөм хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа, УБ., 2019
12. Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ НҮБ. 2021
13. БСШУСЯ, НҮББШУСБ Монгол улсын Боловсролын Суурь Мэдээллийн Тайлан. УБ., 2019
14. НҮББШУСБ/ЮНЕСКО Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ, Боловсролын салбар. УБ., 2020

Гадаад эх сурвалж:

1. UNESCO, Accountability in education: Meeting our commitments; Global education monitoring report summary, 2017/8





Г.ГАНТӨМӨР

ОТИС-ийн Хууль Зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор, профессор

БҮХ НАСААР ХОРИХ ЯЛЫН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

THE PENALTY OF LIFE IMPRISONMENT UNDER INTERNATIONAL LAW

Хураангуй: Энэ эрдэм шинжилгээний өгүүлэлд бүх насаар хорих ялын олон улсын эрх зүйн зохицуулалт, тухайлбал: уг ялыг хэрэглэх, хуульчлах хэрэгцээ, хэмжээ хязгаар, оногдуулах, эдлүүлэх ажиллагааны зарчим, журамд тавигдах шаардлагын талаар дэлхий нийтийн болон бүс нутгийн хэмжээний хүний эрхийн талаарх болон бусад олон улсын эрх зүйн бичиг баримтад хэрхэн тодорхойлсон байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Abstract: This scientific article analyzes the international legal regulation of punishment in the form of life imprisonment, in particular the need for the application and legalization of punishment, the limits, principles and procedures for its appointment and execution, international and regional human rights treaties and other international legal documents that make up the international legal framework of this punishment.

Түлхүүр үгс: хүний эрх, олон улсын хэм хэмжээ, бүх насаар хорих ял, бүх

насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол, оногдуулах, бүх насаар хорих ял эдлүүлэх журам, нөхцөл

Key words: *human rights, international legal norms, life imprisonment, prisoners sentenced to life imprisonment, procedure and conditions for the appointment and serving of life imprisonment.*

I. УДИРТГАЛ

Дэлхийн ихэнх улсуудын Эрүүгийн хуульд бүх насаар хорих ялыг хуульчилсан ба цээрлэлээрээ цаазаар авах ялын дараа ордог, цаазаар авах ялыг халсан орнуудын хувьд хамгийн хүнд, бас онцлог ялын төрөл юм.

НҮБ-ын “Хүний иргэний болон улс төрийн эрхийн пакт”-ын нэмэлт II протокол буюу Цаазаар авах ялыг халах тухай конвенцыг баталснаас хойших 20-иод жилийн хугацаанд олон улсын хэмжээнд цаазаар авах ялыг халах, татгалзах үйл явц хүчтэй өрнөж байна.

НҮБ-ын “Хүний иргэний болон улс төрийн эрхийн пакт”-ын нэмэлт II протокол буюу Цаазаар авах ялыг халах тухай конвенцыг НҮБ-ын Ерөнхий ассамблей 1989 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталж, 1991 оны 07 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд 2021 оны 4 дүгээр сарын байдлаар уг конвенцод 89 улс нэгдэн ороод байна.

Мөн бүс нутгуудын хэмжээний хүний эрхийн бичиг баримтад зарим өөрчлөлтүүдийг оруулжээ. Тухайлбал: Европын Зөвлөлийн Хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенцын нэмэлт VI протокол буюу Цаазаар авах ялыг халах тухай протокол нь 1983 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Страсбург хотод батлагджээ.

Европын Зөвлөлд 46 улс, Европын Холбоонд 27 улс багтах ба 1997 оноос хойш Европ тивд цаазаар авах ялыг гүйцэтгээгүй, 2013 оноос Европ тив цаазаар авах ялгүй бүс нутаг болоод байгаа юм. Европын зөвлөлийн гишүүн орнуудаас гагцхүү Беларусь улс уг конвенцод нэгдэн ороогүй байна¹.

Мөн Америкийн улсуудын байгууллагын Ерөнхий ассамблей 1978 онд баталсан Америкийн Хүний эрхийн тухай конвенцын 1990 оны нэмэлт протоколд “...гишүүн орнууд цаазаар авах ял хэрэглэхгүй байх, хэрэв хэрэглэх бол онцгой нөхцөлд буюу дайны цагт цэргийн гэмт хэрэг үйлдсэнээс бусад тохиолдолд цаазаар авах ялыг хэрэглэхгүй байх...”-ыг үүрэг болгосон байдаг².

2022 оны байдлаар 108 улс цаазаар авах ялыг бүрмөсөн халсан, 6 орон цаазаар авах ялыг ердийн эрүүгийн хэрэгт хэрэглэхгүй, зөвхөн дайны

¹ Ежегодная уголовная статистика Совета Европы (SPACE) 2004.8 и 2014.7.

² <http://www.oas/juridico/english/Sigs/a-52.html>

цагт эсвэл дайн бүхий байдлын үед онц хүнд гэмт хэрэг үйлдсэн онцгой тохиолдолд хэрэглэхээр байгаа бол 60 гаруй оронд цаазаар авах ялыг Эрүүгийн хуульд ялын төрөл болгон хуульчилсан хэвээр байна³.

Түүнчлэн 2018 онд дэлхийн 193 улсаас 169 улсад цаазаар авах ялыг хэрэглээгүй (оногдуулаагүй, гүйцэтгээгүй) болохыг олон улсын Эмнести Интернэшнл байгууллагын мэдээнд дурджээ⁴.

Монгол Улс ч уг үйл явцаас ангид байсангүй, ийм сонголтыг 2012 онд хийж, Улсын Их Хурал “Цаазаар авах ялыг халах тухай” конвенцыг соёрхон баталж, 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа цаазаар авах ялыг ялын төрлөөс хасаж, хугацаагүй хорих ялыг хорих ялын төрөл болгон хуульчилсан билээ.

Сүүлийн жилүүдэд цаазаар авах ялыг халах, татгалзах үйл явцыг дагалдан дэлхийн улсууд бүх насаар хорих ялыг хуульчлах болсноор уг ялаар шийтгүүлэгсдийн тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Олон улсын Ялын шинэчлэл /Penal reform international/ байгууллага болон Английн Ноттенгэймийн их сургуулийн эрдэмтдийн 2017 онд хийсэн хамтарсан судалгаагаар 2000 онд дэлхийн хэмжээнд 261.000 ялтан уг ялаар шийтгүүлж, ялаа эдэлж байсан бол энэ тоо, 2014 онд 305.323, 2017 онд 479.002 болж өссөн нь үүнийг батална⁵.

Бүх насаар хорих ялын тухай асуудал нь хүний эрх, сэтгэл зүй, эрх зүйн философи, эрх зүйн социологи, эрх зүйн харьцуулсан судлал, Эрүүгийн эрх зүй, Олон улсын эрүүгийн эрх зүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй зэрэг шинжлэх ухаан, эрх зүйн салбарын судлагдахууны өнцгөөс тодорхойлон тайлбарлаж болох өргөн хүрээтэй асуудал болно.

Иймээс бүх насаар хорих ялыг хэрэглэх, хуульчлах хэрэгцээ, хэмжээ хязгаар, оногдуулах, эдлүүлэх ажиллагааны зарчим, тавигдах шаардлага, бүх насаар хорих шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангах талаар дэлхий нийтийн болон бүс нутгийн хэмжээний хүний эрхийн болон бусад олон улсын бичиг баримтад хэрхэн тусгагдсаныг авч үзье.

II. ҮНДСЭН ХЭСЭГ:

Бүх насаар хорих ялын талаарх олон улсын зохицуулалтыг судлан үзэхэд уг асуудал нь:

Нэгдүгээрт, Хүний эрхийн талаарх олон улсын үндсэн бичиг баримт, нийтлэг хэм хэмжээ,

³ https://ru.wikipedia.org/wiki/смертные_казни

⁴ Хуторская Н.Б. Пожизненное лишение свободы в мире // ж. Уголовно-исполнительное право. 2018. № 13. С. 67

⁵ <https://cdn.penalreform.org/wpcontent/uploads/2018/04pdf>

Хоёрдугаарт, хорих ял эдлүүлэх болон хоригдлын эрхийг хангахтай холбоотой тусгай хэм хэмжээ,

Гуравдугаарт, бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой дэлхийн хэмжээний болон бүс нутгийн хэмжээний олон улсын хэм хэмжээ, бичиг баримтуудад тодорхойлогджээ.

Нэгдүгээрт: Дэлхийн хэмжээний буюу НҮБ-аас баталсан хүний эрхийн, тухайлбал хорих ял шийтгүүлсэн этгээдийн /хоригдлын/ эрхийг хангахтай холбоотой олон улсын нийтлэг хэм хэмжээ, олон улсын бичиг баримтад Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт хамаарна. Учир нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн пактад бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлын эрх зүйн байдалд шууд ба шууд бусаар хамаарах ба бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд хүний эрхийн талаарх олон улсын үндсэн бичиг баримтад заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхийг заасан.

Хорих ял шийтгүүлсэн этгээдийн (хоригдлын) эрхийг хангахтай холбоотой олон улсын хэм хэмжээнд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар 1955 онд НҮБ-ын Анхдугаар хурлаас баталсан *“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”*⁶, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 дугаар тогтоолоор баталсан *“Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд”*⁷, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарны 09-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан *“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”*⁸ зэрэг багтана.

Дээр дурдсан олон улсын бичиг баримтуудад бүх насаар хорих ял эдлүүлэх талаар болон бүх насаар хорих эдэлж буй хоригдлын эрх, үүргийг тусгайлсан заасан зохицуулалт байхгүй, хоригдлын эрх, үүрэг, хоригдлын эрхийг хамгаалах, хорих анги, тэдгээрийн алба хаагчдад тавигдах нөхцөл, шаардлага, хоригдолтой харьцах зарчмыг тодорхойлсон нийтлэг зохицуулалттай олон улсын хэмжээнүүд байна. Үүний учир шалтгаан нь эдгээр хорих ял эдлүүлэхтэй холбоотой олон улсын бичиг баримтууд батлагдах үед буюу өнгөрсөн зууны 1950-1980 онд бүх насаар хорих ялыг харьцангуй цөөн орнууд хэрэглэдэг, бүх насаар хорих ял эдэлж буй ялтны эрх зүйн байдалд анхаарал бага хандуулдаг, цаазаар авах ялаас татгалзах үйл явц дэлхий дахинд өрнөөгүй, уг асуудал одоогийнх шиг чухлаар тавигдаж байгаагүйтэй холбоотой.

⁶ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ.,1996., 1-24 дэх тал

⁷ Мөн тэнд. 25-26 дахь тал

⁸ Мөн тэнд. 26-38 дахь тал

Иймээс дээрх эрх зүйн бичиг баримтад тодорхойлсон “хоригдол” гэдэг ойлголтод бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд ч хамаарах тул бүх насаар хорих ял эдэлж буй хоригдол нь хоригдлуудын үндсэн эрх, үүргийг эдэлж, эрхээ хамгаалуулах эрхтэй юм.

Бидний судалж буй бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой, тэдгээрийг шууд тодорхойлсон дэлхийн хэмжээний болон бүс нутгийн хэмжээний олон улсын хэм хэмжээ, бичиг баримтууд цөөнгүй байна.

Хоёрдугаарт: Бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой дэлхий хэмжээний олон улсын хэм хэмжээнд юуны өмнө Хүүхдийн эрхийн тухай конвенц, Олон улсын Эрүүгийн шүүхийн дүрэм, 1994 оны НҮБ-ын Бүх насаар хорих ялын талаарх зөвлөмж зэрэг хамаардаг.

1989 оны Хүүхдийн эрхийн тухай конвенцын 37 дугаар зүйлд “...*гишүүн орнууд аль болохоор цаазаар авах ял, хугацаанаас өмнө суллах нөхцөлгүйгээр бүх насаар хорих ялыг гэмт хэрэг үйлдэхийн өмнө 18 насанд хүрээгүй хүнд хэрэглэхгүй байхыг эрмэлзэх ёстой*”. гэж заасан байдаг⁹.

“Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм”-ийн 7 дугаар хэсэгт Олон улсын шүүхийн дүрмийн 5 дугаар зүйлд заасан тус шүүхэд харьяалагдах төрлөөр устгах гэмт хэрэг, хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг, цэргийн гэмт хэргүүдийг үйлдсэн, гэм буруутай этгээдэд оногдуулах ялын талаар тусгасан ба тус хэсгийн 77 дугаар зүйлд гэмт этгээдийн үйлдсэн хэргийн шинж, хор уршиг, гэмт хэрэгтний зан байдал, хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан:

- а) 30 жил хүртэл хугацаатай хорих ял,
- б) бүх насаар хорих гэсэн 2 төрлийн ялыг оногдуулахаар заасан байдаг¹⁰.

Мөн дүрмийн “Таслан шийдвэрлэх тогтоолд заасан ялын хугацааг багасгах тухай асуудлыг шүүхээс хэлэлцэх” гэсэн 110 дугаар зүйлийн 3 дахь заалтад “...Хугацаатай хорих ялаар шийтгүүлсэн хоригдол оногдуулсан ялын гуравны хоёрыг эдэлсэн, эсвэл бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн этгээд 25 жилийн ялаа эдэлсний дараа ялын хугацааг багасгах эсэх асуудлыг шүүх хянан хэлэлцэж болно. Ийнхүү хянан хэлэлцэх ажиллагаа нь дээр дурдсан хугацаанаас өмнө явагдахгүй.”¹¹ гэж заасан нь бидний судалж буй асуудалд шууд холбогдоно.

⁹ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. / эмхэтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо/. УБ. 2012. 55 дахь тал

¹⁰ Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм. ХЭҮК. УБ. 2002. 93 дахь тал

¹¹ Мөн тэнд. 128 дахь тал

Бүх насаар хорих ялын талаарх гол бодлогын бичиг баримт болох 1994 оны НҮБ-ын “Бүх насаар хорих ялын талаарх зөвлөмж” (UN Recommendations on Life Imprisonment, 1994) онцгой үүрэгтэй. Уг зөвлөмжид “...Гишүүн орнууд бүх насаар хорих ялыг гагцхүү нийгмийг хамгаалах, хамгийн хүнд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, шүүн таслах ажиллагаа явуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага, эрүүгийн ялын бодлогын үүднээс хуульчлах ёстой.”, “...Бүх насаар хорих ялыг хуульчилсан гишүүн орнууд хоригдлуудыг хоорондоо харьцах, хүн хоорондын болон нийгэмтэй харьцах боломжийг алдагдуулахгүй байх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, ажил хөдөлмөр эрхлүүлэх, хийсэн ажлын үр дүн, сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх, засарч хүмүүжих чиглэлээр гаргасан ахиц дэвшлийг урамшуулах, шашин, соёл, спортын болон бусад чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл бололцоогоор хангах үүрэг хүлээнэ.”, “...Гишүүн орнууд улс төрийн ба нийгмийн нөхцөл байдалд бус, хувь хоригдлын нийгэмд аюултай зан байдал, засрал хүмүүжилд өгсөн үнэлгээнд тулгуурлан хорих газраас тэнсэн суллах боломжийг олгох үүрэгтэй.”, “...Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол ялаа хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх хүсэлт гаргах, уучлал хүсэх эрхтэй.”¹² гэж заасан нь бүх насаар хоригдож буй хоригдлын эрхийг хамгаалсан чухал зохицуулалт болсон юм.

Бүх насаар хорих ялын хэрэгжилтэд анхаарах, хүний эрхийн зөрчил гэж тооцогддог, шүүмжлэл дагуулдаг асуудал нь уг ялыг хэрэглэдэг улс орнууд бүх насаар хорих ял эдэлж буй этгээдийг ганцаарчлан удаан хугацаагаар хорьдог явдал бөгөөд энэ байдлыг засах, талаар НҮБ ба хүний эрхийн байгууллагууд удаа дараа зөвлөмж, мэдэгдэл гаргаж байсны нэг нь Стамбулийн зөвлөмж билээ.

2007 оны 12 дугаар сарын 9-ний өдөр Туркийн Стамбул хотод болсон олон улсын симпозиумаар уг асуудлыг хэлэлцэн, “Ганцаарчилсан камерт хорих нөхцөл, түүний сэтгэл зүйн үр дагаврын тухай” гэсэн зөвлөмжийг гаргасан ба уг зөвлөмжид хорих камерт /тасалгаанд/

- а) цаазаар авах ялаар шийтгүүлэн, түүний биелэлтийг хүлээж байгаа хүн,
- б) хэргийн онцгой нөхцөл байдал, хувийн онц аюултай байдлаас шалтгаалан ганцаарчлан хорих талаар эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрээс бусад тохиолдолд бүх насаар хорих шийтгүүлсэн хоригдол,
- в) хэрэг хариуцах чадварыг үгүйсгэхгүй сэтгэцийн эмгэгтэй хоригдол,
- г) 18 наснаас доош насны хоригдлыг ганцаарчлан хорихыг хатуу хориглож, энэ үйлдлийг 1987 оны НҮБ-ын Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бус хандах, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг ноцтой зөрчсөнд тооцох талаар дурдсан байдаг¹³.

¹² <https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2013/06/UNODC-1994-Lifers.pdf>

¹³ <https://www.refworld.org/cgi-bin/texis/vtx/rwmain/opendocpdf.pdf?reldoc=y&docid=48db9a112>

Дэлхийн ихэнх орнуудад бүх насаар хорих ялыг эмэгтэйчүүдэд оногдуулдаг. Үүнтэй холбогдуулан бүх насаар хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэднийг бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөгдүүлэхгүй байлгах, урьдчилсан сэргийлэх чухлаар тавигдаж байгаа бөгөөд асуудлыг тодорхойлсон 2010 оны 12 дугаар сарын 21-ний өдөр НҮБ-ын Ерөнхий ассамблейн 65/229 тоот тогтоолоор баталсан *“Хорих ял шийтгүүлсэн болон хорихоос өөр төрлийн арга хэмжээ авагдсан эмэгтэй эрх зүйн зөрчигчидтэй харьцах дүрэм”*¹⁴ буюу *“Бангкокийн дүрэм”* нь бүх насаар хорих ялын олон улс зохицуулалтын нэг салшгүй хэсэг мөн.

Уг дүрэм нь 1955 оны *“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”*-ийн 8 дугаар зүйлийн “а” заалтад заасан *“...гишүүн орнууд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг боломжийн хирээр тусдаа хорих газруудад байлгана. Хэрэв эрэгтэй, эмэгтэй хүмүүс нэг хорих газарт байгаа бол эмэгтэйчүүдийг тусдаа өрөө, тасалгаанд байрлуулбал зохино.”*¹⁵ гэсэн ерөнхий заалтыг бататгахын зэрэгцээ тэдний аюулгүй байдлыг хангах, хорих газрын эрэгтэй албан хаагчдын болон эрэгтэй хоригдлуудын зүгээс харгис хэрцгий хандах, бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэм хэмжээг тодорхойлсон нь онцлог юм. Тухайлбал: уг дүрмийн 53 дугаар зүйлд *“...бүх насаар хоригдож байгаа эмэгтэй хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдэнтэй харьцах, өрөө тасалгаанд хяналт, харуул хамгаалалтыг зөвхөн эмэгтэй албан хаагч хэрэгжүүлнэ.”* гэж заажээ.

Гуравдугаарт: Бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой, тэдгээрийг шууд тодорхойлсон бүс нутгийн бичиг баримтуудад Европын Зөвлөл, Европын холбооны хэм хэмжээ багтана.

Европ тив нь эдийн засгийн хувьд харьцангуй өндөр хөгжилтэй, ардчилал илүү хөгжсөн, хүний эрхийг дээдлэх, хангах бодитой үйлчилдэг механизмыг бий болгосон, энэ талаар бусад тивүүдийг манлайлдаг, үлгэр жишээ болж байдаг утгаараа бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтны эрхийг хангахад ихээхэн анхаардаг, энэ чиглэлээр хэд хэдэн олон улсын эрх зүйн баримт бичгийг баталж мөрдүүлж байна. Эдгээрээс заримыг дурдвал: 1976 оны Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж № R (1976) 2. *“Урт хугацаагаар хоригдож ялтнуудтай харьцах тухай”*¹⁶, 2003 оны Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж № Rec (2003) 22. *“Хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах журмын тухай”*¹⁷, 2003 оны Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж № Rec (2003) 23. *“Бүх насаар болон урт хугацаагаар*

¹⁴ https://www.un.org/ru/documents/decl_conv/conventions/bangkok_rules.shtml

¹⁵ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ, УБ, 1996. 1-24 дэх тал

¹⁶ А.Диденко, В.Човган. Пожизненное заключение. Европейские стандарты и Украинская практика. Харьков. 2014. с 63-65

¹⁷ Мөн тэнд. с 68-78

хоригдож байгаа ялтны талаар хорих байгууллагын захиргааны авах арга хэмжээний тухай”¹⁸ зэрэг болно.

2003 оны “Хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах журмын тухай” Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж /№ Rec (2003) 22/-ийн 4 дүгээр зүйлийн а-д “...гишүүн орнууд бүх ялтнуудад, түүний дотор бүх насаар хорих ял эдэлж буй ялтнуудад хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллагдах нөхцөл бололцоог олгох ёстой.” гэж заасан бол 2003 оны “Бүх насаар болон урт хугацаагаар хоригдож байгаа ялтны талаар хорих байгууллагын захиргааны авах арга хэмжээний тухай” Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж /№ Rec (2003) 23/-д бүх насаар хорих ял эдэлж хоригдлыг аль болох нийгмээс тусгаарлахгүй, эс нийгэмшүүлэхгүй байх, бусад хоригдол, гадаад орчин, гэр бүлтэйгээ харьцаа холбоотой байх, хоригдлыг ганцаарчлан хорихгүй байх, хоригдлуудыг үйлдсэн хэрэг, нийгэмд аюултай байдлын түвшин, зан чанар, (темперамент), хувийн болон сэтгэл зүйн байдал, нас, сонирхол, хоорондын нийцэмжтэй байдлаар нь ангилж ял эдлүүлэх, гэм буруугаа ухамсарлах, хөгжих, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, соёл, спортын ба бусад чөлөөт цагийн арга хэмжээнд хамруулах, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зэрэг хоригдлын эрхийг хангах, ял эдлүүлэхтэй холбоотой асуудлаас гадна хорих эдлүүлэх газрын албан хаагч, удирдлагын эрх, үүрэг, бүх насаар хорих эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, тавигдах шаардлагыг тодорхойлсон байдаг.

Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж /№ Rec (2003) 23/-д бүх насаар нь хорих эдлүүлэх байгууллагын үндсэн зорилго, бүх насаар хорих ял эдлүүлэхэд тавигдах нөхцөл, зарчмыг дараах байдлаар заажээ. Үүнд:

- а) Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол бүрд түүний үйлдсэн хэргийн төрөл, хэргийн нөхцөл байдал, хувийн зан байдал, сэтгэл зүйн байдалд үндэслэн аюултай байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, хүсэл сонирхол, хандлагад нийцүүлэн ял эдлүүлэх ганцаарчилсан төлөвлөгөөг гаргаж, түүнд тулгуурлан ялыг эдлүүлэх,
- б) Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдолд түүнийг засан хүмүүжүүлэх, зан байдалд нь нөлөөлөх, ял эдлүүлэх аюулгүй байдлыг хангахад зөвхөн чиглэсэн хязгаарлалтуудыг Эрүүгийн хууль болон хорих ял эдлүүлэхтэй холбоотой процессын хуульд хуульчлах, шүүхийн шийтгэх тогтоолд заасан болон хорих ял эдлүүлэх тухай хуульд зааснаас бусад хязгаарлалт, хориглолтуудыг хэрэглэхгүй байх,
- в) Бүх насаар хорих ял эдэлж буй ялтанд өөрийгөө хүмүүжүүлэх үүргийг хүлээлгэх, түүнийг хариуцлагажуулах, хорих ангийн захиргааны өмнө

¹⁸ Мөн тэнд. с 79- 91

- ял эдлүүлэх ганцаарчилсан төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ ухамсарлах, үүргээ биелүүлэх боломж, бололцоог олгох,
- г) Бүх насаар хорих байгууллагын харуул хамгаалалтыг зохион байгуулах албан хаагчдын болон хоригдлын аюулгүй байдалд гадаад орчноос ирэх аюул, эрсдэлээс хамгаалах, дотоод орчинд хоригдлуудын хооронд болон хоригдлууд ба хорих ангийн захиргааны албан хаагчдын хоорондын албаны болон хувийн харьцаанаас үүсэх аюултай байдлаас урьдчилан сэргийлэх,
- д) Бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтнуудыг аль болох ганцаарчлан хорихгүй байх, бусад хоригдлуудтай харьцах, аюултай байдлын эрсдэл, хоорондын нийлэмжтэй байдлыг нь харгалзан бусад хоригдолтой хамт хоригдох бололцоог олгох,
- е) Бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтнуудыг тэдгээрийн засрал хүмүүжилд гарсан ахиц өөрчлөлт, хөдөлмөр, спорт, урлагийн бусад сайн дурын арга хэмжээнд үзүүлсэн амжилтыг шат дараатайгаар урамшуулж, урам зориг өгч, итгэл үнэмшил төрүүлж замаар зан байдал, хандлагад сайнаар нөлөөлөх¹⁹ зэрэг болно.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Сүүлийн жилүүдэд цаазаар авах ялаас татгалзах, уг ялыг халах үйл явц сүүлийн жилүүдэд хүчтэй өрнөж, дэлхийн улсууд бүх насаар хорих ялыг хэрэглэх болсонтой холбоотойгоор уг ялыг оногдуулах, эдлүүлэхтэй холбоотой асуудлыг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд олон улсын жишиг, стандартад нийцүүлэн хуульчлах, уг ялаар шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангах асуудал чухлаар тавигдаж байна.
2. Энэ асуудалд НҮБ, түүний салбар байгууллагууд анхаарал хандуулан бүх насаар хорих ялыг хэрэглэх, оногдуулах, эдлүүлэхтэй асуудлыг хүний эрхийн олон улсын үндсэн баримт бичгүүд болон шүүх эрх мэдлийн салбарт хүний эрхийг хангахтай холбоотой жишиг дүрэм, журмуудад тодорхойлсон нь бүх насаар хорих ялын олон улсын эрх зүйн зохицуулалтын үндэс болжээ.
3. Европ тивийн улсууд (Беларусь улсаас бусад) цаазаар авах ялаас татгалзаж бүх насаар хорих ялыг хэрэглэдэг, иймээс уг ялыг хэрэглэх, оногдуулах үндэслэл, хэмжээ хязгаар, бүх насаар хорих ялыг эдлүүлэх зарчим, тавигдах нөхцөл шаардлага, бүх насаар хорих ял эдэлж байгаа ялантай харьцах, эрхийг хангах, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн болон бусад туслалцаа, үйлчилгээ зэрэг асуудлын нарийвчлан тусгасан бүс нутгийн хэмжээний механизм, эрх зүйн зохицуулалтыг бий болгосон туйлын ач

¹⁹ А.Диденко, В.Човган. Пожизненное заключение. Европейские стандарты и Украинская практика. Харьков. 2014. с

холбогдолтой, бусад тив, улсуудад үлгэр жишээ болж байгааг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

4. Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд Хүний эрхийн болон бүс нутгийн олон улсын байгууллагууд, их дээд сургуулиуд холбогдох судалгааг явуулж, түүнд үндэслэн бүх насаар хорих ялыг эдлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох зөвлөмжүүдийг гарган гишүүн орнууд хэрэгжүүлж байгаа сайшаалтай юм.

Иймээс манай улс бүх насаар хорих ялтай холбоотой дэлхийн болон бүс нутгийн олон улсын эрх зүйн баримт бичгүүд, зөвлөмжүүдийг сайтар судлан, хэрэгжүүлэх, тухайлбал: Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ялыг ялын тогтолцоонд бие даасан ялын төрөл болгон хуульчлах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд уг ялыг эдлүүлэх асуудлыг тусгайлан бүлэг болон хуульчлах, бүх насаар хорих ял эдлүүлэх тусгай салбарын (байрны) нөхцөл журам, уг ялыг эдэлж буй хоригдлын эрхийг хангах, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн болон бусад үйлчилгээ, дэмжлэг зэргийг олон улсын жишиг, стандартад ойртуулах, олон улсын байгууллагын зөвлөмж, гадаадын орнуудын сайн туршлагыг тусган хэрэгжүүлэх шаардлага чухлаар тавигдаж байна.

IV. НОМ ЗҮЙ:

Монгол эх сурвалж:

1. Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ.,1996
2. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. /эмхэтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо/. УБ., 2012.
3. Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм. ХЭҮК. УБ.,2002

Гадаад эх сурвалж:

1. Сборник стандартов и норм ООН в области предупреждения преступности и уголовного правосудия /на русском языке/. ООН.Нью-Йорк. 2016
2. А.Диденко, В.Човган. Пожизненное заключение. Европейские стандарты и Украин-ская практика. Харьков. 2014.
3. Хуторская Н.Б. Пожизненное лишение свободы в мире //ж.Уголовно-исполни-тельное право. 2018. № 13. с 67-69



Б.ЯНЖМАА

ХЭҮК-ын Судалгаа, мэдээллийн лавлагаа хариуцсан
ахлах мэргэжилтэн, судлаач

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ

RIGHTS OF THE CHILD AND CHILD PROTECTION IN THE DIGITAL ENVIRONMENT

Хураангуй: Хүүхэд хамгааллын зорилго нь Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хүчирхийллээс ангид байх, нийгмийн бүхий л орчинд хамгаалагдах эрхийг дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэхэд оршдог. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр зүйлд “Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.” гэсэн үүргийг хүлээсэн хэдий ч цахим орчинд хүүхдийн хамгаалуулах эрхийн зөрчил түгээмэл гарсаар байна. Энэ үүднээс цахим орчин дахь хүүхдийн хүчирхийллээс ангид байх эрхийн хэрэгжилтийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд судалж, дүгнэлээ.

Abstract: *The goal of child protection is to promote, protect and fulfil children's rights to protection from all forms of violence such as abuse, neglect, exploitation and the right to be protected in the social environment guaranteed by the Constitution, international treaties and conventions, as well as national legislation. Despite the fact that Article 19 of the Convention on the Rights of the Child states that "States Parties shall take all appropriate legislative, administrative, social and educational measures to protect the child from all forms of physical or mental violence, injury or abuse, neglect or negligent treatment, maltreatment or exploitation, including sexual abuse, while in the care of parent(s), legal guardian(s) or any other person who has the care of the child", violations of children's rights are still common in the online environment. From this point of view, the implementation of the right to freedom from violence in the online environment has been studied and concluded within the framework of the laws that come into force in Mongolia.*

Түлхүүр үг: *Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн хамгаалуулах эрх, цахим орчин, интернэт хэрэглээ, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл.*

Keywords: *Children's rights, child protection, digital environment, internet usage, crime, violation, violence*

I. УДИРТГАЛ

Хүүхэд бүхэн хувь хүний нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг эдлэх эрхтэй бөгөөд хүүхдийн эрх нь нийтлэг, салшгүй, харилцан хамааралтай, харилцан уялдаатай байдаг. Хүүхдийн эрхийг баталгаажуулсан гол баримт бичиг нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц бөгөөд конвенцыг 193 тал соёрхон баталж, бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцод Монгол Улс 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр нэгдсэн орсон. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь заалтад "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.", Хүүхдийн эрхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "Хүүхдийн эрхийн зарчим, нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг хэрэглэж болно." гэсэн заалтыг үндэслэн Хүүхдийн эрхийн тухай конвенц нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчинтэй эрх зүйн голлох эх сурвалж юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцод зааснаар хүүхэд бүхий л хэлбэрийн хүчирхийллээс хамгаалагдах эрхтэй бөгөөд цахим орчинд ч хамгаалагдах эрхтэй. Цахим орчин нь хүүхэд, залуучуудад харилцах, шинэ ур чадвар эзэмших, бүтээлч байх, сурч хөгжих, илүү сайн нийгэмд хувь нэмрээ оруулах олон боломжийг олгодог. Гэхдээ эсрэгээрээ ялгаварлан гадуурхалт, садар самуун, хүчирхийлэлд уруу татсан хууль бус контент, дарамт шахалт, хүчирхийлэл, цахим дээрэлхэлт, тэр ч байтугай бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх, хүүхдийг садар самуунд сурталчлах, уруу татагдах зэрэг эрсдэлүүдийг бий болгож байна.

НҮБ-ын тусгай илтгэгчийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийн талаарх тайланд сүүлийн жилүүдэд хүүхдүүд багаасаа цахим орчинд нэвтэрч, харилцаа холбоо, мэдээллийн хэрэгслийг ашиглаж байна. 2022 оны байдлаар цахим хэрэгсэл ашиглалт 34 хувиас 69 хувь болтлоо хоёр дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн Ковид-19 цар тахлын үед буюу 2020 оны 03 дугаар сараас 09 дүгээр сар хүртэлх хугацаанд хүүхдүүдийн фейсбүүкийн мессенжерийн өдөр тутмын ашиглалт 350 хувиар өссөн байгаагаас дүгнэхэд интернэт идэвхтэй ашиглах хүүхдүүдийн тоо тогтмол нэмэгдсээр байна.

Монгол Улсын хувьд 2022 оны 07 сарын байдлаар интернэтийн дэлхийн статистик үзүүлэлтээр нийт 3,365,992 иргэнээс 3,001,700 иргэн буюу 89,1 хувь нь интернэт хэрэглэгч байна. Интернэт хэрэглэгчдийг насаар нь ангилж харвал 15-19 насныхны 99 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэгэн байдлаар интернэтэд холбогдсон байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байсан тул цахим хэрэгслийн зүй зохистой хэрэглээ, цахим орчин дахь хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд дүгнэлт хийх үндэслэл болсон.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.11 дэхь заалтад “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.” гэж тус тус заасан.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Хүчирхийллийн бүхий л хэлбэрээс ангид байх хүүхдийн эрхийн тухай 13 дугаар Ерөнхий тайлбарт хүүхэд насанд хүрэгчдийн хүчирхийлэлд өртөж болзошгүй бөгөөд хүүхдүүдийн

дунд хүчирхийлэл бий болох боломжтой. Цаашлаад өөрсдийгөө аюулд оруулдаг. Хөвгүүд болон охид хоёулаа хүчирхийллийн бүхий л хэлбэрийн эрсдэлд байгаа боловч жендэрийн хувьд өөр өөр бүрэлдэхүүнтэй байна гэж тодорхойлсон байдаг.

Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан хүчирхийллийн бүхий л хэлбэр гэдэгт үл ойшоох, хайхрамжгүй хандах, сэтгэл зүй болон бие махбодын хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх, өөрийгөө гэмтээх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэх, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан хүчирхийлэх зэргийг хамруулдаг. Үүнээс мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслийг ашигласнаар хүүхэд дараах эрсдэлд өртөж болзошгүй байна. Үүнд:

- Хүүхдүүд түрэмгий, хүчирхийлсэн, заналхийлсэн, үзэн ядсан, арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан, садар самуунд уруу татагдах, төөрөгдүүлсэн бодит болон болзошгүй хор хөнөөлтэй зар сурталчилгаа, ухуулга мэдээ болон контентод өртөх;
- Цахим орчинд дарамт, хүчирхийлэлд өртөх, уруу татагдах, танихгүй хүнтэй уулзахаар ятгагдах, хувийн мэдээллээ алдах;
- Хүүхдүүд бусдыг дээрэлхэх, аюул учруулах, сэтгэл зүйн хөгжилд сөргөөр нөлөөлөх тоглоом тоглох, бэлгийн харилцааны шинжтэй зураг, бичлэг хийх, байршуулах, төөрөгдүүлсэн мэдээлэл, зөвлөгөө өгөх, зүй бус зүйлийг татаж авах, мөрийтэй тоглоом, санхүүгийн луйвар болон терроризмд татагдан орж болзошгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаар 13 дугаар Ерөнхий тайлбарт цахим орчин нь хүүхэд хүчирхийллийн хохирогч болох, өөртөө болон бусдад хор хөнөөл учруулах боломжийг нэмэгдүүлж, хүүхэд хүчирхийлэлд өртөх шинэ арга замыг бий болгох талтай. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч цахим технологийг хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд уруу татах, хүүхэд оролцуулсан бэлгийн харилцааны баримт, материалыг боловсруулах, түгээх, ийм үйлдлийг шууд бичлэгээр дамжуулах, бэлгийн дарамт шахалт үзүүлэх зэргээр ашиглах магадлалтай. Дээрэлхэх, нэр хүндийг гутаахаар заналхийлэх, гуйж эсвэл албадаж бэлгийн шинж чанартай контент зураг үүсгэх, бусдад тараах, өөрийгөө гэмтээх, амиа хорлох зэрэг өөртөө хохирол учруулах зан үйлийг сурталчлах зэрэг үйлдэл ийм зөрчилд багтана. Хүүхэд ийм үйлдэлд холбогдсон тохиолдолд Оролцогч улсууд урьдчилан сэргийлэх, хамгаалах, төлөвшүүлэх бүхий л боломжит арга хэмжээг авна гэж тайлбарласан.

Хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлийн шинжийг агуулсан үйлдэл бүр аюултай биш бөгөөд эрсдэл бүр хүүхдүүдэд хор хөнөөлийг бий болгодоггүй учир хүүхдүүдэд учрах эрсдэл эсхүл хор хөнөөлийн хооронд нь ялгаж, тус бүрд

нь зохих арга хэмжээг авах шаардлагатай байна. Тухайлбал, эрсдэл гэдэгт:

- Зохисгүй эсхүл гэмт хэргийн шинжтэй контент нь хүүхдийг өөрийгөө гэмтээх, хор хөнөөл учруулах, хүчирхийллийн шинжтэй авирлах зэрэгт хүргэдэг;
- Алдаатай, бүрэн бус мэдээлэл хүүхдийн дэлхий ертөнцийн талаарх ойлголтыг хязгаарладаг;
- Чиглүүлэх зорилготой алгоритмаар шүүсэн контент нь хүүхдийн хөгжил, үзэл бодол, үнэт зүйл, зуршилд ихээр нөлөөлдөг;
- Цахим орчинд дээрэлхэх нь оффлайн орчноос илүү хурдтай, өргөн хүрээнд тархдаг бөгөөд өдөр, шөнийн хэдийд ч тохиолддог. Иймд аюулгүй орон зай руу халдаж, тодорхойгүй нөхцөлийг бий болгодог.
- Оффлайн орчинд хохирсон хүүхэд цахим орчинд давхар хохирох магадлалтай.
- Гүтгэх болон нэр хүндэд халдах (бодлогогүй, санамсаргүйгээр үлдээсэн сэтгэгдлүүд олон хүн хүрэх, урт хугацаанд цахим орчинд байрших) зэрэг багтана.

Харин ЮНИСЕФ-ийн интернэтийн хэрэглээний талаарх судалгаанаас үзэхэд хор хөнөөл гэдэгт:

- Өөрийгөө хүчирхийлэх, өөрийгөө гэмтээх /Амиа хорлолт, ялгаварлан гадуурхалт/;
- Радикалчлал /үзэл суртлын ятгалга, үзэн ядсан хандлага/;
- Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг /бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн бэлгийн хүчирхийллийн материал боловсруулах, цуглуулах, тараах, хүүхэд хулгайлах, аялал жуулчлалд хүүхдийн бэлгийн мөлжлөгийг ашиглах/;
- Хувийн мэдээллийг хууль бусаар цуглуулсан, боловсруулсан, буруугаар ашигласан/ хакердах, хулгай, залилан/ зэргийг багтаасан.

Дээрх судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 20 орчим хувь нь өнгөрсөн жил өөрсдийнхөө бие махбодыг гэмтээж, хохироож буй хүмүүсийн бичлэг эсвэл онлайн хэлэлцүүлгийг үзсэн, цахимаар анх танилцсан хүнтэйгээ уулзсан, 2019 онд Internet Watch Foundation (IWF)-аас хүүхдийн бэлгийн хүчирхийллийн зураг, видеог агуулсан 132,000 гаруй веб хуудсыг илрүүлсэн зэргээс дүгнэхэд цахим орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөх нь шинэлэг арга хэлбэр бөгөөд хүчирхийллийг илүү өргөн агуулгаар ойлгож, нарийвчлан зохицуулах шаардлагатай байгааг илтгэж байна.

Нөгөө талаас цахимжих, интернэт хэрэглээ нэмэгдэхийн хэрээр бий болж буй хүчирхийлэл, сэтгэл санааны дарамтын нэг хэлбэр нь цахим дээрэлхэлт бөгөөд цахим технологи ашиглан дээрэлхэхийг ойлгоно. Энэ нь зорилтот хүмүүсийг айлгах, уурлуулах, тав тухгүй байдалд оруулах зорилготой давтагддаг үйл явцыг хэлдэг. Жишээ нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр

хэн нэгний тухай худал мэдээлэл тараах, тааламжгүй зураг, видео нийтлэх, доромжилсон, заналхийлсэн зурвас, зураг, видео бичлэгийг мессежээр явуулах, хэн нэгнийг дуурайж, тэдний өмнөөс болон хуурамч хаягаар бусад руу зурвас илгээх зэрэг цахим дээрэлхэлтэд ордог байна.

Монгол Улсын хувьд Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаарх судалгаагаар цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 2022 онд нийт 8563 бүртгэгдсэн бөгөөд нийт бүртгэгдсэн хэргийн 12 буюу 0.1 хувь нь согтуугаар, 397 буюу 4.6 хувь нь хүүхэд оролцож, 1966 буюу 22.9 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдсэн байна. Хохирогчдын хувьд гэмт хэргийн улмаас 8438 хүн хохирсны 3224 буюу 38.2 хувь нь эрэгтэй, 5214 буюу 61.8 хувь нь эмэгтэй, 83 буюу 1.0 хувь нь 11-17 насны хүүхэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 4103 буюу 94.6 хувь, эрэгтэй хүн 1639 буюу 2.0 дахин, эмэгтэй хүн 2464 буюу 89.6 хувь, хүүхэд 39 буюу 88.6 хувиар тус тус өссөн байна.

Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгаагаар “Хүүхдүүдийн 82 хувь нь зүй бус утгатай зурвас и-мэйл, фейсбүүкийн хэрэглэгчдээс авч байсан гэж үзсэн бол эцэг эхчүүдийн 93 хувь нь хүүхдээ цахим дарамт, дээрэлхэлтэд өртөж байсан гэж хариулсан нь цахим орчинд хүүхдийн эрх ноцтой зөрчигдөх болсныг гэрчилж байна. Түүнчлэн зүй бус зурвас, и-мэйлийн агуулгад гутаан доромжилж нэр төрд халдаж, дарамталсан, хувийн мэдээллийн нууцыг задруулсан, гэмт хэрэгт уруу татсан зэрэг үйлдлүүд зонхилж байна. Хүүхдүүдийн 43 хувь нь садар самууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан гэж хариулжээ. Хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, таван хүүхэд тутмын дөрөв нь цахимаар зүй бус утгатай зурвас авдаг ба эцэг эхчүүдийн ийм төрлийн сөрөг мэдээллийг шүүх программ хангамжийг ашиглах чадвар 95 хувьд нь огт байхгүй байна.” гэж дүгнэсэн.

Монгол Улсад цахим орчин дахь хүчирхийллээс ангид байх эрхийн хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Садар самуунтай тэмцэх тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль үйлчилж байна.

III. ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ

Хүүхдийн эрхийн тухай хууль

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй бөгөөд хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан

сэргийлэх, хамгаалах үүргийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хүлээсэн байна. Гэсэн хэдий ч Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгаагаар хүүхэд болон эцэг эхчүүдийн гурван хүн тутмын нэг нь цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргоо хийх мэдлэг, чадвар огт байхгүй байна. Тэдний дунд түвшний мэдлэг ойролцоо байхад хүүхдийн ахисан түвшний мэдлэг эцэг эхээсээ 3 дахин их байгаагаас дүгнэхэд цахим орчинд хүүхдийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын цахим орчны мэдлэг, ойлголт дутагдалтай байгаа нь дээрх эрхийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль

Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалах үүргийг хүлээсэн байна. Хэдийгээр үүрэгжүүлж байгаа нь сайн талтай хэдий ч үүргээ зөрчсөн эсхүл биелүүлэхгүй байгаа тохиолдолд ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй, хариуцлагын механизмыг зохицуулаагүй байна. Мөн, Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгаагаар эцэг, эхчүүдийн дийлэнх буюу 94 хувь нь интернэт орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашиглах чадваргүй, цахим орчинд хүүхдүүдийн хамгийн дотных нь туслагч нь үе тэнгийн найз нөхөд гэж 61.8 хувь хариулсан байхад сургуулийн багш, нийгмийн ажилтан гэж 8.7 хувийг эзэлж байгаагаас дүгнэхэд дээрх хуулийн заалт хэлбэрийн төдий байгааг илтгэж байна.

Хариуцлагын хүрээнд:

Эрүүгийн хуулийн Арван зургадугаар бүлэгт хүүхдийн эсрэг гэмт хэргийг тусгасан бөгөөд 16 дугаар зүйлийн 16.9 дэх хэсэгт кибер орчныг ашиглаж хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй болгосон нь цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалсан ганцхан зохицуулалт юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 34 дүгээр зүйлд “Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх, хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна” гэж зохицуулсан. Гэтэл Садар самуун явдалтай тэмцэх

тухай хуулиар садар самууныг сурталчлах, садар самуун явдлыг ерөнхийлөн тодорхойлсон бөгөөд садар самуун явдалд хүүхдийг ашиглах, уруу татах, сурталчлахдаа хүүхдийг оролцуулах, шахалт үзүүлэх, энэ талаар мэдээллээр хангах, хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах зэргийг тухайлан зохицуулаагүй байна.

Зөрчлийн тухай хуулиар:

- Хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан;
- Өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан;
- Өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор хууль бусаар хүүхдийн нэрийг барьж, ашиг олох, эсхүл амь нас, эрүүл мэнд, нэр хүндэд нь харшлах, аюул учруулах тоглоом, наадам, бусад арга хэмжээнд оролцуулсан тохиолдолд торгох шийтгэл оногдуулахаар заасан нь хүүхдийн эрхийг хамгаалсан зохицуулалт байна.

Эрүүгийн хуульд тусгагдсан цахим орчинд хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан зохицуулалтыг нарийвчлах, мөн, Эрүү болон Зөрчлийн тухай хуулиар цахим орчин дахь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлан гадуурхалт, цахим дээрэлхэлтийн талаар нэмж зохицуулах шаардлагатай байна.

Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчлийг бууруулахын тулд соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг шуурхай, тогтмол, бүх нийтийг хамарсан, хүртээмжтэй авах шаардлагатай байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар иргэн үр хүүхэд, өөрийн асрамжид байгаа насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулахгүй байх үүргийг хүлээсэн бөгөөд цахим орчинд хүүхдийн эрхийн зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зохицуулалтыг огт тусгаагүй байгааг анхаарах нь зүйтэй.

Кибер аюулгүй байдлын тухай хууль

Тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Иргэн кибер аюулгүй байдлыг хангахдаа өөрийн болон өөрийн асрамжид байгаа хүний кибер аюулгүй байдлыг хариуцах үүргийг хүлээнэ” гэж заасан хэдий ч Гэр бүл, хүүхэд залуучуудын газраас хийсэн цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цагаар цахим орчинд өнгөрүүлдэг ба 2 хүүхэд тутмын 1 нь садар самууныг сурталчилсан мэдээллийг тогтмол авдаг, 82 хувь нь зүй бус утгатай зурвасыг

и-мэйл, фейсбүүкийн хэрэглэгчдээс авч байсан, эцэг эхчүүдийн 95 хувьд нь энэ төрлийн сөрөг мэдээллийг хянах, хязгаарлах программ хангамжийн ур чадвар байхгүйгээс 93 хувь нь хүүхдээ цахим дарамтад өртөж байсан талаар дурдсан. Түүнчлэн Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгаагаар “Хүүхдийнхээ цахим хэрэглээнд эцэг эхчүүдийн 82 хувь нь их бага хэмжээнд хяналт тавьдаг гэсэн боловч цахим сүлжээ хэрэглэх мэдлэг, чадвар маш муу байсан” гэдгээс дүгнэхэд тус хуулийн заалт хэрэгжихгүй байгааг илтгэж байна.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль

Монгол Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг баталсан. Тус хуулиар хүүхдийн эрхтэй холбогдуулан “хүүхдийн бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан;”, “хүүхдийг гуйлга гуйхад, тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, өдөөн хатгасан, уриалсан, сурталчилсан;” мэдээлэл, бичлэгийг зөрчилтэй контент гэж тооцсон бөгөөд зөрчилтэй контентыг шийдвэрлэх, харилцан мэдээлэл солилцох чиглэлээр олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах суваг, олон нийттэй харилцах нэгжийг бий болгосон давуу талтай хууль болсон хэдий ч Ерөнхийлөгч хориг тавьж, хоригийг Улсын Их Хурал хүлээж авснаар 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүчингүй болсон.

Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль

Монгол Улсад 2023 оны байдлаар цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулагдаж байгаа бөгөөд хуулийн төсөлд санал авахаар цахим парламентын веб хуудсанд байршуулсан байна. Тус хууль нь цахим орчинд хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахим дарамт, заналхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар зарим нэр томъёоны тодорхойлолтыг тайлбарласан хэдий ч интернэт, мэдээлэл, харилцаа холбоо хурдтай хөгжихийн хэрээр бий болж буй шинэ ойлголт, нэр томъёог тайлбарлах шаардлагатай байна. Тухайлбал, хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн материал /CSAM/CSEM/, лайв стримийнг /live streaming/, урхидалт /grooming/, цахим бэлгийн дарамт.

Түүнчлэн, хуулийн төслийн гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх үйл явц нь боломжит хугацаанд даруй шийдвэрлэгдэх шаардлагатай бөгөөд цахим орчинд хурдацтай түгээгдэж байгаа хүүхдийн нэр төрд халдсан, эсхүл хүүхдийг садар самуунд, хүчирхийлэлд уруу татсан хууль бус контент,

мэдээллийг хянах, устгах, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хийх бие даасан нэгжтэй байх нь эрсдэлийг урьдчилан тодорхойлж, хор уршиг болохоос нь өмнө холбогдох арга хэмжээг авах боломжит нөхцөхийг үүсгэж болох юм.

Мөн, хуулийн төсөлд хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан хэдий ч тус хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг харах боломжгүй байсан тул дүгнэх боломжгүй болно. Гэхдээ тус хуулийн хэрэгжилтийн гол зохицуулалт нь хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх учир Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд тусгайлан нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

IV. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь 2020 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 5 дугаар бүлэгт интернэт хамгаалалтын асуудлыг тусгасан байна. БНХАУ-д насанд хүрээгүй хүмүүсийн интернэт хамгаалалтын хяналтыг бэхжүүлэх, хүүхдийн бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд аюултай үйл ажиллагаанд интернэтийг ашигласан тохиолдолд шийтгэл оногдуулах, аюулгүй интернэт орчин бүрдүүлэх үүрэгтэй Цахим орон зайн асуудал хариуцсан албатай байна. Цахим орон зайн асуудал хариуцсан алба, Нийтийн аюулгүй байдлын алба болон холбогдох бусад албатай хамтран хүүхдийн насны зөрүүг харгалзан бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй цахим мэдээллийн хэлбэр, хүрээ, стандартыг тодорхойлох, интернэт донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сурталчлах, соён гэгээрүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээ авах, хүүхдийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд хортой мэдээлэл агуулагдаж байгааг талаар байгууллага, хувь хүний гаргасан гомдлыг шийдвэрлэх, хортой мэдээллийг илрүүлсэн тохиолдолд холбогдох мэдээллийг нэн даруй зогсоох, холбоосыг устгах, хаах, түдгэлзүүлэх зэрэг арга хэмжээ авах, холбогдох бүртгэлийг хөтлөх үүрэгтэй.

Түүнчлэн насанд хүрээгүй хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувьд өөрсдийн интернэтийн мэдлэгээ сайжруулах, интернэт хэрэглээгээ зохицуулж, хүүхдийнхээ интернэт хэрэглээнд тавих удирдлага, хяналтыг чангатгах үүрэг хүлээдэг бол сургууль, номын сан, соёл, урлагийн төв, залуучуудын ордон болон бусад газруудын интернэт үйлчилгээний байгууламжууд насанд хүрээгүй хүнд зориулсан сүлжээний хамгаалалтын

программ хангамжийг суулгасан, аюулгүй байдлыг хамгаалах техникийн бусад арга хэмжээ авах үүрэг хүлээдэг байна.

Япон Улс

Үндэсний цагдаагийн газрын санхүүжилтээр 2006 оны 6 дугаар сараас эхлэн Интернэт үйлчилгээний төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд интернэт дэх хууль бус, хортой контентын талаар мэдээлэл хүлээн авч, хууль бус контентын талаар Цагдаагийн байгууллагад мэдэгдэх, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч болон вэбсайтын админуудад устгах хүсэлт гаргах зэргээр ажилладаг байна. Мөн, Япон Улсын парламент 2008 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Насанд хүрээгүй этгээдийн аюулгүй интернэт хэрэглээний орчин бүрдүүлэх тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль бэлгийн хүчирхийллийн талаарх хортой контент үзэх үзэлтийг бууруулж, хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах зорилготой.

Түүнчлэн интернэтээр дамжуулан хүүхдийг садар самуунд уруу татсан хууль бус, хортой мэдээллийн тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан 2005 оны 8 сард Дотоод хэрэг, харилцаа холбооны яамнаас “Интернэт дэх хууль бус/ хортой мэдээллийн эсрэг арга хэмжээний судалгаа”-г зохион байгуулсан бөгөөд үр дүнд нь нөхцөл байдлын талаар олон нийтэд сурталчилж, үүнд үндэслэн сайн дурын эсрэг арга хэмжээ авсан байна.

V. ДҮГНЭЛТ

1. Хүүхэд цахим орчинд сэтгэл зүй болон бие махбодын хүчирхийлэл, дээрэлхэлт, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх, хууль бус, хортой мэдээлэл хүлээн авах, садар самуунд уруу татагдах, ялгаварлан гадуурхагдах, гутаан доромжлогдох, хүнлэг бус харьцах, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх, өөрийгөө гэмтээх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэх, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан хүчирхийлэх нь шинээр бий болж байгаа хүүхдийн эрхийн ноцтой зөрчлийн нэг хэлбэр бөгөөд агуулгын хувьд өргөн хүрээтэй, нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байна.
2. Хүүхэд хүчирхийлэлд өртөх шинжээр нь эрсдэлтэй болон хор хөнөөлтэй гэж ялгаж, тус бүрд нь урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэг, зөрчлийн ангиллаар хариуцлага ногдуулах нь хүүхдийн эрхийг хамгаалах, сэргээн эдлүүлэхэд ач холбогдолтой байна.
3. Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй, хүүхдийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргийг эцэг, эх, харгалзан дэмжигчид үүрэг болгосон ч тэдгээрийн цахим

орчны мэдлэг, ойлголт хомс, интернэт орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашиглах чадваргүй байгаа нь хуулийн заалт хэлбэрийн төдий хэрэгжиж буйгаар илэрч байна.

4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд цахим орчинд хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохицуулалт орхигдуулсан байна.
5. Боловсруулагдаж буй Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд шинээр бий болж байгаа нэр томьёо, ойлголтыг нарийвчлан тайлбарлах, цахим орчинд хүүхдийн эрхийн хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн бие даасан нэгж ажиллуулах, тус хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах Эрүү болон Зөрчлийн тухай хуулиар тусгайлан зохицуулалт хийх шаардлагатай байна.
6. Цахим орчинд дахь хууль бус/хортой контентыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бөгөөд хортой мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх, илрүүлсэн тохиолдолд холбогдох мэдээлэл, бичлэгийг нэн даруй тусгуулах зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.

VI. САНАЛ

1. Хүүхдийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэгтэй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд цахим орчны мэдлэг, ойлголтыг тогтмол нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомж буюу Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэмт хэрэг, зөрчлийн тухай хуульд тодорхой тусгах, үүрэгжүүлэх.
2. Интернэт, мэдээлэл, технологийн хэрэгсэл ашиглаж буй хүүхдүүдэд цахим орчныг хэрхэн ашиглах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цахим орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарсан тохиолдолд хэнд хандах, үе тэнгийнхний цахим дээрэлхэлт, түүний хор нөлөөг таниулсан компани ажлыг зохион байгуулах.
3. Боловсруулагдаж буй Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг батлах хэрэгцээ, шаардлага байгаа бөгөөд шинээр бий болж буй нэр томьёо, ойлголтыг нарийвчлан тайлбарлах, цахим орчинд хүүхдийн эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг шуурхай шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх бие даасан нэгж ажиллуулах, тус хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах Эрүү болон Зөрчлийн тухай хуулиар тусгайлан зохицуулалт хийх шаардлагатай байна.

VII. НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, 1948
3. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989
4. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016
5. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016
6. Эрүүгийн хууль, 2015
7. Зөрчлийн тухай хууль, 2017
8. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998
9. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019
10. Кибер аюулгүй байдлын тухай хууль, 2021
11. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль, 2023

Монгол эх сурвалж:

1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, УБ., 2023, 207 дахь тал
2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан, УБ., 2018, 22 дахь тал.
3. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Олон нийтийн сүлжээнд хүний эрхийн хамгаалах тухай хуулийн үзэл баримтлал, УБ., 2023, 1 дэх тал.

Гадаад эрх сурвалж:

1. Committee on the Rights of the Child, general comment No. 16 on State obligations regarding the impact of the business sector on children's rights, 2013.
2. Joseph A. Cannataci, Report of the Special Rapporteur on the right to privacy, 2021. <https://www.internetworldstats.com/asia.htm>
3. Committee on the Rights of the Child, general comment No. 13 on the right of the child to freedom from all forms of violence, 2011.
4. International Telecommunication Union, Guidelines for policy-makers on Child Online Protection, 2020.
5. <https://www.unicef.org/end-violence/how-to-stop-cyberbullying>
6. Law of the People's Republic of China on Protection of Minors, 2020
7. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/convention-rights-child>
8. <https://www.mofa.go.jp/policy/human/child/congress0811-t.pdf>



Н.ОДОНТУУЛ

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн
Ерөнхий шүүгч, докторант

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

APPLICATION AND CRIMINALIZATION OF MEDICAL COERCIVE MEASURES AND THE LIMITS OF CRIMINAL CODES OF SOME COUNTRIES: COMPARATIVE STUDY

Хураангуй: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, эмчилгээний төрөл, хугацаа, бусад онцлогийг харьцуулан судалж, дүгнэлт хийхийг зорьсон ба судалгаанд ихэвчлэн эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудыг сонгож дүн шинжилгээ хийлээ.

Abstract: This academic paper aims to compare the justification for the application of medical coercive measures, their types, duration, and other features. Countries with mainly civil law systems were selected and analyzed in this study.

Түлхүүр үг: Албадан эмчлэх арга хэмжээ, хууль зүйн хариуцлага, эрүүгийн хариуцлага, өвөрмөц төрөл, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ

Keywords: Compulsory medical measures, legal liability, criminal liability, distinctive type, involuntary mental health treatment

Гадаадын зарим улсын Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хуульчилсан байдлыг харьцуулахдаа нэгдүгээрт Монгол Улстай нийгэм, эдийн засгийн хувьд уялдаатай, эрх зүйн шинэтгэлийн үйл явц ойролцоо улсууд болох, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, хоёрдугаарт Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний сайн туршлага бүхий Европын зарим орон болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Испанийн Хаант Улс, Бельгийн Хаант Улс, Бүгд Найрамдах Чех улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Грек Улс, гуравдугаарт Азийн орны төлөөлөл болох Япон, Израйл Улсыг сонгон судаллаа.

I. МОНГОЛ УЛСТАЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬД УЯЛДААТАЙ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ ОЙРОЛЦОО УЛСУУД

1. Оросын Холбооны Улс

ОХУ-ын өнөөгийн Эрүүгийн хууль 1996 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан. Тус улсын эрүүгийн эрх зүйн үзэл баримтлалын хувьд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь ял биш бөгөөд эрүүгийн хариуцлагын төрөлд ордоггүй. Энэхүү арга хэмжээний мөн чанар нь эм, эмчилгээний бусад хэлбэрээс бүрдэх ба өвчтөний амьдралын хэв маяг, нийгмийн харилцаа холбоо хэвээр үргэлжлэх боломжтойгоороо хоригдож буй хүнээс ялгаатай байна¹.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн Арван тавдугаар бүлэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэж эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хуульчилж, 97-104 дүгээр зүйлд уг арга хэмжээ хэрэглэх үндэслэл, төрөл дэглэм, хугацаа, ялтай хамт эдлүүлэх онцлогийн талаар хуульчилжээ.

Тус хуулийн 97 дугаар зүйлд Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

1. Шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг дараах этгээдэд оногдуулна:
 - а) Хэрэг хариуцах чадваргүй үедээ энэ хуулийн тусгай ангид тусгасан гэмт хэргийг үйлдсэн этгээдэд;
 - б) Гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн үйл ажиллагаа нь сарниж, ял оногдуулах буюу эдлүүлэх боломжгүй болсон этгээдэд;

¹ Калинина.Т.М., Принудительные меры медицинского характера: Понятие, виды, цели. Lex Russica. 2013. №6. С.623. https://nbpublish.com/library_get_pdf.php?id=24492

- в) Хэрэг хариуцах чадвартай сэтгэцийн өвчтэй этгээд гэмт хэрэг үйлдсэн.
- д) Арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн арван найман нас хүрсэн, эрүүл мэндийг үгүйсгэхгүй бэлгийн дур хүслийн эмгэг (педофили) өвчтэй.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан этгээдэд, түүний сэтгэцийн өвчин нь бусдад гэм хор учруулах боломжтой тохиолдолд зөвхөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулна”. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Холбооны бусад хуулийн дагуу тогтооно”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдэд, түүний сэтгэцийн өвчин нь бусдад гэм хор учруулах боломжгүй тохиолдолд шүүх ОХУ-ын эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн дагуу тус этгээдийг эмчлэх, сэтгэцийн эмнэлэг рүү шилжүүлэх асуудлаар эрүүл мэндийн байгууллагад баримт бичгийг шилжүүлнэ” гэж тус тус заажээ.

ОХУ-ын Эрүүгийн хуульд сэтгэцийн хувьд өөртөө болон нийгэмд аюултай этгээд гэж ямар хэв шинж бүхий этгээдийг ойлгохыг тодорхойлон тусгаагүй. Өөрөөр хэлбэл, шүүх хэвтэн эмчлүүлэх, эсхүл амбулаториор эмчлүүлэх албадлага хэрэглэх эсэхийг шийдвэрлэхдээ хуульд тусгайлан тодорхойлсноос эш татах бус өөрийн дотоод итгэл, хэрэгт авагдсан нотлох баримтуудад тулгуурлах шаардлага үүсдэг.

Харин ОХУ-ын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2011 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх тухай” зөвлөмжийг баталсан бөгөөд “сэтгэцийн хувьд өөртөө болон орчиндоо аюултай этгээдийн аюулын зэргийг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сэтгэцийн үйл ажиллагааны хэв шинжийг тодорхойлсон шинжээчийн дүгнэлтийг үндэслэх шаардлагатайг дурдсан ба гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, тухайлбал, бусдын эд хөрөнгийг устгах, галдан шатаах, эсхүл бусад арга хэрэгслээр бусдын өмчлөх эрхэд халдаж байгаа арга, үйлдлийн шинжид шүүх үнэлэлт, дүгнэлт өгөхийн чухлыг тэмдэглэсэн”².

Нөгөөтээгүүр, дан ганц шинжээчийн дүгнэлт, үйлдлийн шинжид анхаарах бус гэмт этгээдийн биеийн хүчний байдал буюу өөрийн санаа зорилгыг гүйцэлдүүлэх чадамжийг харгалзах боломжтой гэсэн нь сонирхол татдаг. Шинжээч томилсон шийдвэрт хэд хэдэн тодорхой асуулт тавигдсан байх шаардлагатайг Дээд шүүхийн зөвлөмжид дурдагдсан байна. Үүнд:

- а) гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэцийн өөрчлөлт, хямралын түвшин, шинж чанар ямар хэмжээнд байсан;

² Постановление Пленума Верховного Суда Российской Федерации, *О практике применения судами принудительных мер медицинского характера*, №6, 2011. <https://rg.ru/2011/04/20/verhovniy-sud-dok.html>

- б) гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдлийн шинж чанар, нийгмийн аюулын шинжийг ухамсарлах чадвартай байсан эсэх;
- в) гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сэтгэцийн эмгэг нь цаашид өөртөө болон бусдад аюултай эсэх;
- г) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай эсэх, хэрэв шаардлагатай бол ямар төрлийн арга хэмжээ зохистой эсэх зэрэг асуулт тавигдаж, үүнд үндэслэн дараа дараагийн шийдвэрийг гаргах нь зүйтэй гэж үзжээ.

Шинжээчийн дүгнэлт нь зөвхөн зөвлөмжийн шинжтэй гардаг. Өөрөөр хэлбэл, шүүх заавал шинжээчийн дүгнэлтийг шууд үндэслэлээ болгох албагүй бөгөөд гагцхүү хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудтай харьцуулан дүгнэсний эцэст шинжээчийн дүгнэлтийг үндэслэлээ болгох эсэх, эсхүл тодорхой нөхцөл байдлыг хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэх бүрэн эрхтэй байна³.

Түүнчлэн ОХУ-ын эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх зорилго”-ыг тусгайлан зааж өгсөн нь уг арга хэмжээг ялаас ялгаж үзэх, түүний агуулга, мөн чанарыг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой зохицуулалт болжээ. Тус хуулийн 98 дугаар зүйлд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх зорилго нь энэ хуулийн 97 дугаар зүйлд заасан этгээдийг эмчлэх, тэдгээрийн сэтгэцийн байдлыг сайжруулах, мөн энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг шинээр үйлдэхээс зайлсхийхэд оршино.” гэжээ.

Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлд Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг дараах байдлаар хуульчилсан: а) эмнэлгийн албадан хяналтад эсхүл сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтад байлгах; б) сэтгэцийн эмгэг судлалын ердийн эмнэлэгт байлгах; в) сэтгэцийн эмгэг судлалын тусгай эмнэлэгт байлгах; г) сэтгэцийн эмгэг судлалын хүч нэмэгдүүлсэн хяналттай эмнэлэгт байлгах.

Хэвтэн эмчлүүлэх арга хэмжээг эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй, сэтгэцийн хувьд хүнд өвчтэй буюу зайлшгүй асрамж, анхаарал, байнгын сувилгаа шаардлагатай хүмүүст хэрэглэдэг бол амбулаториор эмчлүүлэх арга хэмжээг сэтгэцийн хувьд эмгэгтэй боловч хэвтэн эмчлэх шаардлагагүй, орчиндоо аюул учруулах нь бага хүмүүст хэрэглэх боломжийг хууль тогтоогч олгосон байна.

³ 2012 онд ОХУ даяар нийт (хэвтэн эмчлэх 3 төрлийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг багтаасан) 9007 шинжээчийн дүгнэлт гарч, шүүхэд хүргэгдсэнээс 4662 хүнд хэвтэн эмчлэх албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн буюу шинжээчдийн зөвлөмжөөс 48.2 хувиар бага хүнийг албадан эмчлэхээр шийдвэрлэсэн байна. 2013 онд 8880 шинжээчийн дүгнэлт гарсан бол 5121 хүнд албадлагын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн ажээ. Харин амбулаториор эмчлэх шаардлагатай гэх хүмүүсийн хувьд 2013 онд 1300 шинжээчийн дүгнэлт гарсан боловч шүүх 1683 буюу зөвлөмжид зааснаас 29.5 хувиар их, 2013 онд 1481 дүгнэлт гарсан боловч 1682 буюу 13.6 хувиар их хүнд энэ төрлийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн байна. Үүнээс дүгнэхэд шүүхүүд тэр бүр шинжээчийн дүгнэлтэд шууд үндэслэж шийдвэр гаргадаггүй, хэвтэн эмчлэхээс илүүтэй амбулаториор эмчлэх арга хэмжээг сонгон хэрэглэх практик түгээмэл ажиглагджээ.

Дээр дурдсанаар энгийн төрлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа гэмт хэрэг үйлдсэн этгээд нь эмнэлэг болон түүний эргэн тойронд чөлөөтэй зорчих, эмчийн заасан цагт саадгүй байх үүрэгтэйн дээр эмчийн зөвшөөрснөөр гэрээрээ зочлох эрхтэй байдаг. Эдгээр хүмүүст сэтгэцийн байдлаас нь шалтгаалан хэвтүүлэн эмчлэх, хянах шаардлагатай боловч эрчимт хяналт шаардагддаггүй, тэднийг зайлшгүй тусгаарлах, бие махбодод нь хүч хэрэглэх хэрэгцээ байдаггүй.

Тусгай төрлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа этгээдүүдийн хувьд нийгэмд илүү аюултай байдаг бөгөөд эмнэлгийн байгууллагын зүгээс тэдгээрийн эмнэлгээс оргон зайлах боломжийг хязгаарлах арга хэмжээ авч, өвчтөнүүдэд нарийн мэргэжлийн нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх, залруулах, нөхөн сэргээх эмчилгээний аргуудыг ашигладаг.

Харин эрчимт тусгай эмнэлэгт буй этгээдүүдийн хувьд нийгэмд ноцтой аюул заналхийлж, урьд олон удаагийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүс байна. Эдгээр хүмүүс гол төлөв эмнэлгийн ажилтнуудын эрх, эрх чөлөөнд халдах, оргон зайлах, үймээн самуун дэгдээх хандлагатай байдаг ба ийм хүмүүсийг эмчлэхэд нэн бэрхшээлтэйд тооцогддог ажээ.

Эдгээр эмнэлгүүд нь тусдаа барилга байгууламжид байрладаг гэхээсээ илүүтэй сэтгэцийн томоохон эмнэлгүүдийн төрөлжсөн тасгууд байдаг ба видео тандалт, дохиолол, явган хүний зам зэргийг ашиглаж, хяналтаа хэрэгжүүлдэг. Эдгээр эмнэлгүүдэд өвчтөнийг хуваарилахдаа тэдгээрийн оршин суух газрын харьяаллыг харгалзах дүрэм үйлчилнэ⁴.

Амбулаториор эмчлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ шүүх эрүүгийн хариуцлагатай давхар хэрэглэж болдог. Өөрөөр хэлбэл, тэнсэн харгалзах хугацаанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх, эсхүл хөнгөн ял шийтгэл оногдуулсан бол ялыг биелүүлсний дараа хэрэглэхээр заах боломжтой байдаг байна. Харин эдгээр нөхцөл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэргийн хохирол, хор уршиг зэргээс харилцан хамааралтай болно⁵.

Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлд Эмнэлгийн албадан хяналтад эсхүл сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтад байлгах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онцлогийг дараах байдлаар хуульчилсан нь онцлог байна. “Эмнэлгийн албадан хяналт эсхүл сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтад байлгах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг энэ хуулийн 97 дугаар зүйлд заасан сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байрлах шаардлагагүй этгээдийн хувьд оногдуулна” гэжээ.

⁴ Калинина Т. М., *Принудительные меры медицинского характера: Понятие, виды, цели*, Lex Russica, №6, С.629. 2013. https://nbpublish.com/library_get_pdf.php?id=24492

⁵ Калинина Т. М., *Принудительные меры медицинского характера: Понятие, виды, цели*, Lex Russica, №6, С.630. 2013. https://nbpublish.com/library_get_pdf.php?id=24492

Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байлгах: Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт үзүүлж чадахуйц эмчилгээ, арчилгаа, хяналт, байршлын нөхцөл, хяналт нь таарсан гэж үзвэл 97 дугаар зүйлд заасан этгээдийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байлгах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэнэ.

Сэтгэцийн байдлын хувьд хэвтэж эмчлүүлэх шаардлагатай хэдий ч хяналтад байх шаардлагагүй этгээдийг энгийн дэглэмтэй, сэтгэцийн байдлын хувьд хяналтад байх шаардлагатай этгээдийг тусгай дэглэмтэй, сэтгэцийн байдлын хувьд өөрийн хувьд болон бусад этгээдийн хувьд аюултай, хүч нэмэгдүүлсэн хяналттай байх шаардлагатай этгээдийг тусгай дэглэмтэй хүч нэмэгдүүлсэн хяналт бүхий сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байлгах арга зохицуулжээ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх буюу зогсоох: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх буюу зогсоох асуудлыг тус арга хэмжээг хэрэгжүүлж буй байгууллагын саналаар сэтгэл мэдрэлийн эмч нарын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулсан этгээд нь ийнхүү арга хэмжээг өөрчлөх буюу зогсоох асуудлыг шийдвэрлэхийн тулд зургаан сард нэгээс доошгүй удаа сэтгэл мэдрэлийн эмч нарын үзлэгт хамрагдах ёстой. Ийнхүү арга хэмжээ явуулах санаачилгыг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах буюу өөрчлөх боломжтой хэмээн тус этгээдийг эмчлэгч эмч тооцож, гаргах бөгөөд мөн эмчлүүлж буй этгээд өөрөө, түүний хууль ёсны төлөөлөгч эсхүл/ буюу ойрын төрөл садны хүнээс хүсэлт гаргаж болно. Тус хүсэлтийг дээрх арга хэмжээ явагдсан огнооноос үл хамаарч, хүссэн үедээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлж буй байгууллагын удирдлагад гаргана. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох буюу өөрчлөх үндэслэл үгүй хэмээн тус арга хэмжээг хэрэгжүүлж буй байгууллага үзвэл шүүхэд арга хэмжээг сунгах талаар дүгнэлт гаргана. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эхний сунгалтыг эмчлүүлж эхэлснээс хойш зургаан сарын дараа гаргах ба дараагийн сунгалтыг хагас жилд нэг удаа хийнэ.

Шүүх тус эмчлүүлэгч этгээд өмнө нь оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй, эсхүл өөр төрлийн эмнэлгийн албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай хэмээн үзвэл тус арга хэмжээг өөрчилж эсхүл зогсоож болно.

Сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэрэгжүүлж байсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоосон тохиолдолд шүүх ОХУ-ын эрүүл мэндийн тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу тус этгээдийг нийгмийн халамжийн эрүүл мэндийн байгууллагад түүний баримт бичгийн хамт шилжүүлж болно.

Гэмт хэрэг үйлдсэний дараа буюу ял эдэлж байх үедээ сэтгэцийн өвчтэй болсон, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж байсан этгээдэд уг өвчнийг эдгэрсний дараа сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байх нэг өдрийн нэг өдрийн хорих ялтай дүйцүүлэн тооцохоор зохицуулжээ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ялтай хамтад нь эдлүүлэх: ОХУ-ын эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлийн хоёрдугаар хэсэгт заасан тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хорих ял эдэлж буй газарт нь, харин өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдүүдийн хувьд сэтгэц эмгэг судлалын эмнэлгийн байгууллагад эдлүүлнэ. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ялтай хамтад нь эдлүүлэх арга хэмжээг зогсоох асуудлыг сэтгэл мэдрэлийн эмч нарын дүгнэлтийг үндэслэн ялыг хэрэгжүүлж буй байгууллагын тодорхойлолтоор шүүх шийдвэрлэнэ⁶.

Харин гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан тэнсэн харгалзах хугацаанд, эсхүл хөнгөн ял эдэлж байх хугацаанд түүнийг хэвтэн эмчлүүлэх шаардлагатай гэж үзвэл эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шүүх амбулаториор эмчлэх албадлагын арга хэмжээг өөрчилж, хэвтэн эмчлэх арга хэмжээ хэрэглэх эрхтэй. Эсрэгээрээ тухайн этгээдэд авсан хэвтэн эмчлэх албадлагын арга хэмжээг өөрчлөх нөхцөл байдал бүрдсэн гэж үзвэл амбулаториор эмчлэх арга хэмжээгээр өөрчлөх боломжтой болно⁷. Дээрх зохицуулалтаас үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлд Монгол Улстай харьцуулахад дараах онцлог зохицуулалт байна. Тухайлбал, хэрэг хариуцах чадвартай сэтгэцийн өвчтэй этгээд гэмт хэрэг үйлдсэн, 14 насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 18 нас хүрсэн, эрүүл мэндийг үгүйсгэхгүй бэлгийн дур хүслийн эмгэг (педофили) өвчтэй⁸ хүнд хэрэглэх боломжтой гэжээ. Өөрөөр хэлбэл, ОХУ-ын эрүүгийн хуульд хэрэг хариуцах хязгаарлагдмал чадамжтай болон сэтгэцийн эмгэг болон бэлгийн гаж зан үйлд хариуцлага тооцож байгаа нь дэвшилттэй зохицуулалт байна.

2. Бүгд Найрамдах Казахстан Улс

Казахстан улсын Эрүүгийн хууль 1997 оны 07 дугаар сарын 16-ны өдөр батлагджээ⁹. Казахстан нь 1991 оны 12 дугаар сарын 16-ны өдөр ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнээс гарч, бүгд найрамдах улсын статусыг олсон¹⁰ бөгөөд постсоциалист улсын хувьд шинэ үеийн түүх, төрийн байгуулал, эрх зүйн тогтолцооны тухайд манай улстай

⁶ Калинина Т. М., *Принудительные меры медицинского характера: Понятие, виды, цели*, Lex Russica, №6, С.622. 2013. https://nbpublish.com/library_get_pdf.php?id=24492

⁷ Уголовный кодекс Российской Федерации, 1996. <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody&nd=102041891>

⁸ Эдгээр заалтыг 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 14-FZ Холбооны хуулиар нэмэлтээр оруулсан.

⁹ Уголовный кодекс Республики Казахстан, 1997. https://kodeksy-kz.com/ka/ugolovnyj_kodeks.htm

¹⁰ Linz J., Stepan A., *Problems of Democratic Transition and Consolidation: Southern Europe, South America and Post-Communist Europe*, Baltimore and London, Johns Hopkins University Press, P.480.1996.

ижил гараанаас гарч, хууль зүйн хөгжлөөр ололт дэвшлийг олон салбар эрх зүйд хэрэгжүүлж яваа гэж тодорхойлж болох юм.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тус улсын Эрүүгийн хуулийн 91-98 дугаар зүйлүүд зохицуулсан бөгөөд уг арга хэмжээний зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эмчлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийг дээрдүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс нь сэргийлэх гэж заажээ.

Шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг а) гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй; б) гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй болсон; в) гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй бөгөөд цаашид хэрэг хариуцах чадваргүй; г) гэмт хэрэг үйлдсэн бөгөөд сэтгэцэд өөрчлөлт оруулах чадвартай төрөл бүрийн бодис хэрэглэх зуршлын улмаас сэтгэц, зан үйлийн эмчилгээ шаардлагатай байгаа; д) хэрэг үйлдэх үедээ 18-аас дээш настай байсан бөгөөд насанд хүрээгүй хүний бэлгийн халдашгүй байдалд халдсан этгээдэд уг арга хэмжээг хэрэглэхээр хуульд тус тус зохицуулжээ.

Дээр дурдсан тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг гэмт хэрэг үйлдсэн этгээд өөртөө болон бусдад аюул, хор, хохирол учруулж болзошгүй тохиолдолд хэрэглэхээр заасан бөгөөд зан байдлын хувьд нийгэмд аюултай гэж тооцохооргүй бол түүнд албадлагын арга хэмжээ авах шаардлагагүй байдаг байна¹¹.

Казахстан улсад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний 5 төрөл хэрэгждэг бөгөөд эдгээрээс дурдвал:

1. Сэтгэцийн эмчийн хараа хяналт дор амбулаториор албадан эмчлэх (тухайн этгээд өөртөө болон бусдад аюулгүй бол),
2. Энгийн төрлийн сэтгэцийн эмнэлэгт албадан эмчлэх (тухайн этгээдийн сэтгэцийн үйл ажиллагаанд тодорхой эмчилгээ, арчилгаа, ажиглалт шаардлагатай бол),
3. Тусгай төрлийн сэтгэцийн эмнэлэгт албадан эмчлэх (тухайн этгээдийн сэтгэц, зан үйлд дээрхээс гадна байнгын ажиглалт шаардлагатай бол),
4. Эрчимт тусгай төрлийн сэтгэцийн эмнэлэгт албадан эмчлэх (өөртөө болон бусдад нэн аюултай бөгөөд сэтгэц, зан үйлийн хувьд эмчилгээ, байнгын ажиглалт шаардлагатай бол),
5. Бэлгийн хүчирхийлэл үйлдэх донтой этгээдэд химийн албадан эмчилгээ хийх зэрэг болно.

Нөгөөтээгүүр, гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах чадваргүй байсан бөгөөд хожим уг нөхцөл байдал арилсан боловч сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх донтойн улмаас

¹¹ Уголовный кодекс Республики Казахстан, 1997. <https://adilet.zan.kz/rus/docs/K1400000226>

сэтгэц, зан үйлийн эмчилгээ шаардлагатай байгаа этгээдэд шүүх эрүүгийн хариуцлага оногдуулахаас гадна уг донтох өвчний эсрэг эмчилгээ хийлгэхээр даалгах болон сэтгэцийн эмчийн хяналтад амбулаториор эмчлэхээр даалгах эрхтэй байна¹².

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дэглэмийг өөрчлөх, хугацааг сунгах, дуусгавар болгоход сэтгэцийн эмч нарын комиссын дүгнэлт, эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэдэг.

Албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн уг арга хэмжээг хүчингүй болгуулах асуудлаар сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага арга хэмжээ авагдсанаас хойш 6 сард нэг 1 удаа санал гаргах, хэрэв тийнхүү өвчтөний эрүүл мэндийн байдал сайжраагүй, цаашид эмчилгээ шаардлагатай гэж үзвэл уг хугацааг сунгах саналаа шүүхэд гаргах ёстой ба улмаар уг хугацаанаас хойш жилд 1 удаа сунгах, эсхүл хүчингүй болгуулах санал гаргахаар хуульд зохицуулсан байна.

Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, эсхүл эрүүгийн хариуцлага хүлээж байх явцдаа (хорих ял эдэлж байх үедээ) хэрэг хариуцах чадваргүй болсон бол шүүх түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, өвчтөн тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор эдгэрсэн бол шүүх түүний эдэлбэл зохих, эсхүл эдлээгүй үлдсэн ялыг үргэлжлүүлэн эдлүүлэхээр шийдвэрлэж болно. Ингэхдээ түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 1 хоногийг 1 хоногийн хорих ялтай дүйцүүлэн нийт эдлэх хорих ялаас нь хасаж тооцдог байна¹³.

Казахстан улсын хувьд хэрэг хариуцах чадваргүй боловч төлбөрийн чадваргүй этгээдүүдийн үйлдсэн гэмт хэргийн тухайд хохирогчид баримтаар бодит хохирол учирсан бол Хохирогчид нөхөн олговор олгох сангийн тухай хуульд зааснаар төрөөс урьдчилан нөхөн олговор олгож, уг мөнгөн хөрөнгийг гэмт хэрэг үйлдсэн этгээдээс албадан гаргуулахаар шүүхийн шийдвэрт зааж өгдөг¹⁴ нь ОХУ, Киргиз улстай харьцуулахад онцлог юм.

Тус улсын Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлд зааснаар хэрэг хариуцах чадваргүй этгээд:

- а/ хөнгөн гэмт хэрэг үйлдсэн бол тухайн үеийн амьжиргааны баталгаажих түвшинтэй тэнцэх хэмжээний мөнгийг (Казахстан Улсын тенге гэх мөнгөн тэмдэгт) 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгийг,
- б/ хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн бол тухайн үеийн амьжиргааны баталгаажих түвшинтэй тэнцэх хэмжээний мөнгийг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгийг,

¹² Уголовный кодекс Республики Казахстан, 1997. <https://adilet.zan.kz/rus/docs/K1400000226>

¹³ Балтабаев Ю. Ж., Дрокин Ю. Н., *Проблемы уголовно-исполнительного законодательства Республики Казахстан и его применения*, Уголовно-исполнительное право, 2-ое изд., С.170, 2020. <https://www.elibrary.ru/item.asp?id=43963161>

¹⁴ Закон о Фонде компенсации потерпевшим, 2018. https://online.zakon.kz/Document/?doc_id=32981304#pos=168; С.63.

- в/ хүнд гэмт хэрэг үйлдсэн бол тухайн үеийн амьжиргааны баталгаажих түвшинтэй тэнцэх хэмжээний мөнгийг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгийг,
- г/ онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол тухайн үеийн амьжиргааны баталгаажих түвшинтэй тэнцэх хэмжээний мөнгийг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгийг гэмт хэрэг үйлдсэн этгээдээс гаргуулахаар шийдвэрлэдэг байна.

Хохирогчид нөхөн олговор олгох сангийн тухай хууль нь 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан бөгөөд зөвхөн төлбөрийн чадваргүй бөгөөд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт бус бэлгийн халдашгүй байдалд нь халдсан насанд хүрээгүй хохирогч, гэмт хэргийн улмаас ДОХ-ын халдвар авсан хохирогч зэрэг бусад төрлийн тодорхой гэмт хэргүүдэд нөхөн олговор олгохоор заасан.

Түүнчлэн, Казахстан улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн 1999 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 08 дугаар тогтоолоор “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авахад анхаарах зарим асуудал”-ын талаар зөвлөмж гаргасан байна. Үүнд: шүүх хэрэг хариуцах чадваргүй этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах, хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн төрлийг сонгохдоо тухайн этгээдийн зан байдал буюу өөртөө болон бусдад аюултай эсэхэд нарийн үнэлэлт дүгнэлт өгч, дахин гэмт хэрэг үйлдэх талаар үндэслэл бүхий сэжүүр, нотлох баримт байгаа эсэхийг баттай тогтоосны үндсэн дээр эмнэлгийн төрлийг сонгох нь зүйтэйг тэмдэглэжээ¹⁵.

Ийнхүү тогтоох үндэслэл нь нэг талаар шүүгчийн дотоод итгэл байхаас гадна шинжээчийн дүгнэлт чухал үүрэгтэй. Шинжээч дүгнэлт гаргахдаа тухайн этгээдийн ар гэрийн хүмүүсийн тодорхойлолт, сургалт-хүмүүжлийн нөхцөл байдал, түүх буюу оюуны хоцрогдолтой хүүхдүүдийн сурган хүмүүжүүлэх байгууллагад суралцаж байсан эсэх, гэмтэл, осолд орж байсан эсэх, сэтгэцийн эмнэлэгт эмчлүүлж байсан эсэх, урьд сэтгэцийн байдлаас шалтгаалан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөж байсан эсэхийг тогтоохоос гадна эрүүгийн хавтаст хэрэгт тухайн этгээд архинд донтох, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг гэх нотлох баримт байгаа бол уг хүнд эрүүгийн хариуцлага оногдуулахын зэрэгцээ архи, мансууруулах бодисын эсрэг эмчилгээнд давхар хамруулах шаардлагатай эсэхэд мөн дүгнэлт гаргах шаардлагатай¹⁶ гэжээ.

Нөгөөтээгүүр, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар хэрэг хариуцах чадваргүй этгээдийн хууль ёсны төлөөлөгчөөр

¹⁵ Верховный Суд Республики Казахстан, “Нормативное постановление о судебной практике по применению принудительных мер медицинского характера”, 1999. https://adilet.zan.kz/rus/docs/P99000008S_

¹⁶ Верховный Суд Республики Казахстан, “Нормативное постановление о судебной практике по применению принудительных мер медицинского характера”, 1999. https://adilet.zan.kz/rus/docs/P99000008S_

эцэг эх, үрчилсэн, үрчлүүлсэн, төрсөн, эсхүл нэг эцэг, эхээс гарсан ах, эгч, дүү, эмээ, өвөө, ач, гуч байх боломжтой. Хэрэв тухайн этгээдэд төрөл садны хүн байхгүй тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчөөр тодорхой төрийн байгууллага, өмгөөлөгч нь байх боломжтой¹⁷ нь онцлог байна.

Түүнчлэн, шүүхийн шийдвэрт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах хугацаа заадаггүй. Өөрөөр хэлбэл, өвчтөний эдгэрэх хугацааг урьдаас тодорхойлох боломжгүй ба харин эмч нарын комиссын ээлжит (6 сарын дотор) дүгнэлтийн үндсэн дээр албадлагыг үргэлжлүүлэх, дуусгавар болгох эсэхийг шийдвэрлэх боломжтой юм.

Казахстан улсад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа үндэслэл, нөхцөл байдал нь ОХУ-тай зарим талаар ижил байх хэдий ч бас онцлог тогтолцоо ч байгаа нь харагдаж байна. Тухайлбал, хэрэг хариуцах төлбөрийн чадваргүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт төрөөс нөхөн олговор олгож, гэм буруутай этгээдээс хожим нөхөн гаргуулах тогтолцоо хэрэгжиж байгаа нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чухал хөшүүрэг болж буй юм.

Өөрөөр хэлбэл, тодорхой гэмт хэргийн улмаас хохирол, хор уршиг хүлээсэн хүний эрүүл мэндийн байдал нь түүний ажил, амьдралын хэвийн горимыг алдагдуулсан, нөхөн сэргэхэд удаан хугацаа шаардлагатай зэрэг онцлог тохиолдолд энэ нь иргэний эрхийг урьдаас төр хамгаалалтдаа авч байгаа хэлбэр гэж үзэж болохын зэрэгцээ хор уршигийн хэр хэмжээг даамжруулахгүй байх, даруй арга хэмжээ авч, таслан зогсоож байгаа сайн туршлага гэж үзэхээр байна.

Тус улсын Дээд шүүхийн зөвлөмжид дурдсанаар эмнэлгийн чанартай арга хэмжээг шүүхүүд хуульд зааснаар хэрэгжүүлэхээс гадна уг асуудалд туйлын анхааралтай байж, хэрэг хариуцах чадваргүй этгээдийн эрх зүйн байдал, зан үйлийг нарийвчлан тогтоож, албадлагын арга хэмжээний ямар төрлийг сонгон хэрэглэх, цаашлаад тодорхой донтох зуршлын эсрэг эмчилгээ шаардлагатай эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхийн чухлыг дурдсан нь практик ач холбогдолтой зохицуулалт юм.

3. Бүгд Найрамдах Киргиз Улс

Бүгд Найрамдах Киргиз Улсын эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлд “Нийгэмд аюултай үйлдэл хийх үедээ өөрийн үйлдлийн хууль зүйн шинжийг ойлгохгүй, түр зуурын оюуны саатал, тэнэгрэл болон бусад сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийг хянах чадваргүй байсан хүнд эрүүгийн хариуцлага оногдуулахгүй”. “Хэрэг хариуцах чадваргүй хүнд шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэж заасан нь ОХУ, БНКУ-тай ижилхэн зохицуулалт байна.

¹⁷ Уголовно-процессуальный кодекс Республики Казахстан, 2014. <https://adilet.zan.kz/rus/docs/K1400000231>

Эрүүл боловч тодорхой оюуны саатлын улмаас өөрийн үйлдлийн бодит мөн чанарыг ойлгож, ухамсарлах чадваргүй байсан хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно. Уг нөхцөл байдал нь гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахад харгалзан үзэх үндэслэл болох бөгөөд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шалгуур болно.

Хорих ял шийтгэгдсэний дараа сэтгэцийн өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдэд шүүх эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ялтны эдлээгүй үлдсэн хорих ялтай тэнцүү хугацаагаар хэрэглэх бөгөөд хэрэг хариуцах чадваргүй байдал уг хугацааны дотор арилсан бол шүүх үлдэх хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэнэ. Тус Улсын эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэгт “Албадлагын болон эмнэлгийн чанартай бусад арга хэмжээ” гэсэн зохицуулалтыг хуульчилж өгсөн бөгөөд эрүүгийн хариуцлагын төрөл гэж хуульчлаагүй бөгөөд гэмт этгээдийг нийгмээс тусгаарлаж, гэмт хэрэг дахин үйлдэхээс нь урьдчилан сэргийлгэх зорилгоор хэрэглэнэ гэж хуульчилжээ.

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, эсхүл гэм буруутайд тооцохоос өмнө, эсхүл дараа хэрэг хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдэд шүүх дараах төрлийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авахаар эрүүгийн хуулийн 91-92 дугаар зүйлийн холбогдох хэсгүүдэд зааж, агуулгыг тодорхойлсон: 1) сэтгэцийн эмчийн хяналтад амбулаториор албадан эмчлэх; 2) сэтгэцийн эмнэлэгт ердийн хяналтад эмчлэх; 3) сэтгэцийн эмнэлэгт эрчимжүүлсэн хяналтад эмчлэх; 4) сэтгэцийн эмнэлэгт онцгой хяналтад эмчлэх гэжээ¹⁸.

- Сэтгэцийн эмчийн хяналт дор амбулаториор албадан эмчлэх гэдэгт сэтгэцийн эрүүл мэндийн байдал нь тогтвортой бөгөөд хөнгөн хэлбэрийн сэтгэцийн өвчтэй хүмүүсийг сэтгэцийн эмчийн хяналт дор амбулаториор албадан эмчилж, тэдгээрийн өвчнийг даамжрахаас сэргийлж, нийгэмд аюултай гэмт үйлдэл хийхээс нь сэргийлэх арга хэмжээг ойлгоно.
- Сэтгэцийн эмнэлэгт ердийн хяналт дор эмчлэх гэдэгт гэмт этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, нийгэмд аюултай хууль бус үйлдлийнх нь шинж чанарыг харгалзан эмнэлэгт албадан хэвтэн эмчлэх арга хэмжээг ойлгоно.
- Сэтгэцийн эмнэлэгт эрчимжүүлсэн хяналт дор эмчлэх гэдэгт сэтгэцийн өвчтэй бөгөөд хүнийг алахаас өөр нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн, бусад хүнд хохирол, хор уршиг учруулахааргүй этгээдийг эрчимжүүлсэн хяналт дор албадан хэвтэн эмчлэх арга хэмжээг ойлгоно.
- Сэтгэцийн эмнэлэгт онцгой хяналт дор эмчлэх гэдэгт сэтгэцийн өвчтэй бөгөөд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, нийгэмд аюултай этгээдийг онцгой

¹⁸ Criminal Code of the Kyrgyz Republic
<https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/67156/104401/F1696552027/KGZ67156%20Eng.pdf>

хяналт дор албадан хэвтэн эмчлэх арга хэмжээг ойлгоно.

- Эрчимжүүлсэн болон онцгой хяналт дор албадан эмчлэхэд тухайн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэх боломжгүй нөхцөлд байлгана.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацаа сунгах, өөрчлөх, хүчингүй болгоход бүрэлдэхүүнтэй сэтгэцийн эмч нарын дүгнэлтийг үндэслэж шийдвэрлэх бөгөөд шүүхийн шийдвэрээр албадан эмчлэгдэж байгаа этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлын талаар 6 сар тутам шинжилгээ хийж, бүрэлдэхүүнтэй сэтгэцийн эмч нар дүгнэлт гаргахаар Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг заасан байна.

Гэмт хэрэг үйлдсэний дараа болон ял шийтгэгдсэний дараа сэтгэцийн өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдэд шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэх бөгөөд тухайн этгээд эдлээгүй үлдсэн ялын хугацааны дотор эдгэрсэн бол үлдэх ялыг эдлүүлэхээр шийдвэрлэнэ. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний нэг хоногийг хорих ялын нэг хоногтой дүйцүүлэн эдлэх ялаас хасаж тооцно.

Бүгд Найрамдах Киргиз Улсын Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь ерөнхийдөө ОХУ, БНКУ, Манай улсын эрх зүйн зохицуулалттай ижилхэн байдлаар хуульчилсан хэдий ч эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэсэн хүний эмчилгээний хугацааг 6 сар тутам шинжилгээ хийж дүгнэлт гаргах, сэтгэцийн өвчингүй боловч “Согтууруулах ундаа, мансууруулах бодист донтсон” болон сүрьеэ, ДОХ, бэлгийн халдварт өвчинтэй хүнд” ял оногдуулсан бол нэмэлтээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, хорихоос өөр төрлийн ял дээр нэмж гадуур эмнэлгийн байгууллагад, эсхүл хорих ял шийтгэгдсэн этгээдийг тухайн хорих ангид эмчлэх, шаардлагатай тохиолдолд хорих ял эдэлж дууссаны дараа үргэлжлүүлэн эмчлэх онцлог зохицуулалтуудыг тусгажээ. Мөн хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай хүнд эрүүгийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хүлээлгэдэг болох нь дүгнэгдэж байна.

4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

1979 оны Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулж 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр баталсан бөгөөд 1997 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр уг хуулийн 452 дугаар зүйлд заажээ¹⁹.

1997 оны Эрүүгийн хуулийн онцлог нь хууль ёсны болон шударга ёсны зарчмыг тогтоож, уг хуульд тодорхойгүй байсан зүйлүүдийг нарийвчлан хуульчилжээ. Хууль батлахдаа гэмт хэрэгтний эрх ашгийг хамгаалах талаар баримталдаг дэлхий нийтийн жишгийг ихээхэн анхаарсан байна. Гол нь сэжигтэн, заалдагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар олон шинэ заалт оруулсан. Тухайлбал, өмгөөлүүлэх эрхийг нарийвчлан тогтоосон²⁰.

¹⁹ МУИС-ХЗС Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль, УБ, 2021.

²⁰ Батзориг, Б., Зууннасан, Э. БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын хууль. УБ., 2006, 7 дахь тал.

БНХАУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийн тодорхойлолт өгөгдөөгүй. Харин ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох болон эрүүгийн хариуцлагын чадвар²¹ /хэрэг хариуцах чадвар/-ын талаар хуульчилсан.

Эрүүгийн хариуцлагын чадвар гэдэг нь эрүүгийн хуулийн утга агуулгад нийцсэн өөрийнхөө үйл ажиллагааг хууль бус гэдгийг ялган таних ба барих чадварыг ойлгоно. БНХАУ-ын эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын чадварыг доорх байдлаар хуваадаг байна. Үүнд:

1. Эрүүгийн хариуцлагыг бүрмөсөн хариуцах чадвар;
2. Эрүүгийн хариуцлагыг бүрмөсөн хариуцахгүй чадвар;
3. Эрүүгийн хариуцлагыг хариуцахыг хязгаарлах чадвар;
4. Эрүүгийн хариуцлагыг хариуцахыг хөнгөрүүлэх чадвар;

Тус хуульд “Оюун мэдрэлийн тотхар”²² гэсэн ойлголтыг хуульчилсан нь сэтгэцийн өвчний шинж чанарыг тодорхойлсон бололтой. Зарим хүн хэдийгээр эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн боловч түүний оюун мэдрэлд нь саад тотхартай байвал түүний эрүүгийн хариуцлагын чадварт нь нэлээд хэмжээний бууруулах буюу үгүйсгэх нөлөөг үзүүлж болзошгүй гэжээ.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлд мэдрэлийн өвчтэй хүнд ямар тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, хүлээлгэх, эсхүл хязгаартай хүлээлгэх талаар тусгасан. Үүнд:

1. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй мэдрэлийн өвчтэй хүн.

Сэтгэл мэдрэлийн өвчтөн өөрийн үйл ажиллагаагаа гэмт хэрэг гэж мэдэхгүй буюу буюу барьж дийлэхгүй үедээ хор хөнөөлтэй үр уршиг татаад /гэмт үйлдэл хийгээд/ хуульд тогтоосон журмаар шалган магадлагдсан буюу тогтоож нотолсон байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Харин гэр бүлийнхэн буюу асран хамгаалагчид нь зарлигдан чанга хамааруулах буюу эмчлүүлэхийг даалгана. Шаардлагатай үед засгийн ордноос албадан эмчлүүлнэ.

2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой мэдрэлийн өвчтөн. Дараах хоёр тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

а/ Оюун мэдрэл нь эрүүл байгаа хугацаан дахь сэлгүх чанартай мэдрэлийн өвчтөн. Сэлгүх чанартай мэдрэлийн өвчтөн гэдэг нь оюун мэдрэл сарних өвчин, солио өвчин, унадаг өвчин мэтийн байн байн хөдөлдөг мэдрэлийн өвчинг хэлдэг. Эрүүл байх хугацаа гэдэг нь өвчин нь хөдлөхгүй эрүүл байх үе бөгөөд Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлд байн байн хөдөлдөг мэдрэлийн өвчтэй хүн эрүүл байх үедээ гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж хуульчилсан байна.

б/ Олон тооны мэдрэлийн харш саадтай боловч солиорсонгүй хүний мэдрэлийн харш саад нь түүний гэмт хэрэг гэж мэдэх буюу барих чадвараа

²¹ МУИС-ХЗС Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль, УБ., 2021.

²² МУИС-ХЗС Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль, УБ., 2021.

бүрэн алдаагүй мэдрэлийн өвчтөн гэмт хэрэг хийвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

3. Эрүүгийн хариуцлага хязгаартай хүлээлгэх мэдрэлийн тотхарт өвчтөн

Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т зааснаар өөрийн үйл ажиллагаагаа ялган таних буюу биеэ барах чадвараа хараахан бүрэн алдаагүй сэтгэл мэдрэлийн өвчтөн гэмт хэрэг хийсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэвч хөнгөнөөр шийтгэх буюу хөнгөрүүлэн шийтгэж болно. Үе үе хөдөлдөг сэтгэцийн өвчтэй хүн сэтгэцийн хэвийн байдалд байхдаа гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Бие махбодын чадвараа алдах. Хүн хэрэв бие махбодын сонсох, үзэх, ярих зэрэг чухал чадвараа алдвал түүний соёл сурган хүмүүжил хүртэх, мэдлэг эзэмших зэрэгт сөрөг нөлөө үзүүлэх тул түүний ялган таних чадвар болон биеэ барих чадварт нөлөөлөх нь зайлшгүй. Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлд “дүлий мөртөө ява хүн буюу сохор хүн ял хийсэн байвал хөнгөнөөр шийтгэх, хөнгөрүүлэн шийтгэх буюу шийтгэлээс нь хэтрүүлж болно” гэж тогтоосон байдаг. Өөрөөр хэлбэл, хэлгүй, дүлий, сохор хүн гэмт хэрэг үйлдвэл хөнгөнөөр шийтгэх буюу ялыг хөнгөлөх, эсвэл шийтгэлээс чөлөөлж болно²³.

Согтуу хүний эрүүгийн хариуцлага. Согтууг бие махбодын чанартай согтуу болон өвчний чанартай согтуу гэж хоёр хуваадаг. Өвчний чанартай согтуу нь мэдрэлийн өвчинд тооцогдох тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг нь өвчний хүнд хөнгөний байдлыг нь үзэж шийддэг. Бие махбодын чанартай согтуу гэдэг нь ердөө олонд тохиолддог нэг зүйлийн түргэн чанартай спиртийн хордлого. Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т “согтуу хүн ял хийсэн байвал эрүүгийн хариуцлага хүлээх хэрэгтэй” гэж тогтоосноос үзэхэд согтуу хүн гэмт хэрэг үйлдвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

БНХАУ-ын эрүүгийн хуулиас үзэхэд хэрэг хариуцах чадваргүй байдлыг 4 төрөлд хувааж үзсэн нь хэрэг хариуцах чадваргүй байдлыг өвчний шинж чанараас нь хамааруулж ангилан эрүүгийн хариуцлагыг ялгамжтай оногдуулах, өөрөөр хэлбэл, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг хуульчилсан гэж дүгнэж болно. Харин эдгээр хүмүүсийг хөнгөн байдлаар шийтгэхээр ихэвчлэн заасан бол эмчлүүлэх үүргийг өөрт нь болон гэр бүлийн хүмүүст нь даалгаж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заажээ.

II. ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ САЙН ТУРШЛАГА БҮХИЙ ЕВРОПЫН ЗАРИМ УЛСУУД

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Германы эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь 1949 оны ХБНГУ-ын Үндсэн хууль, 1871 оны Эрүүгийн хууль, Холбооны тусгай хууль, мужийн Эрүүгийн хууль

²³ БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйл.

тогтоомжоос бүрддэг. ХБНГУ-ын Эрүүгийн хуульд Дэлхийн II дайн дууссаны дараа хэд хэдэн удаа өөрчлөлт орж 1987 онд шинэчилсэн найруулгыг баталсан.

Nulla poene sine lege буюу хууль үгүй бол ял үгүй зарчмыг ХБНГУ-ын Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт болон ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан.²⁴ Өөрөөр хэлбэл, ХБНГУ-ын ялыг зөвхөн бичмэл эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн оногдуулж болно. Ердийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж болохгүй бөгөөд хэм хэмжээг төсөөтэй хэрэглэхийг хориглоно.

Германы эрүүгийн эрх зүйд гэм бурууг бүрдүүлэгч гурван үндсэн элемент байдаг²⁵ гэж үздэг. Үүнд:

- *Хэрэг хариуцах чадвар* – энэ нь үйлдлийнхээ зүй бус чанарыг олж харах, түүний бүх хариуцлагыг өөртөө хүлээх чадвар бөгөөд чадвартай байх үедээ үйлдэл хийсэн эсэхийг авч үздэг;
- *Зүй бусын мэдрэмжгүй байх явдал* - энэ нь түүний үйлдэл эрх зүйгээр хориотой гэдгийг мэдэхгүй байх тохиолдол;
- *Хэм хэмжээний дагуу хандах боломжгүй тохиолдол* - энэ нь хэрэгтний үйлдлийг уучлах аливаа шалтгаан байхгүй байгаа тохиолдол юм.

Гэмт хэрэг үйлдсэн хүний хэрэг хариуцах чадвар нь түүний гэм бурууг тогтоох үндэслэлд тавигдах гол шаардлага болдог. “Гэм буруутай байх чадвар” буюу “Хэрэг хариуцах чадвар” гэдэг нь хэрэгтэн өөрийн үйлдэх хэргийн зүй бус чанарыг олж харж, ингэсний үндсэн дээр үйлдэл хийх чадварыг хэлэх бөгөөд ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 19, 20 дугаар зүйлд хэрэг хариуцах чадварыг үгүйсгэх хоёр тохиолдлыг хуульчилсан.

Үүнд: 1)Хүүхдийн хэрэг хариуцах чадваргүй байдал, 2)Сэтгэцийн өвчин, сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэг хариуцах чадваргүй байдал орно.

*Сэтгэцийн өвчин, сэтгэцийн эмгэгтэй этгээдийн хэрэг хариуцах чадваргүй байдал*²⁶

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлд зааснаар хэрэг хариуцах чадвар нь хэрэгтэн сэтгэцийн эмгэг, оюуны хомсдол, сэтгэн бодох чадвар муу байдал эсвэл сэтгэцийн бусад ноцтой өөрчлөлтийн улмаас хэрэг үйлдэхдээ тухайн үйлдлийнхээ хууль бус байдлыг мэдэх эсвэл ойлгох чадваргүй бол гэм буруугүйд тооцно. Учир нь: сэтгэцийн өвчтөн өөрийн үйлдлийн зүй бус байдлыг таньж мэдэх, ойлгох чадваргүй, түүн дээрээ тулгуурлан зохих үйлдлийг хийх чадваргүй байдаг.

Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийг амьдрал дээр хамгийн их хэрэглэдэг тохиолдол бол архидан согтуурсны улмаас хөлчүүрхсэн байдалд орж эрүүл ухаанаа алдах тохиолдол юм. Ингэхдээ хэрэг тус бүр дээр эмнэлгийн дүн

²⁴ МУИС-ХЗС Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль, УБ, 2021.

²⁵ Хилгендорф, Э., Чанцалдулам, Д. Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ., 2015.82 дахь тал.

²⁶ Хилгендорф, Э., Чанцалдулам, Д. Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ., 2015.84 дэх тал.

шинжилгээний тусламжтайгаар хөлчүүрлийн ямар хэмжээнд явааг тогтоож хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоодог.

Цусан дахь архины концентрац хэмжээ 3 промилл хүрсэн тохиолдолд, хүнд гэмт хэргийн хувьд 3,3 пормилл хүрсэн бол тухайн этгээдийг хэрэг хариуцах чадваргүй гэж үздэг. Хэт согтуу хүн өөрийн үйлдлийн зүй бус чанарыг таньж мэдэх чадваргүй, ингэснээр үйлдлээ хянах боломжгүй тул хэрэг хариуцах чадвартай гэж үзэхгүй.

Зарим тохиолдолд цусанд хэдийгээр өндөр хэмжээний архины концентрацтай ч байнга уудаг зуршилтай бөгөөд бие нь тийм хэмжээний архины концентрацад дассан бол түүнийг үйлдлийн зүй бус чанарыг таньж мэдэх, үйлдлээ жолоодох чадвартай гэж үздэг.

Засан хүмүүжүүлэх болон аюулгүй байдлын арга хэмжээ

Энэ арга хэмжээ нь ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйн онцлог институт. Түүний онцлог шинж нь эрх зүйн онцгой үр дагаврыг бий болгодог бөгөөд шүүх гэм буруутай болохыг тогтоосон, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гарсан байхад төдийгүй гэм буруугүй байхад сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтүүлэх арга хэмжээг хэрэглэдэг.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох засан хүмүүжүүлэх ба аюулгүй байдлын арга хэмжээний тогтолцоог 1933 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар тогтоосон байна²⁷. ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 61-70 дугаар зүйлд аюулгүй байдлын арга хэмжээ гэж томьёолон, засан хүмүүжүүлэх болон аюулгүй байдлын арга хэмжээний жагсаалтыг мөн хуулийн 61 дүгээр зүйл / аюулгүй байдлын арга хэмжээ/-д тодорхойлсон.²⁸ Үүнд:

1. Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх;
2. Донтох өвчнийг эмчлэх эмнэлэгт хэвтүүлэх;
3. Хамгаалах зорилгоор цагдан хорих;
4. Зан үйлийн хяналт;
5. Жолоодох эрхийг хасах;
6. Мэргэжлээрээ ажиллах эрхийг хасах.

Дээр дурдсан аюулгүй байдлын арга хэмжээг эрх чөлөөг хасахтай холбоотой арга хэмжээ, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах арга хэмжээ гэж ангилдаг бөгөөд эрх чөлөөг нь хасахтай холбоотой арга хэмжээнд сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх, донтох өвчнийг эмчлэх эмнэлэгт хэвтүүлэх, хамгаалах зорилгоор цагдан хорих, зан үйлийн хяналт гэсэн арга хэмжээ хамаардаг байна.

²⁷ Нарангэрэл, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги.УБ., 1999, 386 дахь тал.

²⁸ МУИС-ХЗС Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль,УБ, 2021.

Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх (63 дугаар хэсэг).

Сэтгэцийн эмгэг, өвчний улмаас эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй нөхцөл байдал (20 дугаар хэсэг) эсвэл хөнгөрүүлэн хариуцлага (21 дүгээр хэсэг) хүлээлгэх нөхцөлд хууль бус үйлдэл хийсэн тохиолдолд шүүх тухайн хүний үйлдсэн гэмт хэргийн шинж чанарыг бүхэлд нь үнэлсний дараа сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх шийдвэр гаргана.

Мөн гэмт этгээд сэтгэцийн эмгэгийн улмаас хэрэг хариуцах чадваргүй байхдаа эсвэл хэрэг хариуцах чадварыг алдагдуулах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн, түүний үйлдсэн гэмт хэргийн үр дагаврыг ерөнхий байдлаар үнэлж үзэхэд гэмт этгээд өөрийн нөхцөл байдлаас болж хохирогчид сэтгэл санааны буюу бие махбодын ноцтой хохирол учруулсан, учруулж болзошгүй эсвэл эдийн засгийн хувьд ноцтой хохирол учруулсан, учруулж болзошгүй гэж шүүх үзвэл түүнийг сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх арга хэмжээ авна.

Мансууруулах бодисын донтох эмгэгийг эмчлэх газарт байрлуулах (64 дүгээр хэсэг)

Согтууруулах ундааны болон бусад мансууруулагч бодист донтсон, эсхүл согтуугаар буюу донтсоны улмаас хууль бус үйлдэл хийж гэм буруутайд тооцогдсон этгээдийн хэрэг хариуцах чадваргүй байдал бүрэн үгүйсгэгдээгүй бол тухайн хүний ирээдүйд учруулж болзошгүй аюултай үйлдлээс урьдчилан сэргийлж эрүүгийн хариуцлагын хүрээнд шүүх донтох өвчнийг эмчлэх эмнэлэгт хэвтүүлэх шийдвэр гаргана. Ийнхүү шийдвэр гаргахдаа энэ хуулийн 67d (1) дүгээр зүйлийн 1, 3-т заасан хугацаанд тухайн хүнийг донтох өвчнийг эмчлэх эмнэлэгт хэвтүүлэх замаар эдгээх боломжтой, эсхүл донтох өвчтэй болох нь үндэслэлтэй байгаа тохиолдолд ийм шийдвэр гаргана. Энэ арга хэмжээг авснаар зан авир, ийм хандлагаас үүдэлтэй ноцтой хууль бус үйлдэл хийхээс тодорхой хугацааны туршид урьдчилан сэргийлэх боломжтой.

Хамгаалах зорилгоор цагдан хорих

Согтууруулах ундаа буюу бусад төрлийн мансууруулах зүйл хэтрүүлэн хэрэглэх хандлагатай этгээд согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх дүгнэсэн эсхүл хэрэг хариуцах чадваргүй буюу хэрэг хариуцах чадваргүй эсэхийг нотлох боломжгүйн улмаас шүүх гэмт үйлдэл хийсэн гэж дүгнээгүй, эсхүл согтуурсан болон мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэж үзвэл түүнийг цагдан хорих байранд байрлуулах арга хэмжээ авна.

Энэ арга хэмжээг авахдаа 2 жилийн хугацаанд тухайн этгээд цагдан хорих байранд байснаар эмчлэгдэх, буцаад хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн хэтрүүлэн хэрэглэх хандлагаасаа болж гэмт хэрэг үйлдэхээс сэргийлж чадна гэсэн хангалттай үнэлгээнд үндэслэнэ.

Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх арга хэмжээг гүйцэтгэж эхэлсний дараа ийм арга хэмжээ авах шаардлагатай болсон буюу цааш үргэлжлүүлэх нь

зохимжгүй гэж шүүх тогтоосон бол цагдан хорих арга хэмжээг дуусгавар болгоно. Сэтгэцийн эмнэлэгт хэвтэх буюу цагдан хорих байгууллагад хорих шийдвэр гарсан бөгөөд яллагдагчийг нийгэмшүүлэхэд илүү дэмжлэг үзүүлнэ гэж шүүх үзсэн тохиолдолд түүнд хожим нь өөр арга хэмжээ авахаар өөрчлөн шилжүүлж болно. Түүнчлэн дээрх шийдвэр гарсны дараа онцгой нөхцөл байдлын улмаас арга хэмжээний зорилгыг тэнсэн харгалзсан ч хангах боломжтой гэж шүүх үзсэн тохиолдолд арга хэмжээ гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж тэнсэн харгалзана.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 67 дугаар зүйлд эрх чөлөөг хасах арга хэмжээг хэрэгжүүлэх дарааллыг хуульчилж өгсөн нь онцлогтой байна. 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Хэрэв 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас гадна эрх чөлөөг нь хасах газарт байрлуулахаар шийдвэрлэсэн бол хорих ялаас өмнө уг арга хэмжээг хэрэгжүүлнэ”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Гэсэн хэдий ч, хэрэв уг арга хэмжээний зорилгод илүү хялбар хүрэх юм бол шүүх шийтгэлийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь арга хэмжээ авахаас өмнө биелүүлэхийг тушаана”.*

Гурван жилээс доошгүй хугацаагаар хорих ял оногдуулахаас гадна донтох өвчнийг эмчлэх байгууллагад шилжүүлэх тухай шийдвэр гаргахдаа шүүх хорих ялын зарим хэсгийг уг арга хэмжээ авахаас өмнө биелүүлэхийг даалгадаг. Шийтгэлийн энэ хэсгийг ялын хэсэг, арга хэмжээг хэрэгжүүлсний дараа 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргах боломжтой байхаар тооцно. Нутаг дэвсгэрийн хүрээнд ялтны оршин суух газар нь ял эдэлж байх хугацаанд буюу ял эдэлсэн даруйд дуусгавар болно.

Эрүүгийн хуулийн 67а дугаар зүйлд эрх чөлөө хасах арга хэмжээг өөр арга хэмжээ рүү шилжүүлэх зохицуулалтыг тусгажээ. Үүнд:

1. Сэтгэцийн эмнэлэг, донтох эмгэгийн эмчилгээний газарт хэвтүүлэхээр шийдвэрлэсэн бол шүүх тухайн хүний нийгмийн нөхөн сэргээх боломжийг дээшлүүлбэл, баривчлагдсан этгээдийг эдгээр хоёр арга хэмжээний нөгөөд шилжүүлж болно.
2. Шүүх урьдчилан цагдан хоригдсон этгээдийг 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээний аль нэгэнд шилжүүлж болно. 1 дэх хэсэгт заасан нөхцөл хангагдсан, эмчилгээ хийлгэх, донтох эмчилгээ хийлгэх зорилгоор шилжүүлэхийг зааж өгсөн тохиолдолд, түүний дотор хорих ял эдэлж байгаа, урьдчилан хорих ялаар шийтгэгдсэн хүмүүсийг шилжүүлж болно.
3. Шүүх 1 ба 2 дахь дэд хэсгийн дагуу гаргасан шийдвэрийг дараа нь баривчлагдсан этгээдийн нийгмийн нөхөн сэргээлтийг сайжруулах боломжийг нэмэгдүүлнэ гэж үзвэл өөрчлөх буюу хүчингүй болгож болно. Цаашилбал, 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх нь хүссэн үр дүнд хүргэхгүй гэж үзвэл шүүх 2 дахь дэд хэсгийн дагуу гаргасан шийдвэрийг хүчингүй болгож болно.
4. Байршуулах хугацаа, хянан шалгах хугацааг шүүхийн шийдвэрт хамаарах

заалтын дагуу тодорхойлно. 2 дугаар зүйлийн 2-т заасан тохиолдолд уг арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх хүртэл шүүх 3-д заасан шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн эсэхийг нэг жилээс илүүгүй хугацаанд тогтмол хянаж байх шаардлагатай.

Түүнчлэн мансууруулах бодист донтох эмгэгийг эмчлэх байгууллагад байрлуулах хугацаа хоёр жилээс илүү байж болохгүй. Энэ хугацаа нь албадлагын арга хэмжээний эхнээс хэрэгжинэ. Эрх чөлөөг нь хасахтай холбоотой арга хэмжээг нэгэн зэрэг оногдуулсан хорих ялаас өмнө хэрэгжүүлсэн тохиолдолд дээд хэмжээг хорих ялын хугацаагаар сунгаж, уг арга хэмжээнд зарцуулсан хугацааг ял эдэлсэнд тооцно. (67d хэсэг).

Хамгийн дээд хугацааг заагаагүй, эсхүл хугацаа нь дуусаагүй бол уг арга хэмжээ авсан этгээд цаашид ямар нэгэн ноцтой хууль бус үйлдэл хийхгүй гэж үзвэл шүүх тэнсэн харгалзах арга хэмжээний үлдсэн хэсгийг түдгэлзүүлнэ.

Хамгаалах зорилгоор цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсний дараа шүүх хорих ялыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж болно. Шүүхээс тогтоосон зургаан сараас илүүгүй хугацаа өнгөрөхөөс өмнө хангалттай эмчилгээ үзүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн асуудлыг хянан хэлэлцэхдээ санал болгох арга хэмжээг зааж өгөх хугацаа тогтооно. 1, 2 дугаар хэсэгт заасны дагуу арга хэмжээг түдгэлзүүлэх зан үйлийг хянахад арга хэмжээг шууд авахад хүргэдэг. (67d хэсэг).

Хамгаалах зорилгоор цагдан хорих арга хэмжээг 10 жил эдэлсэн бол хорих ял эдэлж байгаа этгээд хохирогчийн сэтгэл санааны хүнд гэмтэл, бие махбодод гэмтэл учруулсан хүнд гэмт хэрэг үйлдэх аюул байхгүй бол шүүх таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгсэхгүй болгож, суллах шийдвэр нь шууд зан үйлийг хянахад хүргэдэг. (67d хэсэг)

Хамгийн дээд хугацаа дууссаны дараа баривчлагдсан этгээдийг суллана. Цагдан хорихоос чөлөөлөгдөх нь автоматаар зан үйлд хяналт тавихад хүргэдэг.

Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх ажиллагаа эхэлсний дараа шүүх уг арга хэмжээг авах нөхцөл бүрдээгүй, эсхүл уг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүй ёсны бус гэж үзвэл хэрэгсэхгүй болгоно. Баривчлагдсан этгээд өөрийн нөхцөл байдлын улмаас хохирогчдын сэтгэл санааны болон бие махбодод хүнд гэмтэл учруулсан хууль бус ноцтой үйлдэл хийх, эсхүл гэмт хэрэг үйлдэх аюул заналхийлээгүй тохиолдолд уг арга хэмжээ 6 жил үргэлжилсний дараа түүнийг үргэлжлүүлэх нь ерөнхийдөө пропорциональ байхаа болино. 10 жил баривчлагдсаны дараа (3) дэд зүйлийн 1 дэх заалтыг дагаж мөрдөнө. Арга хэмжээнээс чөлөөлөгдөх нь автоматаар зан үйлийг хянахад хүргэдэг. Шүүх арга хэмжээ аваагүй ч цаашид ямар нэгэн гэмт хэрэг үйлдэхгүй гэж үзвэл зан үйлийн хяналтаас татгалздаг.

Эрх чөлөөг нь хасахтай холбоотой арга хэмжээний цаашдын биелэлтийг тэнсэн харгалзах хугацаанд түдгэлзүүлэх эсвэл уг арга хэмжээг хэрэгсэхгүй болгох эсэхийг шүүх хэдийд ч хянаж болно. Хяналт шалгалтыг заасан хугацаанд хийх шаардлагатай.

Донтох өвчнийг эмчлэх эмнэлэгт хэвтүүлсэн тохиолдолд зургаан сар, сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлсэн тохиолдолд нэг жил, хамгаалах зорилгоор цагдан хорих арга хэмжээ авсан бол нэг жил, хэрэв 10 жил цагдан хоригдсон бол есөн сар тутам хянах арга хэмжээ авна. Шүүх эдгээр хугацааг багасгаж болно. Мөн хянан үзэх хүсэлтийг хүлээн авах боломжгүй хугацаа дуусахаас өмнө хуулиар тогтоосон хязгаарт багтаан хянан үзэх хугацааг тогтоож болно.

Хэрэв ял шийтгүүлсэн этгээдэд авсан эрх чөлөөг нь хасахтай холбоотой арга хэмжээг шүүх хүчингүй болгоно. 1/ зан үйлд хяналт тавих хугацаанд хууль бус үйлдэл хийсэн, 2/ зааврыг бүдүүлгээр эсвэл байнга зөрчих эсвэл, 3/ тэнсэн харгалзах ажилтны болон хяналтын байгууллагын хяналт, зааварчилгаанаас байнга зайлсхийсэн зэргийг агуулж болно.

Зан үйлд хяналт тавих хугацаа

Зан үйлд хяналт тавих хугацаа нь хоёр жилээс багагүй, таван жилээс илүүгүй байна. Шүүх хамгийн дээд хугацааг багасгаж болно. Хэрэв ял шийтгүүлсэн этгээд 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан дээд хязгаараас хэтэрсэн тодорхой бус хугацаагаар зан үйлд хяналт тавих тушаал гаргаж болно.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсад сэтгэцийн эмгэгийн улмаас хэрэг хариуцах чадваргүй үедээ эсхүл хэрэг хариуцах чадварыг алдагдуулах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн хүнийг сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх, согтууруулах болон мансууруулах бодист донтсоны улмаас хууль бус үйлдэл хийсэн хүнийг ирээдүйд учруулж болзошгүй аюултай үйлдлээс урьдчилан сэргийлж донтох өвчнийг эмчлэх тусгай эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх зэргээр аюулгүй байдлын арга хэмжээ авдаг. Согтуурсан болон мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүнийг хэрэг хариуцах чадваргүй эсэхийг нотлох боломжгүй, цаашид гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэж үзвэл 2 жилийн хугацаагаар цагдан хорих байранд байрлуулах арга хэмжээ авч, баривчлах хугацаанд албадан эмчилнэ. Хамгаалах зорилгоор авсан цагдан хорих арга хэмжээг 10 жил хүртэл хугацаагаар эдэлсэн, уг хугацаа дуусаж суллах шийдвэр гаргавал зан үйлийн хяналт тогтоох арга хэмжээ авч, цаашид ямар нэгэн гэмт хэрэг үйлдэхгүй гэж үзвэл зан үйлийн хяналт тогтоох арга хэмжээ авахгүй.

2. Бүгд Найрамдах Франц Улс

Бүгд Найрамдах Франц Улсын Эрүүгийн тухай²⁹ хуулийн 2 дугаар бүлэгт Эрүүгийн гэмт хэргийн хариуцлагыг үгүйсгэх, хөнгөрүүлэх үндэслэлийг тодорхойлсон.

²⁹ The France Penal Code, 1992, https://sherloc.unodc.org/cld/document/fra/1992/penal_code_en.html

Эрүүгийн тухай хуулийн 122.1 дүгээр зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдлийг хянах эсхүл ойлгох боломжийг хязгаарласан сэтгэл мэдрэлийн эмгэгтэй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Харин гэмт хэрэг үйлдэх явцад өөрийн үйлдлийг хянах чадварт саад болсон эсхүл ойлгох боломжийг бууруулсан сэтгэл мэдрэлийн эмгэгтэй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Хуульд заасны дагуу шүүх нийгэм шүүхийн ажиглалтыг тогтоож болно³⁰. Нийгэм шүүхийн ажиглалт гэдэг нь шүүхийн зүгээс тогтоосон хугацаанд шүүгдэгчийг гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн хяналт болон ажиглалтын шүүхийн хяналт дор захирагдах ёстойг илэрхийлнэ. Нийгэм шүүхийн ажиглалтын үргэлжлэх хугацаа нь эс үйлдлийн нөхцөлд арван жилээс, харин гэмт үйлдлийн нөхцөлд хорин жилээс хэтрэх ёсгүй. Нийгэм шүүхийн ажиглалт нь тодорхой асаргааг агуулж болдог. Тус хуулийн 131-36-4 дүгээр зүйлд Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн дагуу шинжээчийн дүгнэлтээр шүүгдэгчид ажиглалт тогтоож, эмчилгээнд хамрагдах боломжтой болох нь тогтоогдвол шүүх ажиглалт тогтоож эмчлэх шийдвэрийг гаргана. Хэрэв шүүгдэгч хүн амины хэрэг эсвэл насанд хүрээгүй хүний аминд хүрсэн, хэрэв тус гэмт хэрэг нь хүчирхийлэл, тамлах эсвэл хэрцгий шинж чанартай шууд эсвэл шууд бус байдлаар холбоотой бол шинжээчийн дүгнэлтийг хоёр мэргэжилтний тусламжтайгаар гүйцэтгэнэ.

Шүүх хурал даргалагч нь шүүгдэгчид зөвшөөрөлгүйгээр ямарваа нэгэн эмчилгээнд хамрагдах боломжгүйг тайлбарлах бөгөөд хэрэв шүүгдэгч сайн дураар эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд 131-36-1-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэж болдог. Шүүгч гэм буруутай этгээдэд ял оногдуулж, хорих ял шийтгэсэнтэй адил хугацаагаар эмчлэх тухай шийдвэр гаргахдаа шүүх хурал даргалагч шүүгдэгчид ялыг гүйцэтгэх хугацааны турш энэ төрлийн эмчилгээг явуулах боломжтойг урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв нийгэм шүүхийн ажиглалт тогтоож хугацаагүй эмчлэх шийдвэрийг хорих ялын хамт оногдуулсан бол хорих ял дууссан өдрөөс эхлэн тогтоосон яллах дүгнэлтийн дагуу явуулна. Нийгэм шүүхийн ажиглалтаас урган гарсан хариуцлагыг үл гүйцэтгэсэн тохиолдолд оноосон хорих ял нь тус арга хэмжээг авч байх хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэгт оноосон хорих ялтай дүйцнэ.

Бүгд Найрамдах Франц Улсын Эрүүгийн тухай хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ *сэтгэл мэдрэлийн эмгэгтэй байсан хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй* бөгөөд гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлж нийгэм шүүхийн ажиглалт тогтоон эмчилнэ. Хорих ял шийтгэгдсэн шүүгдэгч өөрөө зөвшөөрвөл эмчилгээнд хамруулах ба сайн дураар эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд хорих ялыг биечлэн эдлүүлдэг байна.

³⁰ Эрүүгийн тухай хуулийн VI дэд бүлэгт “Нийгэм шүүхийн ажиглалт”-ын талаар тусгасан (уг бүлэгт 1998 оны 6 дугаар сарын 17-ны №1998-468 болон 1998 оны 6 дугаар сарын 18-ны 1 тоот хуулиар нэмэлт оруулсан).

3. Англи Улс

Англид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд холбогдох харилцааг 1983 оны 05 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль (Mental Health Act 1983) болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх дүрэм (The Criminal Procedure Rules 2020) зэргээр зохицуулдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд 1983 оноос хойш 2023 оныг хүртэл нийт 72 удаа нэмэлт, өөрчлөлт орсон нь энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээлтэй холбоотой байна.

Английн хуульд байгаа онцлог практикаас дурдвал, шүүх гэмт хэрэг үйлдсэн бөгөөд шүүхэд мэдүүлэх чадваргүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ойлгож чадахгүй, шүүгчийн асуулт, байр сууринд үнэлэлт өгч, ухамсартайгаар тайлбар гаргах, тодорхой үйл баримтыг нотлох, өөрийгөө хамгаалах чадваргүй гэж үзэх сэжиг байвал сэтгэцийн эмчээр холбогдох этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн талаар урьдчилсан байдлаар тодорхойлолт гаргуулж, шаардлагатай тохиолдолд гэмт этгээдийг 1 сараас 12 долоо хоногийн хугацаагаар сэтгэцийн эмнэлэгт байлгах шийдвэр гаргах эрхтэй. Энэ нь нэг төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ гэж үзэх үндэслэлтэй. Харин гэмт этгээдийн санаачилгаар эмнэлэгт байлгах тухай шүүхийн шийдвэрийг цуцлуулах бол өөрийн зардлаар холбогдох шинжилгээ, үзлэгт хамрагдаж, тухайн арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх шалтгаан арилсан гэх эмчийн тодорхойлолт гарсан тохиолдолд шүүх уг арга хэмжээнээс дээрх хугацаанаас өмнө цуцлах эрхтэй байна³¹.

Нөгөөтээгүүр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа, хэргийг хянан шийдвэрлэх хүртэл сэтгэцийн эмнэлэгт хэвтэж буй гэмт этгээдэд зөвхөн шүүх хууль ёсны төлөөлөгч томилж, хэвтэх хугацаанд эмнэлгийн зүгээс өвчтөний зөвшөөрснөөр түүнд шаардлагатай эмчилгээг хийх ба энэ нь албадлагын шинжтэй бус дан ганц холбогдох этгээд, түүний хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр хийгдэж байгаа нь албадан эмчлэх эсэх талаар шүүхийн шийдвэр гараагүйтэй холбон ойлгож болох юм.

Хэрэв гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд гэм буруу нь тогтоогдоогүй 14 насанд хүрсэн бөгөөд 18 насанд хүрээгүй бол түүнийг хууль ёсны төлөөлөгчид нь харгалзуулах, ингэхдээ тухайн этгээдийн оршин суух нутаг дэвсгэрийг харьяалах цагдаагийн алба хаагчид давхар хянан харгалзуулахаар заадаг, эсхүл дээр дурдсанаар сэтгэцийн эмнэлэгт тусгайлан насанд хүрээгүй хүмүүст зориулан бэлтгэсэн тасагт байлгахаар шийдвэрлэдэг³².

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүрэн дүүрэн явагдаж, гэмт этгээдийг шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон бол шүүх хоёроос доошгүй сэтгэцийн эмчийн бүрэлдэхүүнтэй³³ эмнэлгийн дүгнэлтийг үндэслэн хэрэг

³¹ *Mental Health Act 1983*, Part 3, 35 (7), <https://www.legislation.gov.uk/ukpga/1983/20>

³² Мөн тэнд, 39 (1A)

³³ *The Criminal Procedure Rules 2020*, 310, <https://www.legislation.gov.uk/uksi/2020/759/made>

хариуцах чадваргүй гэж үзсэн тохиолдолд түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авахаар шийдвэрлэнэ.

Уг арга хэмжээ авагдсан өвчтөнд ямар төрлийн эмчилгээ хийхийг тухайн сэтгэцийн эмнэлэг шийдвэрлэх ба сэтгэцийн буруу эмчилгээ хийсэн эрх бүхий алба хаагч, сэтгэцийн эмнэлгээс оргон зайлсан этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар тус хуульд тодорхойлсон нь бусад улс орнуудын хууль тогтоомжид төдийлөн тусгагдаагүй онцлог зохицуулалт гэж харж байна.

4. Испанийн Хаант Улс

Эрүүгийн хуулийн³⁴ 20 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ аливаа сэтгэцийн өөрчлөлтийн улмаас өөрийн үйлдлийн хууль бус шинж чанарыг ухамсарлах, түүнээс гарах үр дагаврыг урьдаас ойлгох чадваргүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Харин гэмт хэрэг үйлдэх үедээ түр зуурын сэтгэцийн сааталд орсон боловч тухайн хууль бус үйлдлийн үр дагаврыг урьдаас ойлгох чадвартай байсан хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй байхаар зохицуулжээ.

Тус хуулийн 25 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгийг төрөлхийн биеийн, оюуны хоцрогдлын улмаас нийгэмд эзлэх байр сууриа бүрэн дүүрэн хэрэгжүүлэх чадамжгүй, тулгарсан саадыг даван туулах чадваргүй хүнийг ойлгоно гэж тайлбарласан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, үүргийг хуулиар тодорхойлох бөгөөд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахын тулд бусдаас дэмжлэг, туслалцаа авах эрхтэй.

Харин тус хуулийн 48 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй хүнд *шүүх тодорхой газар амьдрах, эсхүл очихгүй байх, хохирогч, түүний гэр бүлтэй уулзахгүй байх үүрэг хүлээлгэх* арга хэмжээ авахаар заасан. Шүүх хэрэг хариуцах чадваргүй хүний гэм бурууг шийдвэрлэхдээ түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийнх нь санал, дүгнэлтийг харгалзан үздэг.

Мөн 60 дугаар зүйлд хорих ял эдэлж байхдаа хэрэг хариуцах чадваргүй болсон нь тогтоогдвол ял эдлүүлэх ажиллагааны шүүгч хоригдлыг хорих ялаас хугацааны өмнө суллаж, албадан эмчлүүлэхээр шийдвэрлэхээр, албадан эмчлэх хугацаанд ялтны сэтгэцийн эрүүл мэндийн байдал дээрдсэн, хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан гэж үзэх үндэслэл тогтоогдвол шүүх албадан эмчлэх шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэхээр тус тус зохицуулжээ.

Мөн 101 дүгээр зүйлд хорих ялаас хугацааны өмнө суллаж албадан эмчлэхээр шийдвэрлэсэн этгээдийн албадан эмчлэх хугацаа нь түүний эдлээгүй үлдсэн хорих ялын хугацаатай тэнцүү байхаар тусгасан.

³⁴ Ministry of Justice, Spain Criminal Code, 1995 <https://www.globalwps.org/data/ESP/files/Criminal%20Code.pdf>

5. Бельгийн Хаант Улс

Бельги улсад гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээдийг эмчлэх харилцааг 1964 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Нийгэм хамгааллын тухай хуулиар зохицуулж байна. Гэмт хэрэг, зөрчил үйлдэх үедээ сэтгэцийн хүчтэй тогтворгүй байдал, оюуны хомсдол, галзуурлын байдалтай байсан хүнийг тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлах бөгөөд энэ нь шийтгэл бус *нийгмийн хамгаалал* гэж үздэг онцлогтой байна.

Шүүх гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг өөрийн үйлдлийн бодит шинж чанарыг ойлгон ухамсарлах чадваргүй буюу сэтгэцийн өвчтэй гэж үзэх хангалттай үндэслэл байвал хорих ангийн сэтгэцийн нэгжид (ажиглалт хийх нэгж) цагдан хорих шийдвэр гаргадаг. Холбогдогчийг тийнхүү ажиглахаар цагдан хорих нь түүний сэтгэцийн эрүүл мэндийг шалган тогтоох нэг арга хэлбэр байхаас гадна уг арга хэмжээний үндсэн хугацаа 1 сар байх бөгөөд хэрэв шүүх тухай бүр хугацааг 1 сараар сунгах шаардлагатай гэж үзвэл энэ нь нийт 6 сараас хэтрэхгүй байхаар хуульчилжээ³⁵.

Түүнчлэн, шүүх хорих ангийн сэтгэцийн нэгжид хоригдож байгаа хэрэг хариуцах чадваргүй этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийг шинжлэн тогтоосон буюу түүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд *тодорхойгүй хугацаагаар хорихоос өөр төрлийн байгууллагад* байрлуулахаар шийдвэрлэнэ.

Энэ арга хэмжээг магистратуудаас бүрдсэн хараат бус бүрэн эрхтэй Нийгэм Хамгааллын Хороонд харьяалагдах Хамгааллын Институтэд харуул хамгаалалтын хяналтад хэрэгжүүлэх, эсхүл энэ төрлийн эмчилгээ үзүүлдэг бусад эмнэлгийн байгууллагад тэдгээрийн зөвшөөрснөөр байрлуулахаар шийдвэрлэдэг байна.

Ийнхүү эмчлүүлэгч 6 сар тутамд сэтгэцийн эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдах ба эмчлүүлэгчийн эрүүл мэнд хангалттай сайжирсан, нийгэмд аюулгүй болсон гэж үзвэл суллах шийдвэр гаргана.

Сэтгэцийн шинжилгээг шинжээч дангаараа эсхүл 3 шинжээчийн бүрэлдэхүүнтэй гаргах ба тэдгээр нь дараах 3 асуултад зайлшгүй хариулах шаардлагатай: 1) холбогдогч нь гэмт хэрэг, зөрчил үйлдэх үедээ сэтгэцийн хувьд өөрийн үйлдлийн бодит шинж чанарыг ухамсарлах чадвартай байсан эсэх, энэ нь ямар шинж тэмдгээр илэрсэн эсэх; 2) холбогдогчийн хувийн байдал нийгэмд аюултай эсэх; 3) холбогдогчийн одоогийн сэтгэцийн байдал сайжирсан эсэх болно. Мөн шинжээчид эмчлүүлэгчийн сэтгэц, зан үйлтэй холбоотой тусгайлсан асуултууд тавигдаж болох ба өөр бусад нөхцөл байдлын талаар дүгнэлт гаргахыг шинжээчид хориглоогүй байна.

³⁵ Hans Joachim Salize & Harald Dressing, *Placement and Treatment of Mentally ill Offenders-Legislation and Practice in EU Member States, 2005, Mannheim, Germany, 99.*
<http://www.krim.dk/undersider/straffuldbyrdelse/forvaring/psykisk-afvigende-indsatte-placering-europa-eu2006.pdf>

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь хоёр үе шатыг дамжих ба ажиглалт хийх байдлаар цагдан хорих, улмаар хэрэг хариуцах чадваргүй болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдвол сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад албадан эмчлүүлэхээр шүүх шийдвэр гаргаснаар Нийгэм хамгааллын хороо нь холбогдогчийг сэтгэцийн эрүүл мэндийн аль нэг байгууллагад эмчлүүлэхээр хуваарилах, ингэснээр тодорхой хугацаанд эрүүл мэндийг магадлан шинжлэх, суллах, эсхүл цаашид эмчлэх зэрэг шийдвэрүүдийг бие даан гаргадаг нь тус улсын энэ салбар дахь өвөрмөц онцлогтой байна³⁶.

6. Бүгд Найрамдах Грек Улс

Грек улсын тухайд хэрэг хариуцах чадваргүй байдал гэх ухагдахуун анх 1870 оны Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд тусгалаа олжээ. Тухайлбал, хэрэг хариуцах чадваргүй гэдэгт хүчтэй, хоромхон зуурын сэтгэцийн өөрчлөлт автсан, хагас болон бүрэн тэнэгрэлтэй, эсхүл тархины гэмтэл буюу сэтгэцийн өвчнөөр өвчилсөн, хэвийн логикоор сэтгэн бодох чадваргүй хүнийг хамааруулан авч үздэг байв³⁷.

Грек улсад сэтгэцийн эрүүл мэндийн талаар бие даасан хууль батлагдаагүй бөгөөд хэрэг хариуцах чадваргүй байдлыг 1950 оны Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулж байна.

Эрүүгийн хуулийн 33 дугаар зүйлд хэлгүй, мөн дүлий хүн өөрийн үйлдлийн хууль бус шинж чанарыг ухамсарлах чадваргүй байсан бол түүнд оногдуулах ял, шийтгэлийг хөнгөрүүлэх, мөн гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн үйл ажиллагаа нь сарниснаар өөрийн үйлдлийн хууль бус шинж чанарыг ухамсарлах чадваргүй байсан бол түүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно гэж томьёолсон байна.

Харин 35 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэх сэдэл төрөх, гэмт хэргээ төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх үе шатуудыг хийж эхлэх үедээ эрүүл байсан боловч тухайн гэмт хэргийг үйлдэх үедээ өөрийгөө хордуулах зэргээр сэтгэцийн үйл ажиллагаагаа санаатайгаар сарниулсан, өөрийн үйлдлийн шинж чанарыг ухамсарлах үйл ажиллагаанд зориуд саад учруулах бодит алхам хийсэн бол тухайн этгээдийг хууран мэхэлсэн гэж үзэж ял, шийтгэл оногдуулна гэж заажээ.

Эрүүгийн хуулийн 38 дугаар зүйлд хэрэг хариуцах чадваргүй этгээд, эсхүл хэлгүй, мөн дүлий хүн хүндэвтэр болон түүнээс хүнд төрлийн гэмт хэрэг үйлдэж, тухайн гэмт хэрэгт 6 сар буюу түүнээс дээш хугацаагаар хорих ял

³⁶ Hans Joachim Salize & Harald Dressing, *Placement and Treatment of Mentally ill Offenders-Legislation and Practice in EU Member States, 2005, Mannheim, Germany, 99.* <http://www.krim.dk/undersider/straffuldbyrdelse/forvaring/psykisk-afvigende-indsatte-placering-europa-eu2006.pdf>

³⁷ Hans Joachim Salize & Harald Dressing, *Placement and Treatment of Mentally ill Offenders-Legislation and Practice in EU Member States, 2005, Mannheim, Germany, 100.* <http://www.krim.dk/undersider/straffuldbyrdelse/forvaring/psykisk-afvigende-indsatte-placering-europa-eu2006.pdf>

оногдуулах эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байвал шүүх тухайн этгээдийг *сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад байрлуулах, эсхүл хорих байгууллагын тусгай нэгжид хорих шийдвэр гаргана* гэж заасан.

Ингэхдээ тухайн төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээний хагасаас илүүгүй хугацаагаар эмнэлэг эсхүл хорих байгууллагын тусгай нэгжид тусгаарлахаар шийдвэрлэнэ.

Ийнхүү 2 жил тутамд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр, эсхүл хорих байгууллагын тусгай нэгжийн холбогдох шийдвэр зэргийг үндэслэн хэрэг хариуцах чадваргүй этгээдийг суллах эсэх асуудлыг тухайн шийдвэрийг гаргасан шүүх шийдвэрлэх ба хэрэв шүүх 5 жилийн дотор хэрэгтнийг суллах шийдвэр гаргаагүй бол суллах талаар дахин хэлэлцэхгүй. Мөн ямар ч тохиолдолд хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээдийг эмчлэх, хорих хугацаа нь 10 жилээс ихгүй, хүнд гэмт хэрэг үйлдсэн бол 15 жилээс ихгүй байхаар хуульчилжээ³⁸.

Нөгөөтээгүүр, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, эсхүл хорих байгууллагын тусгай нэгжид хоригдож байгаа этгээдийн сэтгэцийн эрүүл мэнд хэвийн болсон бол шүүх прокурорын санал, холбогдох эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн этгээдийг ердийн хорих байгууллагад хорих шийдвэр гаргаж болох ба түүний хэрэг хариуцах чадваргүй байхдаа эмнэлэг, хорих байгууллагад байрласан хугацааг нийт эдлэх ялд оруулан тооцдог³⁹.

Хэргийг хянан хэлэлцэж тухайн этгээдийг гэм буруутайд тооцсон бөгөөд түүний сэтгэцийн эрүүл мэндийг хорих ангийн тусгай нэгжид эмчлэх боломжтой гэж үзвэл хорих байгууллагад, хэрэв уг этгээдэд илүү нарийвчилсан эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай байгаа бол сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад байрлуулахаар шийдвэрлэдэг онцлог харагдаж байна.

7. Бүгд Найрамдах Чех Улс

Одоогийн үйлчилж байгаа Эрүүгийн хууль нь 2009 онд батлагдаж 2011 онд нэмэлт, өөрчлөлт орсон⁴⁰. Эрүүгийн хуулийн 26 дугаар хэсэгт “сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийнхээ хууль бус шинж чанарыг ухамсарлах, өөрийн үйлдлээ хянах чадваргүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан⁴¹. Мөн 40 дүгээр хэсэгт “гэмт хэрэг үйлдсэн оюун ухааны хомсдолтой хүний эрүүл мэндийн байдлыг харгалзан засах боломжтой гэж шүүх үзвэл хорих ялыг хөнгөрүүлж, давхар хамгаалах эмчилгээ хийлгэх арга хэмжээ авна”, Мөн хуулийн 47 дугаар хэсэгт “сэтгэцийн өвчний улмаас гэмт хэрэг

³⁸ Hans Joachim Salize & Harald Dressing, Placement and Treatment of Mentally ill Offenders-Legislation and Practice in EU Member States, 2005, Mannheim, Germany, 161. <http://www.krim.dk/undersider/straffuldbyrdelse/forvaring/psykisk-afvigende-indsatte-placering-europa-eu2006.pdf>

³⁹ Hans Joachim Salize & Harald Dressing, Placement and Treatment of Mentally ill Offenders-Legislation and Practice in EU Member States, 2005, Mannheim, Germany, 163. <http://www.krim.dk/undersider/straffuldbyrdelse/forvaring/psykisk-afvigende-indsatte-placering-europa-eu2006.pdf>

⁴⁰ <https://rm.coe.int/ct-legislation-czech-republic-criminal-code/16806415ce>

⁴¹ <https://rm.coe.int/ct-legislation-czech-republic-criminal-code/16806415ce>

үйлдсэн хүнийг ялаас чөлөөлж хамгаалалтын арга хэмжээ буюу хамгаалалтын эмчилгээ хийнэ” гэж тус тус заажээ.

Хамгаалалтын эмчилгээ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нөхөн сэргээх, нийгмийг хамгаалах зорилготой бөгөөд шийтгэлээс илүү үр дүнтэй байдаг гэж тодорхойлжээ.

Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлд хамгаалалтын арга хэмжээний төрлийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- 1) Хамгаалах эмчилгээ /эмчлэх эмчилгээ/;
- 2) Баривчлан хамгаалах;
- 3) Эд зүйл, бусад үнэ бүхий зүйлсийг хураах;
- 4) Хамгаалах боловсролыг зөвхөн насанд хүрээгүй хүүхдэд явуулна.

Гэмт этгээд хорих ялаар шийтгэгдсэн бол хорих ял эдэлж эхэлснээс хойш түүнд хорих ангид хамгаалах эмчилгээг хийнэ. Бусад тохиолдолд хамгаалах эмчилгээг ихэвчлэн эмнэлгийн байгууллагад хийдэг.

Хамгаалах эмчилгээний зорилгодоо хүрэх хугацааг 2 жилээс илүүгүй байхаар хуульчилсан бөгөөд энэ хугацаанд эмчилгээ дуусаагүй бол шүүх хугацааг дуусахаас өмнө дахин 2 жилээс илүүгүй хугацаагаар сунгах шийдвэр гаргаж болохоор хуульчилсан нь бусад улсуудтай харьцуулахад богино хугацааг тогтоосон байна. Мөн хамгаалах эмчилгээнээс чөлөөлөх шийдвэрийг гагцхүү шүүх гаргана.

Гэмт этгээдийн өвчний шинж чанар, эмчилгээний боломжоос шалтгаалан амбулаторийн эмчилгээ хийснээр эмчилгээний зорилго хангах боломжтой гэж шүүх үзвэл хорих ангид хэрэгжүүлэхээр заасан хамгаалах эмчилгээний арга хэмжээг амбулаторийн эмчилгээ хийх төрлөөр өөрчилж болно. Харин хорих ангид хоригдох хугацаа нь эмчилгээний зорилгыг хангахгүй гэж шүүх үзвэл хорих ял эдэлсний дараа хамгаалах эмчилгээг эрүүл мэндийн байгууллага, амбулаторид үргэлжлүүлэн эмчлэх шийдвэр гаргана гэж зохицуулсан нь мөн бусад улсаас ялгагдах онцлогийг харуулах зохицуулалт гэж дүгнэж болно.

8. Бүгд Найрамдах Эстони Улс

Тус улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх тодорхой гэмт үйлдэл хийж болохгүйг ойлгох чадваргүй этгээдийн сэтгэцийн байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно”, мөн хуулийн 34 дүгээр зүйл “Сэтгэц, оюун санааны хэмжээ хязгаар” гэсэн хэсгийн 1-д Гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдлийн хууль бус шинж чанарыг ойлгон ухамсарлах чадваргүй бөгөөд дараах нөхцөл байдал тогтоогдвол тухайн этгээдийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно гэжээ.⁴²

- 1) сэтгэцийн өвчин;
- 2) түр зуурын огцом оюуны хомсдол;

⁴² The Penal Code of Estonia, 2002. https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/estonia-criminal-code-as-amended-2013_html/Estonia_Criminal_Code_as_amended_2013.pdf

- 3) оюуны чадамжгүй байдал;
- 4) тэнэгрэх өвчтэй, эсхүл;
- 5) бусад оюуны хомсдол.

Тус хуулийн 35 дугаар зүйлд “Оюуны чадварын хоцрогдол” гэсэн хэсэгт “Энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл байдлын улмаас оюуны чадвар нь хоцрогдож, өөрийн үйлдлийн хууль бус шинж чанарыг ойлгон ухамсарлах чадваргүй этгээдэд шүүх энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэглэнэ” гэжээ.

Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл, хэрэгжүүлэх байгууллагын төрөл, шинжийг тодорхойлсон байна. Тухайлбал, энэ зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ, үйлдсэний дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсөн бөгөөд өөртөө болон нийгэмд аюултай гэж үзэх үндэслэл байвал шүүх тухайн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэвтэн эмчлүүлж хийнэ”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөртөө болон нийгэмд аюул учруулахааргүй, эмчилгээний тодорхой горимыг дагаж мөрдөх чадвартай гэж үзвэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэвтэн эмчлүүлэхгүйгээр хэрэглэж болно”, “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тусгайлан эрх олгогдсон байгууллага хэрэгжүүлнэ”⁴³ гэж заажээ”.

Харин энэ зүйлийн 4 дэх хэсэгт “Эмнэлгийн чанартай арга хэмжээг гэмт этгээдийг эдгэрэх хүртэл, эсхүл нийгэмд аюул учруулах үндэслэл арилсан гэж үзэх нөхцөл байдал тогтоогдох хүртэл хэрэглэх ба уг арга хэмжээг зогсоох хугацааг шүүх тогтооно” гэж заасан нь тодорхой хугацаа заагаагүйг харуулж байна. Мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох ба эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 1 хоногийг хорих ялын 1 хоногтой дүйцүүлэн тооцно” гэж заасан нь манай улсын хуулийн зохицуулалттай төстэй байна.

Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлд өвчний учир эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэргийг шийдвэрлэхээс өмнө, эсхүл шийдвэрлэсний дараа сэтгэцийн өвчнөөр өвчилж, өөрийн үйлдлийг ойлгон ухамсарлах чадваргүй болсон бол шүүх тухайн этгээдийг эрүүгийн хариуцлага, эсхүл ял эдлэхээс чөлөөлж, түүнд оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн ялтай тэнцүү хэмжээгээр хяналтын хугацаа тогтооно.” гэж заажээ. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хяналтын хугацаанд тухайн этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал хэвийн болсон, эдгэрсэн бол шүүх түүнд оногдуулсан, эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр

⁴³ The Penal Code of Estonia, 2002. https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/estonia-criminal-ode-as-amended-2013_html/Estonia_Criminal_Code_as_amended_2013.pdf

шийдвэрлэнэ.” гэж заасан.

Тус хуулийн 692 дугаар зүйлд хорих ялыг эмнэлгийн чанартай арга хэмжээгээр солих зохицуулалтыг нарийвчлан тусгасан нь онцлог байна. Үүнд:

- Оюуны хомсдолтой боловч өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадвартай этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар байвал шүүх хорих ял оногдуулахгүйгээр эмнэлгийн чанартай арга хэмжээгээр сольж болно;
- Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг дангаар хэрэглэж болохгүй бөгөөд оногдуулах эрүүгийн хариуцлагын зарим хэсэгт дүйцүүлэн хэрэглэж болно;
- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтооход хэрэглэж болно.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн хорих ялыг эмнэлгийн чанартай арга хэмжээгээр солих бөгөөд эмчлэх хугацаа 18 сараас багагүй, 3 жилээс ихгүй байхаар тогтоожээ.

Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай нэмэлт арга хэмжээ гэдэгт: 1) мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос хамааралтай этгээдэд хийх нэмэлт эмчилгээ; 2) бэлгийн чиг хандлагын өөрчлөлтөөс шалтгаалан хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хийх цогц эмчилгээ хамаарна. Эмчилгээг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, эсхүл эмнэлэгт очиж эмчлүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ. Эмнэлгийн чанартай арга хэмжээг Эрүүл мэндийн байгууллагын тухай хуульд заасан журмын дагуу санхүүжүүлдэг байна.

Эмчлүүлэгч эмчлүүлэх явцдаа түүнд тавигдах шаардлага, хүлээлгэх үүргийг сахин биелүүлэх үүрэгтэй. Хэрэв эмчлүүлэгч эмчилгээ хийлгэхээс татгалзсан, эмчилгээний горим, түүнд хүлээлгэсэн үүргийг мөрдөхөөс зайлсхийсэн бол эмнэлгийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан эмчлүүлэгчид сануулах арга хэмжээ авч, түүний зөвшөөрөлтэйгөөр электрон хяналтын төхөөрөмжөөр ажиглалт явуулах эрхтэй бөгөөд эмчлүүлэгч эмчилгээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаанаас өмнө дуусгах талаар бичгээр хүсэлт гаргасан, эсхүл холбогдох эмчилгээг хийсэн боловч тухайн эмчилгээ нь тодорхой шалтгааны улмаас эмчлүүлэгчид сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байвал шүүх тухайн этгээдэд цагдан хорих арга хэмжээ авахаар шийдвэрлэж болно.

Хэрэв эмчлүүлэгч эмчилгээ хийлгэх явцдаа шинээр гэмт хэрэг үйлдвэл шүүх эмчилгээг зогсоож, түүнд цагдан хорих арга хэмжээ авахаар шийдвэрлэнэ.

Эстони улсын Эрүүгийн хуулийн онцлог зохицуулалт нь сэтгэцийн өвчтэй хүн өөртөө болон нийгэмд аюулгүй гэж үзвэл эмнэлэгт хэвтэхгүй, өөрөө очин эмчлүүлэх бөгөөд эмчлүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд цагдан хорих арга хэмжээ авч албадан эмчилдэг байна.

9. Шведийн Хаант Улс

Швед Улсын Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт “Эрүүгийн хариуцлага оногдуулахад харгалзах зүйл” гэсэн зохицуулалтыг хуульчилж, тус бүлгийн 3 дугаар зүйлд эрүүгийн хариуцлага оногдуулахад харгалзан нөхцөлийг хуульчилсан бөгөөд дурдсан нөхцөл тогтоогдвол шүүх оногдуулах ялыг хөнгөрүүлэн авч үзнэ.⁴⁴ Үүнд:

- 1) гэмт хэрэг үйлдэхэд өөр бусад этгээдийн зүй бус үйлдэл байсан эсэх;
- 2) гэмт хэрэг үйлдэх үедээ оюуны сааталд орсон буюу өөрийн үйлдлийн бодит мөн чанарыг ухамсарлах чадваргүйд хүргэх оюун санааны хязгаарлагдмал байдалд байсан;
- 3) гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэл, оролцоо нь түүний биеийн болон оюуны чадамж, туршлагаас хамаарсан эсэх;
- 4) тухайн үйлдэл нь гарцаагүй байдлын улмаас хийгдсэн эсэх;
- 5) тухайн үйлдэл нь энэ хуулийн 24 дүгээр бүлэгт заасан нөхцөл байдлыг хангаж байгаа эсэх.

Тус хуулийн 30 дугаар зүйлд “Оногдуулах эрүүгийн хариуцлагын төрлийг сонгох” гэсэн бүлгийн 6 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан бол шүүх тухайн этгээдэд хорих ял оногдуулахгүйгээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Харин энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл байдалд энэ хэсэг хамаарахгүй гэжээ.

Мөн хуулийн 31 дүгээр бүлгийн “Бусдын асран хамгаалалтад өгөх” гэсэн хэсгийн 3 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан гэж үзэх үндэслэл байвал шүүх шинжээч томилж, тухайн этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон шинжээчийн дүгнэлтийг үндэслэн гэм буруутай этгээдэд ял оногдуулахгүйгээр *сэтгэцийн эмнэлгийн асран хамгаалалтад шилжүүлэх албадлагын арга хэмжээ авч болно.*” гэжээ. Мөн 36 дугаар бүлэгт “Эд хөрөнгө хураах, хуулийн этгээдэд торгууль оногдуулах болон бусад хариуцлага” гэсэн хэсгийн 13 дугаар зүйлд “Гэмт

хэрэг үйлдэх үедээ 15 насанд хүрээгүй, эсхүл сэтгэцийн хүчтэй сааталд орсон бол шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэм буруутай этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан гэм буруутай этгээдэд ногдох эд хөрөнгөөс хураах эрүүгийн хариуцлага оногдуулж болно.” гэжээ.

Дээрх зохицуулалтаас үзэхэд хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулдаггүй, харин эмчилгээний арга хэмжээ хэрэглэдэг, насанд хүрээгүй сэтгэцийн сааталтай хүмүүсийн үйлдлийн төлөө мөнгөн төлбөр оногдуулах зохицуулалтыг эрүүгийн хуулиараа тодорхойлсон, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг ямар нэгэн хэмжээнд авч үздэг болох нь дүгнэгдэж байна.

⁴⁴ The Swedish Criminal Code, 1965. <https://www.government.code.pdf>

III. АЗИЙН ОРНЫ ЗАРИМ УЛС

1. Япон Улс

Япон улсын Эрүүгийн хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Сэтгэцийн эмгэгийн улмаас хийсэн үйлдэл, эс үйлдэхүйд хариуцлага хүлээлгэхгүй”, 2 дахь хэсэгт “Оюун ухааны хомсдолын улмаас гэмт хэрэг үйлдсэн бол хүлээлгэх ял шийтгэлийг хөнгөрүүлнэ” гэж тус тус заасан.⁴⁵ Харин сэтгэцийн эмгэгийн улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд албадан эмчлэх арга хэмжээг эрүүгийн хуулиар нарийвчлан тогтоогүй, бусад хуулиар зохицуулдаг онцлогтой байна.

Япон улс 2005 онд “Сэтгэцийн эмгэгийн улмаас хүнд хор уршиг учруулсан иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, хяналт тавих тухай” хуулийг шинэчлэн баталсан нь сэтгэцийн өөрчлөлтийн улмаас гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг эмчлэх, аюулгүй байдлыг хангах, нийгэм хамт олонд тулгуурласан эмчилгээ хийх талаар томоохон өөрчлөлтийг бий болгожээ. Өмнө нь үйлчилж байсан хууль зөвхөн гэмт хэрэг давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг үндсэн чиглэлээ болгож байсан бол 2005 онд шинэчлэн баталсан хуулийн хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмийн амьдралд эргэн нэгтгэх, эмчилгээг сайжруулах, нийгмийн нэг хэсэг хэвээр байлгах, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, бодлогыг илүүтэй баримталсан байна.

Энэ хуулиар гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнийг хэвтүүлэх болон гадуур эмчлэх хоёр төрлийн арга хэмжээг бий болгожээ.

Гэмт хэрэг үйлдсэн тухайн хүнийг гадуур, эсхүл урьдчилан тогтоосон эмнэлгийн байгууллагад хэвтэн эмчлүүлэх шийдвэрийг мэргэшсэн шинжээчийн бүрэлдэхүүн гаргадаг бөгөөд шинжээчийн бүрэлдэхүүнд сэтгэцийн эмгэгийг тогтоох, эмчилгээнд хамруулах эсэхийг шийдвэрлэдэг шүүгч болон шүүх эмнэлгийн сэтгэцийн мэргэшсэн шинжээч багтдаг.⁴⁶ Ийнхүү шийдвэр гаргахад гурван шалгуурыг баримтална:

- 1) сэтгэцийн эмгэгийн түвшин ба сэтгэцийн эмгэг болон гэмт хэргийн хоорондын шалтгаант холбоо;
- 2) эмчлэгдэх боломж;
- 3) нийгэмд эргэн нэгтгэхэд саад болж болохуйц хүчин зүйлс.

Сэтгэцийн эмгэгийн улмаас хүнд хор уршиг учруулсан иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, хяналт тавих тухай хуулийн онцлог нь хүнийг санаатай алах, дээрэмдэх, хүний эрүүл мэндэд гэмтэл учруулах, галдан шатаах, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд үйлчилдэг бол бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд “Сэтгэцийн эрүүл

⁴⁵ Япон улсын Эрүүгийн хууль, Япон Улсын Хууль зүйн яамны албан ёсны цахим хуудас дахь англи хэл дээрх орчуулга. Цахим холбоос: http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=1960

⁴⁶ Ando, Kumiko & Soshi, Takahiro & Nakazawa, Kanako & Noda, Takamasa & Okada, Takayuki. (2016). Risk Factors for Problematic Behaviors among Forensic Outpatients under the Medical Treatment and Supervision Act in Japan. *Frontiers in Psychiatry*. 7. 10.3389/fpsy.2016.00144.

мэнд, халамжийн тухай хууль"-иар зохицуулдаг байна.⁴⁷

2007 оны байдлаар Япон улсын хэмжээнд "Сэтгэцийн эмгэгийн улмаас хүнд хор уршиг учруулсан иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, хяналт тавих тухай" хуулийн хэрэгжилтийг хангах, хэвтэн эмчлэх 14 эмнэлэг байсан бол 2013 онд 30 гаруй болж нэмэгджээ. Харин "Сэтгэцийн эрүүл мэнд, халамжийн тухай хууль"-ийн үйлчлэлд хамаарах бусад төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадуур эмчлэх эмнэлэг 2014 оны байдлаар Япон улсын хэмжээнд 452 ажиллаж байжээ.⁴⁸

Эрүүгийн хуульд заасан ноцтой гэмт хэрэг үйлдэж хэвтүүлэн эмчлэх арга хэмжээ авсан шийдвэрийг хэрэгжүүлж байгаа тусгай эмнэлгийн эрхлэгч тухайн этгээдийг үргэлжлүүлэн эмчлүүлэх шаардлагатай эсэхийг 6 сар тутам хянан дүгнэж, эмнэлгээс гаргах нь зүйтэй гэж үзвэл шүүхэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэхээр зохицуулжээ.

Харин гадуур эмчлэх шийдвэртэй хүний хувьд тэнсэн харгалзах арга хэмжээнд хяналт тавих албаны Сэтгэцийн эрүүл мэндийн хяналтын албанаас хяналт тавьдаг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүн нэг бүрд чиглэсэн төлөвлөгөөг гаргадаг. Нийт хугацаа гурван жил байх бөгөөд хоёр жилийн хугацаагаар сунгаж болно. Тэнсэн харгалзах арга хэмжээнд хяналт тавих албанаас хэрэв тухайн этгээдийн байдал дордсон тохиолдолд хэвтүүлэн эмчлүүлэх арга хэмжээ авхуулахаар шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн хэлэлцүүлгээр шийдвэрлэдэг байна.

2. Израил Улс

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт нь Израил улсад 1991 онд батлагдсан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулагдаж байна⁴⁹. Израилд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болзошгүй этгээдэд улсаас төлбөргүй өмгөөлөгч томилон өгдөг байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө хэрэг хариуцах чадваргүй гэж үзвэл өөрийн биеэр, эсхүл өмгөөлөгчөөрөө дамжуулан сэтгэцийн эрүүл мэндийн байдлаа шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргах эрхтэй. Нөгөөтээгүүр, цагдаагийн байгууллага шүүхэд хүсэлт гаргах, эсхүл шүүх өөрийн санаачилгаар шийдвэрлэх эрхтэй байна.

Ийнхүү өвчтөнд сэтгэцийн эрүүл мэндийн ажиглалт хийх, шинжилгээ хийх шийдвэр гарсан тохиолдолд энэ нь гурван өдрөөс гурван долоо хоног

⁴⁷ Dimitri Vanoverbeke, The Medical Treatment and Supervision Act (2005):Forensic Mental Health in Japan Today, P.9, https://www.academia.edu/20114107/The_Medical_Treatment_and_Supervision_Act_2005_Forensic_Mental_Health_in_Japan_Today

⁴⁸ Van Enis, Ann-Sofie. "The Medical Treatment and Supervision Act (2005): Forensic Mental Health in Japan Today." *Nippaku*, January 20, 2015.

⁴⁹ Official web page of Ministry of Health of Israel.

https://www.health.gov.il/English/Topics/Mental_Health/treatment/Hospitalization/Pages/Involuntary.aspx

хүртэл хугацаагаар үргэлжлэх бөгөөд эрх бүхий шинжээч тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, эсхүл сэтгэцийн тодорхой ямар нэгэн нөхцөл байдалд байсан талаар дүгнэлт гаргаснаар шүүхийн дараа дараагийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шалтгаална.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй бөгөөд нэгэнт уг шийдвэрээр сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа бол өвчтөний сэтгэцийн эрүүл мэндийн байдлын талаарх шинжилгээг 6 сар тутамд явуулах ба эмнэлгээс гаргах эсэх асуудлыг тухайн дүүргийн Сэтгэцийн эрүүл мэндийн хороо (хоёр сэтгэл зүйч, нэг хуульчаас бүрдэх) бие даан шийдвэрлэх эрхтэй байна.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Ихэнх улс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг эрүүгийн хуулиар зохицуулж байгаа бол зарим улсад иргэний болон бусад бие даасан хуулиар шийдвэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлагын хүрээнд дангаар болон ялтай хамт хэрэглэх, эсхүл урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын хүрээнд хэрэглэдэг болох нь дүгнэгдэж байна.

Харин албадан эмчлэх арга хэмжээг хэрэглэх үндэслэлд: 1) эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хэрэг хариуцах чадваргүй үедээ эсхүл сэтгэцийн эмгэгийн улмаас үйлдсэн; 2) гэмт хэрэг үйлдсэний дараа ял оногдуулах үед сэтгэцийн эмгэг үүссэн, 3) согтуурах, мансуурах донтох өвчтэй хүнийг эмчлэх зайлшгүй шаардлага үүссэн; 4) хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн; 5) сэтгэцийн болон бусад өвчинтэй болох нь тогтоогдсон (Киргиз) зэргийг дурдаж болно. Түүнчлэн хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварыг Франц, Герман, ОХУ, Япон зэрэг орнуудын эрүүгийн хуульд уг арга хэмжээг хэрэглэх үндэслэл болгон хуульчилжээ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг амбулаторийн хяналтад гадуур эмчлүүлэх; сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх; хорих ангийн тусгай нэгжид эмчлүүлэх; донтох зуршлын эсрэг эмчилгээг гадуур болон хэвтэн эмчлүүлэх гэсэн төрлөөр хэрэгжүүлж байна. Ихэнх улсад албадан эмчлэх арга хэмжээний хугацааг шууд тогтоодоггүй, харин эмчилгээний явцад өвчний шинж байдал, өөрчлөлтийг зургаан сар тутам хянан магадалдаг нийтлэг хандлага байгаа бол согтуурах, мансуурах бодист донтсон хүмүүст хугацаа тогтоож энэ арга хэмжээг хэрэглэдэг нийтлэг хандлага (ХБНГУ, Грек Их Британид) байна.

V. НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

1. МУИС-ХЗС Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль, УБ., 2021

2. Б.Батзориг, Э.Зууннасан, БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ., 2006
3. Э.Хилгендорф. Д.Чанцалдулам, Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ.,2015.
4. С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги.УБ., 1999. 386 дахь тал.
5. Япон улсын Эрүүгийн хууль, Япон Улсын Хууль зүйн яамны албан ёсны цахим хуудас дахь англи хэл дээрх орчуулга. Цахим холбоос: http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=1960

Гадаад эх сурвалж:

1. Калинина.Т.М., Принудительные меры медицинского характера: Понятие, виды, цели. Lex Russica. 2013. №6. С.623. https://nbpublish.com/library_get_pdf.php?id=24492
2. Постановление Пленума Верховного Суда Российской Федерации, *О практике применения судами принудительных мер медицинского характера*, №6, 2011. <https://rg.ru/2011/04/20/verhovniy-sud-dok.html>
3. Уголовный кодекс Российской Федерации, 1996. <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody&nd=102041891>
4. Linz J., Stepan A., *Problems of Democratic Transition and Consolidation: Southern Europe, South America and Post-Communist Europe*, Baltimore and London, Johns Hopkins University Press, P.480.1996.
5. Уголовный кодекс Республики Казахстан, 1997.<https://adilet.zan.kz/rus/docs/K1400000226>
6. Уголовно-процессуальный кодекс Республики Казахстан, 2014. <https://adilet.zan.kz/rus/docs/K1400000231>
7. Criminal Code of the Kyrgyz Republic <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/67156/104401/F1696552027/KGZ67156%20Eng.pdf>
8. The France Penal Code, 1992, https://sherloc.unodc.org/cld/document/fra/1992/penal_code_en.html
Mental Health Act 1983, Part 3, 35 (7), <https://www.legislation.gov.uk/ukpga/1983/20>
9. Hans Joachim Salize & Harald Dressing, *Placement and Treatment of Mentally ill Offenders-Legislation and Practice in EU Member States, 2005, Mannheim, Germany, 99.*
<http://www.krim.dk/undersider/straffuldbyrdelse/forvaring/psykisk-afvigende-indsatte-placering-europa-eu2006.pdf>
10. The Swedish Criminal Code, 1965.<https://www.government.code.pdf>
11. Ando, Kumiko & Soshi, Takahiro & Nakazawa, Kanako & Noda, Takamasa & Okada, Takayuki. (2016). Risk Factors for Problematic Behaviors among Forensic Outpatients under the Medical Treatment and Supervision Act in Japan. *Frontiers in Psychiatry*. 7. 10.3389/fpsyt.2016.00144.
12. Dimitri Vanoverbeke, *The Medical Treatment and Supervision Act (2005):Forensic Mental Health in Japan Today*, P.9, https://www.academia.edu/20114107/The_Medical_Treatment_and_Supervision_Act_2005_Forensic_Mental_Health_in_Japan_Today
13. Van Enis, Ann-Sofie. "The Medical Treatment and Supervision Act (2005): Forensic Mental Health in



С.Ганцэцэг

Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

SOME CHALLENGES FACING THE IMPLEMENTATION OF THE LABOUR LAW OF MONGOLIA

Хураангуй: Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл нь тухайн хуулийн зохицуулалтаас хамаарч байх бөгөөд шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэхэд ажил олгогч бэлэн биш байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэ зохицуулалт бодит байдалд хэрэгжүүлэхэд санхүүгийн тооцоолол хийгдээгүйгээс ажилтан, ажил олгогчид бэрхшээл учруулж байна.

Abstract: Difficulties in implementing the Labor Law will depend on the regulation of the law, and the employer is not ready to implement the new regulation. The lack of financial calculations for the implementation of the new regulations of the Labor Law creates difficulties for employees and employers.

Түлхүүр үг: Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн гэрээ, ажлын цаг

Key words: employment relations, labor relations, labor contract, working hours

I. ҮНДСЭН ХЭСЭГ

Нэгдсэн үндэсний байгууллагаас 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй” хэмээн заасан нь хүний хөдөлмөрөө үнэлүүлэх, чөлөөтэйгөөр хөдөлмөр эрхлэх эрх зүйн суурь зохицуулалт болжээ.

Монгол Улсад хөдөлмөрийн харилцааг 1925 онд “Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм”-ээр анх зохицуулж байсан нь хөдөлмөрийн харилцааны эрх зүйн үндсийг тавьсан бөгөөд 1930, 1933, 1934, 1941, 1973, 1991, 1999 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулиуд нь тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан хөдөлмөрийн харилцааны асуудлыг зохицуулж ирсэн уламжлалтай.

Өдгөө хөдөлмөрийн харилцаа хэлбэр, агуулгын хувьд гүнзгийрэн өргөжиж хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа, бүтэн бус цагаар ажиллах, зайнаас ажиллах, хувь хүн хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллах (туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан гэх мэт), алслагдмал газар байрлаж ажил, үүргээ гүйцэтгэх зэрэг шинэ хандлага, арга хэлбэр нэвтэрсээр байгаа боловч эдгээр хөдөлмөр эрхлэлтийн шинэ харилцааг зохицуулах эрх зүйн акт байхгүй байсныг Улсын Их хурлаас 2021 оны 07 дугаар сард Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар эрх зүйн орчин бүрдсэн нь эерэг талтай.

Хөдөлмөрийн тухай хуульд “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа”, “Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл”, “Хөдөлмөрийн хамтын харилцаа”, “Ажлын бүрэн бус цагаар ажиллах”, “Бөөнөөр халах”, “Дотоод хэм хэмжээ” зэрэг шинэ нэр томъёо орсон бөгөөд эдгээр нь хөдөлмөрийн харилцаанд шинэ зохицуулалт бий болсныг илэрхийлнэ.

Гэвч хэрэгжээд жил хагасын нүүр үзэж Хөдөлмөрийн тухай хуулийг ажил олгогч тал болон ажилтан хэрэглэж хэрэгжүүлэхэд цөөнгүй хүндрэл гарсаар байгаа нь илт болсон.

Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт “ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа” гэдэгт ажил үүргээ гүйцэтгэх, албан томилолтоор ажиллах, ажилдаа ирэх очих, ээлж солилцох, ажил хүлээлцэх, сургалтад хамрагдах болон ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ зэрэг хамаарна” гэж зохицуулсан нь хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах харилцааны агуулгыг тодорхойлжээ.

Хөдөлмөрийн харилцааг өмнө нь хөдөлмөрийн гэрээ байгуулснаар үүсэнд тооцдог байсан бол харин одоо хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүссэнээр буюу ажил үүргээ ажилтан гүйцэтгэж эхэлснээр тооцох болсон нь ажилтны эрх ашгийг хамгаалсан зохицуулалт болсон. Мөн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа гэх нэр томъёоны агуулга нь Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд “Ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь ажилд орох гэж байгаа хүнтэй түүний гүйцэтгэх ажил үүрэг, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн бусад нөхцөлийг харилцан тохиролцох бөгөөд ажилтан ажил үүргээ гүйцэтгэж

эхэлснээр хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүснэ” гэж зааснаар илэрхийлэгдэнэ. Энэ нь нэг ажилтныг хамгаалсан гол зохицуулалт бөгөөд зарим тохиолдолд ажил олгогч хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй байх, түүнчлэн гэрээ байгуулаагүй гэдэг үндэслэлээр цалин хөлс олгохоос татгалзах, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхөөс зайлсхийх зөрчлийг зохицуулсан болно.

Мөн Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн зах зээлд аль хэдийн бий болсон зохицуулалтгүй байсан харилцааг зохицуулсан нь оновчтой байна. Тухайлбал, бүрэн бус цагаар ажиллах, зайнаас ажиллах, гэрээс ажиллах, хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа, хувь хүн хоорондын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг хуулиар шинээр зохицуулсан. Гэвч Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд хөдөлмөрийн гэрээг хугацаатай байгуулах тохиолдлыг зааж, үүнээс бусад тохиолдолд гэрээг хугацаагүй байгуулахаар заажээ. Тэгвэл Хөдөлмөрийн тухай хуулийн 66-68 дугаар зүйлд шинээр орж ирсэн ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, зайнаас ажиллуулах, гэрээс ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулах тохиолдолд хугацаагүй байгуулах уу? гэдэг асуудал үүснэ. Угтаа бол эдгээр зохицуулалт нь хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүссэн ажилтанд тодорхой нөхцөл үүсэхэд хэрэглэх боломжтой атал хугацаагүй хөдөлмөрийн гэрээтэй ажилтантай эдгээр төрлийн гэрээг хэрхэн байгуулах вэ? гэдэг ойлгомжгүй зүйл үүсч байна. Эдгээр шинэ зохицуулалт нь хөдөлмөрийн харилцаанд шинэ тутам зайлшгүй хэрэгцээтэй зохицуулалт мөн. Гэхдээ үүнийг гэрээгээр зохицуулах нь хэр оновчтой вэ? Учир нь, эдгээр нь хөдөлмөрийн харилцааны явцад үүсэж болох харилцаа атал дахин шинээр гэрээ байгуулах уу? уг байгуулж буй гэрээ нь хугацаагүй байх уу?

МҮХАҮТ-ын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлөөс Хөдөлмөрийн шинэчилсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад тулгарч буй асуудлын талаар компанийн хуулийн зөвлөх, хүний нөөцийн асуудал хариуцсан захирал, менежерүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, тэд Хөдөлмөрийн хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлын талаар байр сууриа илэрхийлсэн. Жишээ нь, уг хэлэлцүүлэгт Скайтел” компанийн Хүний нөөц, хууль эрх зүйн албаны захирал, МҮХАҮТ-ын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлийн дарга Б.Жамбалсүрэн *“Ажлын бүтэн бус цагийн ажилтны хөдөлмөрийн харилцаа, ээлжийн ажлын цагийн зохицуулалт, илүү цагийн хязгаарлалттай холбоотой хүндрэл үүсэж байгаа”* хэмээн илэрхийлсэн.

Хөдөлмөрийн харилцаа гэх шинэ нэр томъёонд байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээ хамаарна гэсэн. Тэгвэл, ажилтан байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцоогүй бол сахилгын шийтгэл хүлээх үндэслэл үүсэх үү? гэдэг эргэлзээтэй асуудал гарч байгаа. Учир нь, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэгт сахилгын зөрчил гэдгийг өргөн хүрээнд тодорхойлсон: *“Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, ажлын байрны тодорхойлолтыг зөрчсөн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчилд тооцно.”* Энэ агуулгаас үзэхэд дээрх тохиолдолд сахилгын шийтгэл хүлээх үндэслэл байгаа мэт. Гэтэл олон нийтийн арга хэмжээ гэдгийг хэрхэн

хэмжих, цалин хөлсийг хэрхэн тооцох зохицуулалт Хөдөлмөрийн тухай хуульд зохицуулаагүй байна.

Ажлын байрны дарамтын талаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д бэлгийн дарамтын тухай заалтаар хязгаарлаж, Хөдөлмөрийн тухай хуульд байхгүй хийдэл байсныг хуулийн 6 болон 7 дугаар зүйлээр зохицуулжээ. Гэтэл уг зохицуулалтыг байгууллага хөдөлмөрийн дотоод журамд нарийвчлах байдлаар хэрэглэхээр заасан нь ажил олгогчид хүндрэл үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд энэ талаарх зохицуулалтыг хэрхэн тусгах талаар нэгдсэн ойлголтгүй байна.

Угтаа бол Н.Лүндэндорж Хуулийн эцсийн зорилго бол хууль байхад биш идэвхтэй үйлчилж нийгмийн харилцааг зохицуулж байхад оршино. Хууль бол хүмүүсийн хоорондын арилжаа наймаа, ахуйн энгийн харилцаанаас эхлээд хүн, төр хоёрын харилцаа, төр, нийгмийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон хүний амь насыг хүртэлх асуудлыг шийдвэрлэдэг асар их хүчин чадалтай байдаг. Хуулийн асар их хүчин чадал нь эрх зүйн бүх салбарт өндөр мэргэшсэн, мэргэжлийн өс зүйн эрхэм дээд чанарыг эзэмшсэн албан хаагчийн гарт байж, түүний оюун ухаанаар, бодох, шийдвэрлэх үйл ажиллагаагаар хэрэгждэг юм¹ хэмээн бүтээлдээ дурдсан оновчтой болжээ.

Хөдөлмөрийн тухай хуульд хэрэглэхэд хүндрэл учирч буй дараагийн зохицуулалт нь уртын ээлжээр ажиллуулах харилцаа болно.

Хөдөлмөрийн тухай хуулийн 92.4 Уртын ээлжээр ажиллах ажилтны нэг ээлжид ажил гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байхаар заасны дагуу ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын цалингийн зардал, ажлын байрны тоонд хэрхэн өөрчлөлт гарсныг судлахад нэг ажилтны сарын дундаж цалин 25.5 хувиар буурч, нийт ажилтны цалингийн зардал сард дунджаар 25.1 хувь өссөн, ажлын байрны тоо дунджаар 46 хувь өссөн”.

“Оюу толгой” компанийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал Д.Амарбаясгалан Уртын ээлжийг хатуу тогтоосныг уян хатан болгох, илүү цагийн тооцооллын нэг мөр ойлгох талаар саналаа дээрх хэлэлцүүлэгт илэрхийлсэн.

ХААН банкны Хүний нөөц, захиргаа удирдлагын газрын захирал Н.Ариунтуул “Хөдөлмөрийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бичиг баримт, гэрээ зэргийг заавал хэвлэх, гарын үсэг зурж баталгаажуулах шаардлага тулгардаг. Үүнийг цахим гарын үсэг ашиглан, гэрээг цахимаар байгуулах, гэрээс ажиллах, зайнаас ажиллах зохицуулалтын нарийн зааг ялгааг тодорхойлох шаардлагатай” байгааг дурдаад нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл нь хүний эрхийг хүндэтгээгүй, хэрэгжих боломжгүй заалт” гэв.

“М-Си-Эс проперти” ХХК-ийн Хуулийн ахлах зөвлөх Э.Банзрагч “Уул уурхай, олборлох салбарын ажил олгогч уртын ээлжээр ажиллуулах талаар зохицуулсан нь газар тариалан, хөдөө аж ахуй зэрэг бусад салбарын ажилтнуудын уртын ээлжээр ажиллахыг хязгаарласан зохицуулалт болсон, уртын ээлжээр ажилладаг

¹ Н.Лүндэндорж, “Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага”УБ., 2009., 25 дахь тал

ажилтны нөхөн амрах хугацааг тодорхой заагаагүй, уртын ээлжээр ажиллах хугацааг 14, 14 хоног хэмээн хатуу тогтоож өгсөн нь ажиллах, амрах хугацааг талууд харилцан тохиролцож, Хөдөлмөрийн гэрээгээрээ зохицуулах боломжийг хааж байгаа” гэлээ.

Уртын ээлжээр ажиллах ажилтны нэг ээлжид ажил гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног болсноос шалтгаалж, орон тоогоо нэмсэн ч ажиллах хүчний хомсдолд орох болсон, ажилтны хувьд цалин хөлсний орлого буурсан зэрэг ажилтан, ажил олгогч талуудад хохиролтой үр дагавартай байгаа учраас уян хатан, талууд гэрээгээрээ зохицуулдаг болох, уртын ээлжээр ажилладаг ажилтнуудын ээлжийн амралтыг нарийвчлан зохицуулах, үндсэн цалин бус дундаж цалин хөлсийг баримтлан нэмэгдэл хөлс, олговрыг тооцон олгох зэрэг асуудал үүсэж байна. Дараагийн хөндөх зүйл бол ажил, амралтын цагтай холбоотой зохицуулалт болно. Хөдөлмөрийн тухай хуульд хүйсийн ялгамжтай байдалд хүндэтгэлтэй хандаж, гэр бүлийн тэнцвэртэй байдлыг хадгалах зорилгоор хүүхэд асрах чөлөөг ажилтанд олгох, шинээр төрсөн хүүхдээ асрахад зориулж аавд нь ажлын 10 хоногийн чөлөө өгөх, энэ нь олговортой байх талаар зохицуулсан.

Гэтэл үр дагаврыг бүрэн тооцоогүй зохицуулалт болсон байна. Үр дагавар гэдэг нь тулгамдсан асуудлын шууд нөлөөгөөр хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын хүрээнд үүссэн үзэгдэл, үйл явцыг хэлнэ.² Учир нь, Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлд “Эцэгт шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10-аас доошгүй өдрийн чөлөөг ажил олгогч олгож, тухайн хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгоно”, мөн 139 дүгээр зүйлд “Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна” гэж заасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-тай зарим талаар зөрчилдөж байна. Учир нь, хуулийн зохицуулалтыг үзэхэд тухайн тохиолдолд чөлөө авсан бол олговортой байх, мөн тэтгэмжтэй байх эсэхийг ажил олгогч шийдэхээр байна. Хэрэв ажилтан олговор эсхүл тэтгэмж авсан гэвэл Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод хамаарахгүй байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 138 дугаар зүйлд заасан тохиолдолд ч нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй. Гэтэл үндэслэл өөр ч хүүхэд асрах чөлөө авч байгаа ажилтанд ээлжийн амралтад чөлөөтэй байгаа хугацааг тооцох эсэх нь дээрх журамд ялгамжтай оруулжээ. Журмын 2.5 дахь хэсэгт “Хүүхэд асрах чөлөөтэй байсан... хугацаанд ээлжийн амралт тооцож олгохгүй” гэсэн бол 2.6 дахь хэсэгт “Жирэмсний болон амаржсаны амралттай байсан, Хөдөлмөрийн тухай хуулийн 138.1-д заасны дагуу тэтгэмжтэй чөлөөтэй

² Я.Бямбасүрэн, “Төрийн бодлого”, 2020, 82 дахь тал

байсан... хугацаанд ээлжийн амралт тооцож олгоно” гэж агуулгын хувьд ижил зохицуулалтад ялгамжтай байдлаар ээлжийн амралт олгохоор журамлажээ.

Хөдөлмөрийн тухай хуулиар эхлэн хөдөө аж ахуйн салбар, бөөний болон жижиглэн худалдаа, машин засварын салбарт нийт ажиллах хүчний 46.3 хувь нь ажиллаж байна.³ Эдгээр салбарт ажил олгогч ихэвчлэн иргэн байх тохиолдол бий бөгөөд хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр иргэнийг ажиллуулах зөрчил цөөнгүй байсныг хувь хүн хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулах боломж олгох замаар арилгасан.

Хөдөлмөрийн харилцаанд эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхийг хангах, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах, ажлын байран дахь дарамтыг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, албадан хөдөлмөрийг хориглох зэрэг хөдөлмөрийн харилцааны үндсэн эрхүүдийг хуульчилсан нь өмнөх хуулиас зарчмын хувьд дэвшилтэт зохицуулалтыг бий болгожээ.

II. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль шинэчлэгдэж шинэ зохицуулалт бий болсон ч шүүхээр шийдвэрлэх маргааны тоо буурахгүй байгаа нь шүүхийн статистик мэдээнээс харагдаж байна. Тухайлбал, 2021 онд Монгол Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр 1169⁴ байсан бол хууль хэрэгжиж эхэлсэн өнгөрсөн онд 1157 болж тоон дүнгийн хувьд буураагүй байна.⁵ Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 154 дүгээр зүйлд заасан эрхийн маргаан шийдвэрлэх үе шат үр дүн гаргахгүй байгааг илэрхийлнэ. Хуулиар 20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага бүр өмчийн хэлбэр үл харгалзан хөдөлмөрийн маргааныг таслах орон тооны бус, байнгын ажиллагаатай комисс байгуулан ажиллахаар үүрэг болгосон. Харин 15 ба түүнээс доош ажилтантай байгууллага сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах хороонд хандах боломжтой. Энэ нь талуудын хооронд үүссэн хөдөлмөрийн эрхийн маргааныг шийдвэрлэхэд цаг, зардлыг хэмнэх ач холбогдолтой гэж үзсэн ч хөрсөн дээр төдийлөн үр дүн харагдахгүй байгааг шүүхээр шийдвэрлэсэн маргааны тоон дүнгээс харагдана.

Хөдөлмөрийн тухай хуульд шинээр орсон ажлын цагийн зохицуулалт (уртын ээлжээр ажиллах, дуудлагаар ажиллах гэх мэт), ажилтны нийгмийн баталгаанд хамаарах хүүхэд асрах чөлөөний зохицуулалт зэрэг нь санхүүжилтийн эх үүсвэрийг зааж өгөөгүйгээс хэрэгжих боломжгүй зохицуулалт болжээ. Учир нь, ажилтанд хүүхэд асрах чөлөөг тэтгэмжтэй олгох үүргийг ажил олгогчид Хөдөлмөрийн тухай хуулиар бий болгосон ч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12, 15.1.3 дахь заалтуудтай уялдаагүйгээс хэрэгжих боломжгүй болоод байна.

³ УИХ-ын архив, Хөдөлмөрийн тухай хуулийн хувийн хэрэг, 2021

⁴ Монгол Улсын шүүхийн тайлан 2021, 244 дэх тал

⁵ https://drive.google.com/file/d/1J4tKAXBPUIJLvUQHlbc2O0_B4YPbD7doA/view

Хөдөлмөрийн тухай хуульд хэрэглэхэд хүндрэлтэй зохицуулалтууд цөөнгүй байгаа бөгөөд энэ нь ажил олгогч хэрэгжүүлэхэд санхүүгийн хувьд хийгээд зохион байгуулалтын хувьд хүндрэлтэй, нөгөө талаас ажилтны хууль ёсны эрх ашиг хөндөгдөх үр дагаврыг бий болгож байгааг анхаарах цаг болжээ.

III. НОМ ЗҮЙ:

Эрх зүйн эх сурвалж:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, УБ., 2011 <https://legalinfo.mn/mn/detail/253>
2. Нийгмийн даатгалын тухай хууль УБ., 1994 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=390>
3. НҮБ, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, 1948 <https://legalinfo.mn/mn/detail/1271>
4. Төрийн хэмнэлтийн тухай хууль УБ., 2022 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468624002961>
5. Хөдөлмөрийн тухай хууль, УБ., 2021 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751>
6. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал: “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам” <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389706300881>

Монгол эх сурвалж:

1. УИХ-ын архив, Хөдөлмөрийн тухай хуулийн хувийн хэрэг, УБ., 2021
2. Я.Бямбасүрэн, “Төрийн бодлого” УБ., 2020
3. Монгол Улсын шүүхийн тайлан, УБ., 2021
4. Н.Лүндэндорж, “Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага” УБ., 2009

Цахим эх сурвалж:

1. https://drive.google.com/file/d/1J4tKAXBPJLVUQHlbc2O0_B4YPbD7doA/view
2. <https://www.mongolchamber.mn/a/1286>

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН



ФЕРНАНДА ПИРИЕ., ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ¹

FERNANDA PIRIE., ORDER, DISPUTES, AND LEGAL PLURALISM, THE ANTHROPOLOGY OF LAW, 2013.

ЭРХ ЗҮЙН БОДОЛ: УТГА БА ЭРХ МЭДЭЛ

1960-аад онд улс төр судлаач Баркун хүн судлалын жишээн дээр үндэслэн угсаатны зүй, олон улсын эрх зүйн хэлбэрийг тогтвортой харьцуулж үзсэн. Тэрбээр хууль гэж юу болохыг тайлбарлахдаа энэ нь өөрийн субъектуудад ‘бодит байдлын онцлог дүр зургийг’ тулгадаг гэсэн санаа дээр үндэслэсэн; санаа нь үр дагавартай бөгөөд хууль биднээс ертөнцийг онцгой байдлаар харахыг шаардаж байна (1968:75-77). Тэрбээр хууль бол загвар, ‘дүрслэл, боловсронгуй, өндөр хөгжсөн метафорын хэлбэр’ хэмээжээ (1968:87); Баримт бичгийг эрх зүйн ангиллаар зохион байгуулж, утга учиртай болгодог бөгөөд ‘эрх зүйн ухагдахуунууд нь олон нийтийн бүтцийг тодорхойлдог хуулийн хамт олны ойлголт юм. Тэд харилцаа холбоо тогтоохыг зөвшөөрдөг. Дүрмүүд нь бодит байдлыг бүтээж болох нэг төрлийн бэлгэдлэл болж өгдөг (1968: 92).²

Хууль нь хүмүүс ба нийгмийн харилцааг дүрсэлж, төлөөлж болохуйц ангиллуудаар хангах замаар бэлгэдлийн чанартай ажиллах боломжтой. Эрх зүйн ангилал нь Английн хуулийн дагуу өмчлөх эрхээ чөлөөтэй эзэмших, түрээслэх, лиценз, сервитур эсвэл буцаах хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглах арга хэлбэрийг тодорхойлдог; тэд гэрээний харилцаа, эрүүдэн шүүх хариуцлагын тохиолдол, итгэлцлийн мөн чанар, гэмт хэрэг, компанийн хувийн шинж чанарыг тодорхойлдог. Хуульч бүхэнд ойлгомжтой, техникийн шинжтэй мэт санагдаж болох ч үр дагаврыг нь нийгэм, эрх зүйн судлаачид бүрэн авч үзээгүй байдаг. Хууль нь зан үйлийн дүрмээс хамаагүй илүү: хүн, эд хөрөнгө, бусад нийгмийн байгууллагуудын хоорондын харилцан үйлчлэлийг тодорхойлдог бүхэл бүтэн ангилал, харилцааг бий болгодог. Эдгээр нь бүгд хүмүүс ертөнцийн тухай бодох, дүрслэх, үнэлэх боломжтой ангилал, харилцаа байна. Гэмт хэргийн тодорхойлолт, асран хамгаалах үүрэг, итгэмжлэгдсэн харилцаа, бүтээлч итгэлцлийн талаарх санаа нь нийгмийн ёс суртахууны нэгэн хэлбэрийг илэрхийлдэг. Тэд хүмүүс бие биетэйгээ хэрхэн харьцаж, харилцах ёстойг зааж өгдөг. Хууль нь нийгэм ямар байж болох загвар тухай болж өгдөг.

¹ Монголын Криминологичдын холбооноос санаачлан Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Археологи, антропологийн тэнхим, Монголын Антропологийн холбоо нарын хамтран хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд “Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013” хэмээх номын орчуулгыг цувралаар хүргэж байна. Энэхүү номыг дараах холбоосоор орж үзнэ үү. https://books.google.mn/books?id=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false (Сүүлд үзсэн огноо: 2022.10.31)

² Түүний өргөн хүрээтэй төсөл нь асуудалтай боловч хуулийн бүтцийн харьцуулсан судалгааг санал болгодог (1968: 33).

Энэ бүлэгт би зарим үр дагаврыг нь тайлбарлаж, эрх мэдлийг өргөн хүрээний харилцааны элемент болгон хуулинд анхаарлаа хандуулдаг антропологичдын хандлагыг харьцуулж үзье.

ХУУЛИЙН АНГИЛАЛ БА ШҮҮХИЙН ҮЙЛ ЯВЦ

Хуулийг 'мэдлэгийн техник' гэж хүлээн зөвшөөрсөн олон тооны антропологичид хуулийн хэлний ач холбогдлыг ил, далд байдлаар задлан шинжилжээ. Шүүхийн үйл явцыг судлахдаа антропологичид болон бусад эрдэмтэд аль аль нь хууль тогтоомжийг батлахдаа энгийн баримтуудыг багтаах ёстой ангиллуудыг онцолж өгснөөр хууль зүйн хэллэгийн хүчин чадлыг онцлон тайлбарласан байна (Мерц 1994; Коутин ба Юнгвессон 2008).³ Тиймээс Конли ба О'Барр (1990) АНУ-ын доод шатны шүүхүүдийн хэрэглээг судлахдаа шүүхийн байгууллагууд хэрэг хянан шийдвэрлэх, түүнийхээ тухай мэдээлэх, хадгалахад хэрхэн шилж сонгодгийг тайлбарлажээ.

Энэхүү сонгон шалгаруулах үйл явцаар дамжуулан хуулийн байгууллагууд өөрсдийн судласан асуудал, түүндээ өгсөн хариултын аль алийг нь бүрдүүлдэг... Мэргэжлийн хууль зүйн хэллэг нь боловсруулаагүй өгөгдөл буюу өөрсдийн гол ажиллах материалыг, маргааны өдөр тутмын явцаас олж авдаг... Хэдий тийм ч хууль нь [шүүх хуралд оролцогчдын дуу хоолой] дотроос сонгож, заримынх нь дууг алгасаж, заримынхыг нь эрх зүйн ангилал, конвенцод нийцүүлэн өөрчилдөг. (1990:168)

Тэдгээрийн тайлбарлаж буйгаар, эрх зүйн үүднээс авч үзвэл, хууль нь бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн бүрэлдэхүүн хэсэг буюу практикт ажиллагсдын бодит дуу хоолойг хүлээн авдаггүй, харин тусдаа, ялгаатай, төвийг сахисан дуу хоолойг сонгодог гэсэн үг болж байна (1990:169). Үүнийг өөрсдийнх нь хийсэн кейс судалгаа баталдаг. Бордиу мөн адил Францын шүүхэд идэвхгүй, хувь хүнээс хөндий барилга байгууламж давамгайлж байгааг онцолж, хувь хүнээс хөндий, төвийг сахисан риторикийг бий болгож, хувь хүний өөрчлөлт хийх боломж багатай томьёог ашигласан (1987:820). Кларк (2012:108) орчин үеийн Ливан Улсад шүүх хуралдаан эхэлсний дараа нэхэмжлэл гаргагчидтай 'ах дүүгийн' харилцааны хэлбэртэй байснаа огцом өөрчлөгдөж 'хуурай', 'хатуу' хэлээр ярих болж, 'шүүгчийн хувиар хэлэлцдэг *шариатын* шүүгчийг дүрсэлжээ.

1980-аад онд АНУ-ын доод шатны шүүхэд нэхэмжлэгчдийн туршлагыг судалж байхдаа Мэрри дараах зүйлийг санал болгов:

Хууль зөвхөн дүрэм журам, шийтгэл ногдуулснаар бус, харин нийгмийн харилцаа, үйл ажиллагааны эрх мэдэлтэй дүрсийг бүтээх чадвараараа, мөн бэлгэдлийн хувьд хүчирхэг дүр төрхөөр дэлхийд үйлчилдэг. Хууль нь ертөнцийг тайлбарлах олон ангилал, хүрээг бүрдүүлдэг. (1990: 8-9)

Ерөнхийдөө хууль нь 'аливаа зүйлийг хийх боломжтой, санаанд багтамгүй, байгалийн болон соёлын арга замыг тодорхойлогч чадваруудыг хамарна'. Хууль зүйн хэллэг нь өмч, эрх, өөрийгөө болон эд хөрөнгөө хамгаалах, эрх,

³ Уран зохиол нь өргөн цар хүрээтэй бөгөөд онцлох судалгаа бөгөөд О'Барр (1982), Хирш (1998), Филипс (1998), Мерц (2007), Ричланд (2008) зэрэг болно.

баримт, үнэний тухай яриа юм. Эрх зүйн харилцааны талаарх ард түмний ойлголт нарийвчилсан, нарийвчлалтай биш ч байж болох боловч 'үнэн' -ийг тодорхойлохын тулд гэрээ, өмч, оновчтой хэлэлцүүлэгт үндэслэн шийдвэр гаргах, нотлох баримт танилцуулах гэсэн ойлголтуудыг агуулдаг (1990:112 дахь талаас).

Сонирхолтой нь тэрээр АНУ-ын доод шатнуудын шүүхэд нэхэмжлэгчид хууль тогтоомжид хандаж, асуудлаа хууль ёсны үүднээс тайлбарлахыг оролдож, үйл явдал, зан чанарын талаарх тайлбарыг хуулийн ангилал, арга хэрэгслийн хувьд хавсаргаж өгдөг болохыг судалж мэдсэн (1990:10). Шүүхийн албан тушаалтнуудыг нухацтай хандахад ятгах оролдлогуудыг эхнэр, нөхөр, амраг, хүүхдүүд, хөршүүд, гэрийн эзэдтэй холбоотой хувийн асуудлуудаа хууль бусаар 'дайрах', 'дарамтлах', 'гэрээг зөрчих', 'хичээл таслах' гэх мэт ангилалд оруулдаг (1990:13, 98). Хуульч, шүүхийн ажилтнууд, түүний дотор шүүгчид тэднийг хууль ёсны хэрэг үүсгэх, хөөцөлдөхөөс татгалзаж, эвлэрүүлэн зуучлах болон нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдахыг уриалж, гомдлоо илүү ерөнхий, ёс суртахуун, эмчилгээний хэлбэрээр боловсруулдаг. Тиймээс өсвөр насны хүүхэд нөхцөл байдлаас хамааран 'гэмт хэрэгтэн', 'хариуцлагагүй хүүхэд' эсвэл 'баашилж буй өсвөр насны хүүхэд' байж болно (1990: 130 дахь талаас).

Конли, О'Барр нарын (1990:168) тайлбарласнаар маргаан эрх зүйн тогтолцоонд нэвтэрч, 'хэрэг' нээгдсэнээр түүний илэрхийлэл өөрчлөгддөг. Хуульчид хэргийн оролцогчдын түүхийг сонсож, хэргийн аль хэсэгт эсвэл аль хэсгийг оруулахыг шийднэ. Өмгөөлөгчид үйлчлүүлэгчдийнхээ бүртгэлийг тухайн хэрэгт хамаарах эрх зүйн ангиллын шаардлага, түүнчлэн эрх зүйн маргааны ерөнхий журамд нийцүүлэн өөрчилдөг. Дээд шатны шүүхүүдэд ч гэсэн, Лондонд (мөн өөр бусад газарт ч гэсэн) өмгөөлөгчид эрх зүйн хэрэг нь тэдний үйлчлүүлэгчийн гол асуудал гэж үздэг зүйлийн гол цөм рүү ордоггүй гэдгийг сайн мэддэг.⁴ Энд ч мөн шүүгчид хэргийг шүүхээс гадуур шийдвэрлэхийг ятгаж, тэдгээрийг практик шийдэл рүү чиглүүлж, бүр зарим ааш муутай шүүгч хэргийг 'хэрүүл' гэж гутаах үе байдаг нь нууц биш юм. Гэлээ гэхдээ хуулийн маргаан нь үйлчлүүлэгч өөр этгээдээс стратегийн давуу тал олж авахыг эрэлхийлж буй арилжааны чиг баримжаа бүхий маневруудын нэг хэсэг байж болох бөгөөд түүний стратегийг өмгөөлөгч өөрөө мэддэггүй байж болно. Хууль нь үйлчлүүлэгчдийн ертөнцийн арилжааны болон ёс суртахууны бодит байдалтай зөвхөн хэсэгчлэн холбоотой байхтусгай хэл, аргументын багцыг бүрдүүлдэг.

Хууль зүйн социологич Рожер Коттерреллын хэлснээр 'хууль нь нийгмийн амьдралыг бүрдүүлдэг эсвэл тодорхойлдог үндсэн ангилал (өмч, өмчлөх эрх, гэрээ, итгэлцэл, хариуцлага, гэм буруу, зан чанар гэх мэт) -д нөлөөлж нийгмийн амьдралыг бүрдүүлдэг' (1998:177). Асуудлыг өвөрмөц байдлаар зохицуулдаг нь зөвхөн хууль биш ээ: Матерер, Юнгвессон (1980/81) нар онцлон тэмдэглэсэнчлэн эвлэрүүлэн зуучлах явцад аливаа үйл явдлыг шийдвэрлэхэд тохиромжтой байдлаар зохион байгуулдаг тул асуудлыг өөрчлөх боломжтойболно. Асуудлыг танилцуулах, өөрчлөх олон арга зам байдаг боловч тэдгээрийн дунд хууль ёсны

⁴ Энд Лондонгийн баарын холбоонд канцлерын өмгөөлөгчийн хувиар ажиллаж байсан хуулийн туршлагаасаа ашигласан болно.

хүрээ нь онц ялгаатай байдаг. Крис Фуллер (1994:11) хэлснээр 'бүх шүүхийн үйл явц их, бага хэмжээгээр өвөрмөц бөгөөд ихэвчлэн хүчирхэг өөрийгөө баталгаажуулдаг сэтгэлгээний тогтолцоогоор тодорхойлогддог бөгөөд түүний анализ, тайлбар нь эрх зүйн антропологийн төв байх ёстой' хэмээсэн. Барууны эрх зүйн тогтолцоонд энэ өвөрмөц зүйл биш ээ. Исламын ертөнцөд Пауэрс (2002:165) 1400 оны орчим Фез хотод болсон өмчийн маргааныг тайлбарлахдаа: 'Энэ хэргийг шударга ёсны аппаратаар дамжуулж, нийгэм эдийн засаг, сэтгэл хөдлөлийн үндэс нь хууль ба хэл хоорондын харилцааны тухай бичвэрийн шинжилгээний асуудал болж хувирсан.

Хэрэв энэхүү өвөрмөц бөгөөд ихээхэн өөрчлөгдөж байдаг эрх зүйн чадамжийг ойлгохгүй бол бусад нийгмийн хэлбэр, ангилалтай холбогдох хуулиудыг шүүмжлэхэд хүргэж болзошгүй юм. Де Соуса Сантос (1987) хуулийг газрын зураг гэж алдаршуулсан боловч гаргасан 'бодит байдлын гажуудал', 'нутаг дэвсгэрийн талаарх буруу уншлагыг' онцолсон байдаг. Поттэж ба Мунди (2004:2)-ийн онцлон тэмдэглэснээр эрх зүйн дүрмүүд нь хүн ба эд зүйлсийн ялгааг багтаасан байгалийн болон нийгмийн баримттай нийцдэг гэсэн онолгүй таамаглал нь эрх зүйн хязгаарлалтын талаарх антропологийн олон тооны шүүмжлэлийг үндэс болгодог. Хуулийн ангиллын өөрчлөлтийн хүчийг үнэлэхийн тулд бид зөвхөн оюуны өмчийн талаар бодох хэрэгтэй болно: патентын зохицуулалтын хүрээг бүрдүүлж, 'эзэмшигч'-ийг бусдын ашиглалтыг хязгаарлах, ашиглахыг зөвшөөрснөөр хууль урьд өмнө байгаагүй өмчийг үр дүнтэй бий болгодог.

ХУУЛЬ УТГА САНААНЫ ТОГТОЛЦОО БОЛОХЫН ХУВЬД

Тиймээс хууль шийдвэр гаргахад илүү дасан зохицохын тулд асуудлыг дахин боловсруулж болох дүрэм, ангиллыг бий болгодог. Энэ нь шүүхийн танхимын гадна шинэ (хууль ёсны) харилцаа үүсгэж болно. Эрх зүйн ангилал нь ертөнцийг удирдахаас гадна ойлгох хэрэгслээр хангадаг. Антропологич Клиффорд Герц (Баримт ба хууль нь харьцуулсан үүднээс авч үзэх чухал баримт бичигт) 1983 онд хуулийг судлахад 'тайлбарлах' эсвэл 'герменевт' хандлагыг нэвтрүүлэхийг дэмжиж байна. Түүний хэлснээр хууль нь баримтад ногдуулж болох боловч тэдгээрийг төлөөлж болох ангилал, дүрмийг өгдөг. Энэхүү харилцааны асуудалтай байж болзошгүй шинж чанарыг эртний грекчүүд эрт дээр үеэс хүлээн зөвшөөрсөн гэж тэрээр хэлэхдээ, тэдний 'байгаль ба уламжлалыг эрс эсэргүүцсэн' (1983:171).⁵ Тодорхой баримтуудад ('хэрэв -тэгвэл' дүрмийг) ерөнхий дүрмийг ашигласны үр дүнд ('шиг-тийм учраас') шийдвэр гаргадаг: нийтлэг хуулийн системд шүүхийн даалгавар бол юуны түрүүнд дараа нь хуулийг хэрэгжүүлэхийн тулд юу байх ёстой, шүүхийн шийдвэрт хүрэхийн тулд юу байх ёстой баримтуудыг олж тогтоох явдал юм. Шүүхийн үйл явц ба 'хуулийн байгууллагууд нь төсөөллийн хэл ба шийдвэрийн хооронд шилжиж, улмаар шударга ёсны тодорхой мэдрэмжийг бий болгодог'. Үүнийг тэрээр 'хууль ёсны мэдрэмж' гэж нэрлэдэг (1983:174-75).

Энэхүү загварыг санал болгож буй баримт ба норм хоёрын хоорондох ялгаа нь хэтэрхий хурц боловч Герцийн үзэж байгаагаар 'баримтын хууль ёсны төлөөлөл

⁵ Хүний ертөнц болох физи, байгалийн ертөнц ба номосуудын хоорондох энэхүү эсэргүүцэл нь хууль зүйн сэтгэлгээний дараагийн түүхэнд чухал нөлөө үзүүлсэн (Келли 1990).

эхнээсээ норматив байдаг’ (1983:174). Хууль бол баримтыг илэрхийлэх, улмаар мэдэгдэж, утга учир олж авах аргуудын нэг юм. Хууль нь төлөөллийн өргөн хүрээний асуудлын жишээг өгдөг бөгөөд үүнийг шинжлэх ухаан, урлаг, шашин шүтлэг, ёс зүй, үзэл суртал, түүх болон бусад утга учрыг бий болгох оюуны дасгалуудаар авч үздэг. Манай сошиал ертөнц нь хүмүүс, бүлгүүдийг бүү хэл утга учиртай баримт, үйл явдлыг хангаж өгдөг бөгөөд үүнийг бид ойлгож, хэрхэн яаж ажиллахаа шийддэг схемүүдээр дүүрэн байдаг. Тиймээс Герцийн мартагдашгүй хэллэгүүдийн нэгийг ашиглахын тулд хууль бол ‘бодит байдлыг төсөөлөх арга хэлбэрийн нэг хэсэг’ юм (1983:173). Түүний нотолгоо бол хуулийг утга санааны систем болгон судалж үзэх ёстой; эрх зүйн тогтолцооны гол цөм болох ойлголт, санаа, түүний ‘хууль ёсны мэдрэмж’ дээр анхаарлаа төвлөрүүлэх нь оролцогчдын нийгмийн ертөнц, соёлын талаар бидэнд ихийг хэлэх болно. Үүнийг хийхдээ Инди, Ислам, Индонезийн ертөнцийн эрх зүйн гол үзэл баримтлал болох *дарма*, *хакк*, *адат* -ын жишээг хувийн кэйс судалгаандаа ашигласан байдаг.

Герц нь зөвхөн нийгмийн нийтлэг хэм хэмжээг тусгахын тулд утга агуулгыг бий болгох эрх зүйн чадварыг баталдаг. Энэ бол:

Тодорхой газар (болж буй, бүтэлгүйтэж болох, байж болох зүйлүүд) -т онцгой ач холбогдол өгч, эдгээр эрхэмсэг, аймшигтай, эсвэл зүгээр л зохистой хэрэгслүүд нь тодорхой хэлбэртэй болж, тодорхой нөлөө үзүүлдэг. Товчхондоо машин биш гэсэн үг. (1983:232)

Эсвэл илүү баттай хэлэхэд, ёс суртахууны хувьд (эсвэл ёс суртахуунгүй) төгссөн нийгэмд техникийн нэмэлт зүйл гэхээсээ илүүтэйгээр хууль нь түүний идэвхтэй хэсэг юм; Хууль нь ‘олон нийтийн цуурай бус алсын хараа’ (1983: 218) -гаар хангадаг. Ийм байдлаар Герц миний бодлоор хуулиудыг нийгмийн нийтлэг хэм хэмжээг төлөөлж эсвэл гаргаж ирсэн гэж үздэг хүмүүсийн эсрэг хуулийн талаарх үзэл бодлоо илэрхийлдэг. Нормуудыг хуваалцахдаа тэдгээрийг хууль болгон ил тод болгох шаардлагагүй. Жишээлбэл Ладакийн алслагдсан тосгонуудаас олж мэдсэнээр, бүх хөдөө аж ахуйгаас хамааралтай байсан усалгааны систем нь асуулт тавихад хэтэрхий чухал байсан (Пири 2007б). Хүмүүс надад юу хийснээ, усны эргэлтийн тогтолцоо хэрхэн ажилладаг талаар хэлж өгч болох байсан ч үүнийг хууль дүрмээр бичих шаардлагагүй байсан. Нөгөө талаар тэдний ёс заншлыг гэр бүлийн гишүүдийн өмч хөрөнгийг хуваахаас эхлээд баяр ёслолоо зохион байгуулах арга зам хүртэлх үзэл бодлын зөрүүтэй байх ёстой. Нийгмийн бүтэц, ‘манай ёс заншил’ -ын тодорхой илэрхийлэл нь тосгоны стандартыг бий болгосон. Энэ тохиолдолд ёс заншилтай адил хууль бол нийтлэг хэм хэмжээний тусгалаас илүү зүйл юм.

Миний өмнө өөр газар тэмдэглэж, хэлэлцсэнчлэн (2010:219) Герцийн хандлага нь дэлхий ертөнцийг утга учиртай бусад нийгмийн хэлбэрүүдээс ялгаж салгаж өгдөг зүйл биш юм. Герц өөрөө шашин, урлаг, үзэл суртал, шинжлэх ухаан, түүх, ёс зүй, нийтлэг ойлголтыг дурддаг (1983:230). Түүний хандлага нь эрх зүйн хэлбэр гэж ойлгож болох зүйлийг ойлгоход бидэнд тийм ч их ач холбогдол өгдөггүй.⁶

⁶ Герц өөрөө ‘хууль’ гэсэн шошгыг хэрхэн яаж ашиглах талаар хоёрдмол утгатай байдаг: ‘шүүхийн шийдвэрийн хэв маягийг [кейс судалгаанд хэлэлцсэн] ...’ хууль ‘гэж нэрлэх нь зохистой эсэхээс үл

Робертсын (2005:8) шүүмжилж хэлснээр 'хууль нь сансар судлал, бэлгэдэл зүйд алдагдах болно'. Гэвч тэрээр хууль хэрхэн утга учрыг бусад схемээс ялгаж салгах талаар санаа зовдоггүй ч Герц хууль болон хуульч сэтгэлгээний хувьд юугаараа онцлог болохыг тайлбарладаг. Түүний хэлснээр, хууль 'дэлхий ертөнцийг болон тэнд болж буй үйл явдлыг тодорхой шүүмжлэлийн үүднээс дүрсэлдэг'; болон хууль зүйн техник бол 'тайлбарыг зөв болгохын тулд зохион байгуулалттай оролдлого хийх явдал юм' (1983:174). Тэрээр эдгээр санааг Бали тосгонд хууль ёсны зохион байгуулалтын тод жишээгээр харуулсан бөгөөд тэнд тосгоны ажлыг зохицуулах дүрмийг далдуу модны навч дээр нарийн бичсэн байв. Тэрээр нэг хүний орон нутгийн зөвлөлийн тэргүүний хувиар ээлжинд гарахаас татгалзсан нь аймшигтай үр дагаварт хүргэж, газар нутаг, нийгмийн байдал, улс төр, шашны эрхээ алдаж, улмаар хөөгдсөн хүн болж хувирсан тохиолдлыг тайлбарлав. Энэ нь тосгоны зөвлөлийн зүгээс энэ асуудалд ямар ч эрх мэдэлтэй гэж тооцогдоогүй бусад олон асуудлаар өргөмжлөгдсөн хааны оролцоотой байсан ч тосгоны дүрэм журам, хүний халдварын үр дагаврыг хэлэлцэх боломжгүй байв. Герц энэ түүхийг эргэцүүлэн бодож, 'бүх хэргийг бүхэлд нь хамарсан мэт санагдаж байна. Энэ ертөнцийн юмс, тэдгээрийн дундах хүн төрөлхтнийг ангилж, зарим нь шаталсан, зарим нь хоорондоо уялдуулан зохицуулсан, гэхдээ бүх зүйл тодорхой бөгөөд ангиллаас гадуурх асуудал нь бүхэл бүтэн бүтцийг алдагдуулдаг, учраас засах юмуу устгах шаардлагатай гэсэн ерөнхий үзэл юм.' (1983:180).

Тосгоны оршин суугчид эрх мэдлийн салбарыг ангилах, бурууг олон нийтийн ёс зүйн нэг гэж тодорхойлох тухай дүрэм, ангилалтай байсан; Тухайн хэргийн бодит байдлаас гадна тэд гамшигт үр дагаварт хүргэх эрх мэдэлтэй байв. Тосгоны иргэд хууль ёсны ангилал, дүрмийг ашигладаг байсан бөгөөд үүнийг хүндэтгэх ёстой бөгөөд эрх мэдэл нь хааны эрх мэдлээс давсан байв. Чухам энэ хууль ёсны байдал буюу Герц 'хууль зүйн техник' гэж нэрлэдэг нь тосгоны хуулиудад хүч өгч, эцсийн дүгнэлт гаргахад ашиглах боломжийг олгосон юм.

Эрх зүйн онол дахь утга

Хуулийн дүрслэлийн хүч эрх зүйн онолчдын анхаарлаас хэлтрээгүй. Тэдний зарим бичвэр сайтар танигдсан боловч антропологичдын хийсэн ажлын талаар бараг сайжруулдаггүй. Жишээлбэл, хуульч эрдэмтэн Роберт Ковер (1983/84) эрх зүйн дүрмийг бидний 'норматив орчлон ертөнц' -ийн нэг хэсэг, зөв буруугийн ертөнц гэж үздэг. Түүний хэлснээр хууль бол бусад хэм хэмжээний нэгэн адил тодорхой төрлийн үйл ажиллагааг явуулах боломжийг олгодог 'утга учиртай эх сурвалж' юм. Тиймээс, ариун ёслол, найр, татварыг тогтоодог шашны болон санхүүгийн дүрэм журам, түүнтэй холбоотой зан үйлийн хэм хэмжээг дагаж мөрдвөл бид зөвхөн ариун ёслолоос татгалзах, шашны баярыг гутаах, татвар төлөх боломжтой болно. Түүгээр ч зогсохгүй үүнийг хийх боломжтой утга учиртай үйл ажиллагаа нь дуулгавартай байдал эсвэл татгалзах энгийн үйлдлүүдээс хамаагүй илүү юм: хуулиуд нь бусад хэм хэмжээний нэгэн адил бидэнд захирагдах, баярлах, тэмцэх,

хамааран. . . бага ач холбогдолтой; Хэдийгээр би өөрөө үүнийг хийхийг хүсэж байна. Хамгийн гол нь тэдний уран сэтгэмжийн хүчийг халхлахгүй байх явдал юм '(1983: 215). Хуулийн мөн чанар, онцлог шинж чанарыг бусад утга санааны схемээс хатуу авч үзэх нь түүний төсөлд тийм ч чухал биш нь ойлгомжтой.

гажуудуулах, дооглох, гутаах, доромжлох, нэр төрөө илэрхийлэх, эсэргүүцэх, дагаж мөрдөх боломжийг олгодог. Мэдээжийн хэрэг, эдгээр цэгүүд нь зөвхөн эрх зүйн төдийгүй бүх төрлийн хэм хэмжээнд хамааралтай боловч хууль тогтоомж, хэм хэмжээгээр олгогдсон үйл ажиллагааны боломжуудын дунд зарчимгүй, үл хүндэтгэсэн, инээдтэй байдлаар удирдах боломжийг бидэнд олгодог гэдгийг сануулах нь зүйтэй юм. Дуулгавартай эсвэл дуулгаваргүй амьдрал шиг хуулийн төсөөллийн чанар, нийгмийн хэлбэрүүдийн тайлбарлагдаж буй мөн чанарыг Герц онцлон тэмдэглэв: 'Бид өөрсдийн норматив ертөнцөд бий болгодог мэдрэмж', 'Бидэнд тавигдах шаардлагын хэв маягийг зааж өгөхдөө дуусаагүй байна' (1983/84:8).⁷

Хуулийн утга санааны систем болох өөр хандлагыг хууль судлаачид Никлас Лухманн, Гюнтер Тюбнер нар баримталдаг. Лухманн бол хууль бол харилцааны систем бөгөөд харилцааны тусламжтайгаар хэлбэр (өгүүлбэр) -ийг утга агуулгын хүрээнд багтаахыг шаарддаг (2004:70-74). Бид үүнийг 'үйл ажиллагаагаа хаах'-аар тодорхойлогддог, биеэ даасан, өөрийгөө ялгах систем гэж үзэх ёстой. энэ нь бодит ертөнцөд шууд зураглаагүй өөрийн гэсэн утга, тодорхойлолтыг бий болгодог. Гийрц, Коверын нэгэн адил Лухманн нь эрх зүйн утга учир, функцийг бий болгох чадварыг онцлон тэмдэглэв. Энэ нь норматив хүлээлтийг тогтворжуулах явдал юм.

